



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-107
1.Монгол Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал	13-60
2.Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх тухай асуудал	60-93
3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	93-94
4.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2025.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	94-95
5.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	95-100
6.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	100-107

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 17-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батбаатар, Да.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Цэнгүүн;

Тасалсан: О.Амгаланбаатар, Ч.Анар, Ж.Батсуурь, Х.Болормаа, Т.Доржханд, С.Замира, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа;

Хоцорсон: Н.Алтанхуяг-06 минут, Т.Аубакир-25 минут, М.Бадамсүрэн-08 минут, Э.Бат-Амгалан-09 минут, Д.Батлут-05 минут, Н.Батсүмбэрэл-1 цаг 54 минут, Б.Батцэцэг-03 минут, П.Батчимэг-51 минут, Э.Батшугар-01 минут, Б.Бат-Эрдэнэ-28 минут, Ж.Баярмаа-13 минут, Д.Бум-Очир-01 минут, С.Бямбацогт-03 минут, Ж.Галбадрах-09 минут, Г.Ганбаатар-38 минут, Х.Ганхуяг-01 минут, Б.Дэлгэрсайхан-06 минут, Б.Жавхлан-42 минут, Х.Жангабыл-31 минут, Б.Заяабал-05 минут, Ж.Золжаргал-17 минут, С.Лүндэг-2 цаг 06 минут, Т.Мөнхсайхан-05 минут, З.Мэндсайхан-1 цаг 09 минут, Н.Наранбаатар-03 минут, С.Одонтуяа-2 цаг 07 минут, У.Отгонбаяр-04 минут, Л.Соронзонболд-01 минут, Р.Сэддорж-2 цаг 37 минут, Н.Учрал-08 минут, Б.Хэрлэн-05 минут, Б.Чойжилсүрэн-2 цаг 07 минут, Л.Энх-Амгалан-05 минут, Б.Энхбаяр-2 цаг 13 минут, Ж.Энхбаяр-02 минут, Д.Энхтуяа-53 минут, Д.Энхтүвшин-03 минут, Р.Эрдэнэбүрэн-2 цаг 45 минут.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хуралдааны ирцтэй холбогдуулан тайлбар хийв.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, О.Саранчулуун, Б.Уянга, Э.Болормаа, М.Мандхай, О.Батнайрамдал, Б.Тулга, Г.Тэмүүлэн, Д.Ганмаа, Г.Лувсанжамц, М.Энхцэцэг, Х.Баасанжаргал, Н.Алтаншагай, Ч.Лодойсамбуу, Б.Пүрэвдорж, Л.Мөнхбаясгалан, Р.Батболд, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар үг хэлэв.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай холбогдуулан тайлбар хийв.

Х.Булгантуяа: Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг дэмжээгүй, Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 71

Бүгд: 111

36.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

“Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

“Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, С.Бямбацогт нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:58/

Уг асуудлыг 12 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 48 минут үргэлжилж, 13 цаг 00 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 14 цаг 02 минутаас 14 цаг 28 минутад хуралдааныг удирдав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт Ц.Болормаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл үг хэлж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж зөвөлгөө өгөв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 28 минутаас 15 цаг 58 минутад хуралдааныг удирдав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Д.Жаргалсайхан, Д.Ганбат, Ч.Ундрэм, Л.Соронзонболд, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, Г.Ганбаатар, Ч.Лодойсамбуу, А.Ариунзаяа, Л.Мөнхбаясгалан, Б.Бейсен, Д.Үүрийнтуяа, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалангийн чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 102

Татгалзсан: 12

Бүгд: 114

89.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж “Д.Амарбаясгаланг Монгол Улсын Их Хурлын даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

“Д.Амарбаясгаланг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:49/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж үг хэлэв.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 15 цаг 59 минутаас 16 цаг 50 минутад хуралдааныг удирдав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Уг асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын дэмжээгүй санал:

Х.Булгантуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31,6 их наяд төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32 их наяд 980 тэрбум төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах ДНБ-д эзлэх хувьд өөрчлөлт оруулах гэсэн Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 64

Бүгд: 114

43.9 хувийн саналаар Байнгын хороодын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 69

Бүгд: 114

39.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. *“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2025.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Уг асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Х.Булгантуяа: “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 42

Бүгд: 114

63.2 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Тав. *Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026

оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Х.Булгантуяа: 1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	72
Татгалзсан:	42
Бүгд:	114

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах

зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Н.Учрал, хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын тавьсан асуултад Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./16:49/

Уг асуудлыг 16 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 36 минут үргэлжилж, 126 гишүүнээс 115 гишүүн хүрэлцэн ирж, 91.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 12 минут**

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе.

10.00 цаг болж 2025 оны 10 сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Үндсэн хуулийн зүйл, заалттай асуудлыг өчигдрөөс хэлэлцэж эхэлсэн. Хэлэлцэж эхлэхээр ирц өнөөдрийг болтол 61 гишүүнтэй байна.

Үндсэн хуулийн тухайн асуудлыг хэлэлцэх зүйл, заалт нь 3 хоногийн дараагаар хэлэлцэж эхэлж, 10 хоногийн дотор хэлэлцэн батлах ёстой байгаа Улсын Их Хурал. Бид 3 хоногийн дараагаар Төрийн байгуулалтын байнгын хороо орж, хэлэлцүүлгийг хууль, ном журмын дагуу хэлэлцэж эхэлсэн. 10 хоногийн дотор буюу өнөөдөр 1 цаг хагас гэхэд Улсын Их Хурал үүнийг хэлэлцэн баталж, шийдвэрээ гаргасан байх ёстой.

Тиймээс өнөөдөр Улсын Их Хурлын гишүүдээ цаг нартай Үндсэн хуулийн асуудлаа цагтаа бүгдээрээ хэлэлцэж дуусгая гэдэг, чуулганыхаа ирцэд орно уу гэж хүсэж байна.

Өнөөдөр чуулганыхаа ирцэд орсон байгаа гишүүдийг танилцуулъя.

Жуковын Алдаржавхлан, Оюунсайханы Алтангэрэл, Наранцэцэгийн Алтаншагай, Дашзэгвийн Амарбаясгалан, Сайнбуянгийн Амарсайхан, Аюушийн Ариунзаяа, Хүрэлбаатарын Баасанжаргал, Жадамбын Бат-Эрдэнэ, Далайн Батбаяр, Отгоншарын Батнайрамдал, Халтмаагийн Баттулга, Баярмагнайн Баярбаатар, Жадамбаагийн Баясгалан, Буланы Бейсен, Энхбатын Болормаа, Хүрэлбаатарын Булгантуяа, Шинэбаярын Бямбасүрэн, Жамбалын Ганбаатар, Сайнхүүгийн Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Даваасамбуугийн Ганмаа, Лувсаннямын Гантөмөр, Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэрэнпилийн Даваасүрэн, Батбаярын Жаргалан, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Лхагвын Мөнхбаатар, Цагаанхүүгийн Мөнхбат, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Баатаржавын Мөнхсоёл, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Бадрахын Найдалаа, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Чинбатын Номин, Одсүрэнгийн Номинчимэг, Нямтайширын Номтойбаяр, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Даваахүүгийн Пүрэвдаваа, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Цэвэгдоржийн Туваан, Буяагийн Тулга, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Ганзоригийн Тэмүүлэн, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Гончигдоржийн Уянгахишиг, Одонгийн Цогтгэрэл, Лутаагийн Энхнасан, Мөнхчулууны Энхцэцэг, Сүхбаатарын Эрдэнэбат, Сүхбаатарын

Эрдэнэболд гэсэн гишүүд чуулганыхаа ирцдээ бүртгүүлээд Үндсэн хуулийн цагтай, нарийвчилсан заалттай энэ асуудлаа хэлэлцэж дуусгая гээд хүрэлцэн ирсэн байна. Ирцдээ орсон байна.

Өчигдөр өглөөнөөс авхуулаад асуудлаа хэлэлцэх гээд дараа дараачийнхаа олон асуудлыг хэлэлцэх гээд хүлээгдэж байгаа. Улсын Их Хурлын гишүүд зарим нь шөнөжин, өдөржин л энэ чуулганы танхимд хүлээж байх шиг байна. Сайд нарын томилгоог хийхэд яг ингээд үүр цайгаад өглөө болоход сайд нарын томилгоо хийгдэж дуусаж байсан. Хорин хэдэн цаг хуралдаад.

Дээрээс нь нэмээд дахиад өмнөх сайд нар нь яаман дээрээ очоод тамгаа хүлээлгэж өгөөд ингээд нийтдээ 30 цаг орчим зарим хүмүүс тухайн үед яг нойр, хоолгүй ажиллаж байсан. Одоо иргэдийн зүгээс өөрсдийнхөө томилгооны асуудлыг ярих болохоороо шөнөжин, өдөржин хуралдаад, үүрэг хариуцлагын асуудал ярих болохоороо ингээд хойшоо суугаад байна гэж хүртэл шүүмжилж байна. Та бүхэн маань өөрсдөө үүн дээрээ үнэлэлт, дүгнэлт өгнө биз. Би өмнө бас хэвлэл мэдээллийнхэнд үүрээр бас мэдээлэл өгсөн. Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна. Чуулганд орж ирэхгүй ээ гэж манай олон гишүүд өрөөнөөсөө LIVE-даж пост оруулсан байна лээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1-ийг 2019 оны оны 11 сарын 14-нд баталсан. Шинэчлэн найруулсан. Ингэхэд Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавивал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн, 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол “Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно гээд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ойлгохгүй байна гэж зарим хүмүүс яриад байх шиг байна.

Энэ зүйл, заалт дээр гол нь юу орсон бэ гэхээр хуучин ердийн олонхоос санал хураалт явуулаад, өөрөөр хэлбэл 76 гишүүнээс 39 нь хүрэлцэж ирээд 20 гишүүн дэмжсэн санал гарах юм бол Засгийн газар огцрохоор байгаад байсан. Үүнийг Засгийн газрыг илүү их тогтвортой ажиллуулах үүднээс нийт гишүүдийн буюу 76 гишүүнээс 39 нь дэмжих юм бол гэдэг ийм томьёоллоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Энэ хүрээнд 2020 оны Улсын Их Хурлын парламентын Дэгийн хууль дээр Улсын Их Хурлын нийт гишүүний олонх 99.4 дээр тухайн үед байсан Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх Ерөнхий сайдыг огцруулах саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоол баталсанд тооцно гэж. Энэ нь өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101.4-д Улсын Их Хурлын нийт гишүүний олонх Ерөнхий сайдыг огцруулах саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоол баталсанд тооцно гэж оруулсан. Мөн үүнтэй адилхан 99.3 нь хуучин дэгийн, 2020 оны дэгийн нэгдсэн хуралдааны Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулна.

Өнөөдөр энэ шинэ дэгийн, 126 гишүүнтэй шинэ дэгийн 101.3 байгаа. Нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулна гээд ингээд үг, үсэггүй адилхан байгаа юм. Тухайн үед хүмүүс үгүй ээ энэ 2021 онд Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан Ухнаагийн Хүрэлсүх

өөрийнхөө өргөдлийг өгч огцрох өргөдлөө өөрөө өгсөн. Тэгэхээр үүнийг хэрэглээгүй шүү дээ гэж яриад байх шиг байна. Та бүхэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг унших юм бол Үндсэн хууль дээр ч гэсэн өөрөө өргөдлөө өгвөл гэдэг тусгайлан зохицуулалт байдаггүй.

Тийм учраас тухайн үед Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх 101-тэйгээр, 101-ийн, 101 дүгээр зүйлийг ашиглахаар Байнгын хороодоор санал хураалт, Байнгын хороогоор, Төрийн байгуулалтын байнгын хороогоор санал хураалт явуулж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр Төрийн байгуулалтын байнгын хорооны саналын томьёоллоор санал хураалтыг явуулсан байдаг.

Ерөнхий сайдтай холбоотой 99 дүгээр зүйл Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэх байдаг. 100 дугаар зүйл Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх байдаг. Үүн дээр бол Ерөнхий сайд эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан бол Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 7 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргана.

100.2 нэгдсэн хуралдаан энэ хуулийн 100.1-д заасан хүсэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөгдөх хүсэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай тогтоол баталсанд тооцно. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдаас чөлөөлөгдөх шалтгаан, үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж болно гэж 100 дугаар зүйл дээр туссан.

101 дүгээр зүйл дээр Ерөнхий сайдыг огцруулах асуудал Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын хувьд 102 дээр Ерөнхий сайдад тодорхой асуудлаар итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх гэж тусгайлан зүйлээр санал хураалтыг явуулсан.

Гишүүд ээ, чуулганы ирц 51.6 хувьтай. 65 гишүүн, 66 гишүүн ирцдээ орж чуулганы хуралдаан эхлэхэд бэлэн болоод байна.

Та бүхэн танхимдаа орж ирнэ үү.

Өнөөдрийн чуулганы ирц бүрдүүлэлттэй холбоотой зарим гишүүд Улсын Их Хурлын гишүүдийн групп дээр бичээд байна. Үүн дээр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж дарга.

Улсын Их Хурлын нийт гишүүд 126 гишүүнээс 66 гишүүн ирж, 52.4 хувиар ирц бүрдээд байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны ирцтэй холбоотой хэд хэдэн гишүүд асуулт асууж байна. Дахин ирц үүсэх ёстой юу, үгүй юу гэдэг асуудлаар. Үүн дээр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж дарга тайлбар өгнө үү? 1 номерын микрофон.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын дэд дарга болон Улсын Их Хурлын гишүүддээ 10 дугаар сарын 16 болон 17-ны өдрийн мэндийг хүргэе.

Манай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр 6 дугаар зүйл хуралдааны тов, дараалал тогтооход баримтлах журам гэж зүйл байгаа. Энэ зүйлийн 6.2-т нэгдсэн хуралдаан долоо хоног бүрийн Пүрэв, Баасан гарагт хуралдана. 10 цаг 00 минутаас хуралдаан эхэлнэ ээ гэж заасан байгаа. Ингэж 10 цаг 00 минутаас эхлэхдээ гишүүд өглөө 09.00 цагаас эхлэн ирцэд бүртгүүлж хуралдаанаар асуудал хэлэлцэхэд бэлтгэнэ гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл... /минут дуусав/

Х.Булгантуяа: 1 номерын микрофоныг нэмж өгье. Гүйцэд хариулъя.

Б.Баасандорж: Өөрөөр хэлбэл 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Пүрэв гаргийн чуулганы нэгдсэн хуралдаанд бэлтгэх ирц 09.00 цагт эхэлж, хуралдаанаар асуудал хэлэлцэхэд бэлтгэсэн. Одоо энэ 09.00 цагт эхэлсэн бүртгэл маань сая 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 13 минутад ирц бүрдлээ.

Тэгэхээр энэ бол чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай ямар нэгэн зөрчилдсөн зүйл байхгүй.

Х.Булгантуяа: Өнөөдрийн чуулганаар нийтдээ 6 асуудал хэлэлцэхээр байгаа.

Нэгдүгээр хэлэлцэх асуудал бол Үндсэн хуулийн хэлэлцэн дуусах цаг хугацаатай асуудал. 3 хоногийн дараагаар хэлэлцэн эхэлж, 10 хоногийн дотор хэлэлцэн батлахаар байгаа. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэх асуудал нэгдүгээрт.

Хоёрт, Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал гээд ингээд төсөвтэй холбоотой нийтдээ 6 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга 2025 оны намрын ээлжит чуулганы хуралдааны 10 сарын 16-ны өдрийн ирцтэйгээр үргэлжлүүлэн хуралдахад асуудал байхгүй гэсэн тул өнөөдөр нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 6 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Дөрөвдүгээрт, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Тавдугаарт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал

Нэгдүгээр асуудалдаа оръё. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэж эхэлье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн. Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

А.Ариунзаяа: Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын нэр бүхий 54 гишүүн Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг саналыг Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 3 хоногийн дараа буюу 2025 оны 10 дугаар сарын 10, 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийг баримтлан хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулсан бөгөөд уг саналдаа

Нэг.Монгол Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр томилж, чөлөөлж, огцруулна гэж заасан.

Гэтэл Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд мэдэгдэл хийхдээ өөрийн онцгой бүрэн эрхийнхээ дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдаар нэр бүхий гишүүнийг

томиллоо гэж албан ёсоор мэдэгдэн Засгийн газрын болон өөрийн албан ёсны цахим хуудаснаа уг мэдээллийг нийтэлсэн.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг шийдвэрлэхээс өмнө Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгч танилцах бүрэн эрхтэй байна. Нөгөө талаар томилох, чөлөөлөх, огцруулах шийдвэр гаргахаасаа өмнө Улсын Их Хуралд болон Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулах үүргийг Үндсэн хуулиар Монгол Улсын Ерөнхий сайдад хүлээлгэсэн. Үндсэн хууль, аливаа хуулийн үг, өгүүлбэр төдийгүй цэг, таслал нь хүртэл утгын нарийн уялдаатай, Үндсэн хуулийг жижгээр зөрчих, томоор зөрчих гэдэг ойлголт байдаггүй бөгөөд бүгд Үндсэн хуулийн зөрчилд хамаардаг.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн 70 дугаар зүйлд Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасныг Монгол Улсын Ерөнхий сайд баримталж ажиллах ёстой.

Гэтэл Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид Хууль зүй, дотоод хэргийн сайдыг огцруулах, шинээр томилох асуудлыг танилцуулаагүй байхдаа ийнхүү Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томиллоо гэж олон нийтэд албан ёсоор зарласан нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан, Үндсэн хуулийн суурь зарчмыг хөндсөн, хууль дээдлэх зарчмыг зөрчсөн үйлдэл гэж үзэж байна. Засгийн газрын гишүүнийг томилох, огцруулахад Улсын Их Хурал Ерөнхийлөгчид урьдчилан танилцуулах нь төрийн эрх мэдлийн салаа мөчир болох институт хоорондын харилцаа төдийгүй төрийн эрх мэдлийн хуваарилалт, төрийн эрх мэдэл хоорондын харилцан хяналт тэнцэлтэй байх зарчмыг хангаж байгаа явдал бөгөөд үүнийг үл ойшоон Ерөнхий сайдын онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томиллоо гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчмын нэг болох төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулж Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ гэснийг зөрчсөн үйлдэл болсон гэж үзэж байна.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайд нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн, Засгийн газрын тэргүүн, төрийн өндөр албан тушаалтны хувьд олон нийтэд зориулж албан мэдэгдэл хийхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гэснийг, 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхий сайд Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэснийг тус тус зөрчин бусдын гэм бурууг тогтоосон агуулгатай мэдэгдэл хийснээрээ Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсын шүүх эрх мэдлийн бүрэн эрхэд халдсан шинжтэй төдийгүй Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх зарчмыг үгүйсгэж байна. Тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томиллоо гэсэн агуулгатай мэдэгдэл нь Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалын бүрэн эрхийг хэтрүүлсэн, шударга ёсны зарчмыг өөртөө ашигтай байдлаар сонгож ашигласан

буюу selective justice Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын бүрэн эрхэд хамаарахгүй ажил үүргийг хариуцуулах шинжтэй байна.

Ерөнхий сайдын энэхүү үйлдэл нь парламентын засаглалтай Үндсэн хуульт ёсыг гажуудуулах, хүн биш хууль засагладаг байх манай нийгмийн хүсэл зоригийн эсрэг жишиг болж үлдэх эрсдэлийг бий болголоо.

Гурав.Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдөр баталсан 55 дугаар тогтоолоороо нүүрс, төмөр, хайлуур жонш экспортлогч аж ахуйн нэгж нь тухайн сардаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу АМНАТ төлөхдөө бүтээгдэхүүний дөрөвний нэгийг уул уурхайн биржээр арилжаалсан тохиолдолд нийт экспортод гаргасан бүтээгдэхүүний АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг биржээр борлуулсан үнэлгээгээр буюу бага үнээр тооцохоор зохицуулжээ.

Ингэснээрээ тодорхой этгээдүүдэд давуу байдал үүсгэсэн, шударга бус өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжсэн, далд эдийн засгийг дэмжсэн, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанаас ухарсан шийдвэр болсон байна. Мөн энэхүү тогтоол нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох бусад эрх зүйн акттай тус тус зөрчилдөхийн зэрэгцээ улсын төсөвт мөн төрлийн бүтээгдэхүүний АМНАТ-аас төвлөрүүлэх орлогыг бууруулах нөхцөлийг бүрдүүлж, улс орны эдийн засагт хохиролтой шийдвэр болсон төдийгүй Төсвийн тухай хуулийн 6.2.5-д төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлнэ гэснийг зөрчин Засгийн газар тогтоол баталсан гэсэн тодорхой 3 шалтгааныг огцруулах үндэслэл болгожээ.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 13.6 хувь нь дэмжсэнээр Ерөнхий сайдыг огцруулах саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсон Сайнзориг нарын Улсын Их Хурлын гишүүдийн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтойгоор Улсын Их Хурал дахь намын бүлгээс санал, дүгнэлт, үг хэлэхээр нэр ирүүлээгүй байна.

Тиймээс хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүдэд нэрээ өгнө үү. Хамтдаа.

44 гишүүнээр тасаллаа.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал бол Үндсэн хуулийн цаг хугацаатай асуудал. Бид 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй. 3 хоногийн дараагаас хэлэлцэж эхлэн, 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ гээд Иргэний хуулиар хүлээж авсан цагаасаа тооцохоор бид өнөөдөр 1 хагасаас өмнө шийдвэр гарсан байх ёстой. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-оор хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлана гэж заасан байгаа.

Тиймээс өнөөдрийн санал хураалтыг 12 цаг 30 минутад явуулна. Түүнээс өмнө багтаж ирүүлсэн нэрс, үг хэлж, асуулт асуух гишүүд асуултаа асууж амжина гэсэн үг. Ингээд горимын санал байхгүй Бямбацогт сайд аа.

Улсын Их Хурлын Бөхчулууны Пүрэвдорж таныг урьж байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Дарааллаараа явсан чинь Лутаагийн Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Сайн байцгаана уу? Өглөөний мэнд хүргэе.

Монгол Улсын төрийн түүхэнд анх удаа хоёр өндөрлөг болох Ерөнхий сайд, Их Хурлын даргыг огцруулах шийдвэрийн өмнө бид нар ирсэн байна.

Тэгээд өчигдөр ирц 10.00 цагт бүрдсэн боловч ирцээ хүлээгээд 24 цаг боллоо. Тэгээд хүлээж сууж байхдаа би шинэ гишүүний хувьд ингэж бодлоо. Ямар их эрх мэдэл вэ. Ямар их. Яагаад хүрч ирж ирцдээ бүрдэхгүй байна. Нэг бодлын харамсалтай. Нөгөө бодлын гунигтай. Одоо юу хэлэх вэ. Тэгэхдээ өчигдөр ирцдээ ирээд суусан бүх гишүүддээ бас баярлалаа гэж хэлье. Тэгээд парламентын шинэ тогтолцооныхоо талд, үнэт зүйлсийнхээ төлөө өнөөдөр би энд сууж байгаа. Асуух зүйл байхгүй байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Лутаагийн Энхнасан гишүүн маш эрт ирцдээ ороод яг бүтэн өдөржин, шөнөжин хүлээсэн.

Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун. Саранчулуун гишүүний микрофон нээлттэй байна.

О.Саранчулуун: Өглөөний мэнд эрхэм гишүүд ээ,

Би чинь одоо та нарыг чинь аягүй суралцах гэж, туршлагатай гишүүд маань гээд зөндөө л хамтарч ажиллаж, зөндөө л уулзаж ярилцсан даа. Би одоо үнэхээр харамсалтай байна. Та нарын цаг хугацааны хэмжүүр юугаар явдаг юм? Одоо дахиад нэг юм асууж. Одоо асуугаад ч хариултаа олж авахгүй байгаа нь манай энэ улс төрийн хүмүүсийн цаг хугацааны хэмжүүр хаагуур явдаг юм? Өөрсдөдөө оноо авах болохоор цаг нь яваад байдаг. Өөрсдөдөө ашигтай болохоор цаг хугацаа яараад байна яараад байна гээд байдаг. Өөрсдөд нь чухал биш болохоор цаг хугацаа сонин биш болдог юм уу? Та нарын хувьд чухал үед цаг хугацаа яараад

байдаг. Тэгээд түүндээ ард иргэдийн нэрийг их ярьдаг. Дахиад асууя Сангийн сайд аа, жагсаж байгаа хүмүүсийн эрүүл мэндийн асуудал хэцүү байна гэж өчигдөр, уржигдар ярьж ярьчихаад тэгээд ярья гэхээр өөрсдөө алга болдог. Та нар ямар бүдүүлэг, ямар муухай харагдаж байгаагаа та нар мэдэж байна уу? Та нар өөрсдөөсөө ичээч. Ичдэггүй юм уу та нар. Өөрсдөөсөө ич. Зүгээр ич за юу.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Хорин хэдэн цаг хүлээж байж бид өнөөдөр чуулганаа арайхийж эхлүүллээ. Нэг их олон зүйлийг хэлэхийг хүсэхгүй байна. Уг нь олон зүйлийг хэлье гэж бэлдэж байлаа. Тэр яах вэ, зүгээр парламентын засаглалтай манай улсад аягүй их олон зүйл сүүлийн 24 цагт өрнөхийг бүгдээрээ л харлаа. Тэгээд нэг л зүйлийг тод томруун хэлье гэж бодсон юм. Ямар ч төрлийн хэрүүл, маргаан, үл ойлголцол гарах л байх. Тэгэхдээ яг үндсэн хоолоо олж идэж байгаа уул уурхайн салбараар попрохоо болих хэрэгтэй байна. 1 шанага бараг хөрс ч хөдлөөгүй байгаа тэр Бор тээгийн уурхайгаар, ордоор, хэсгээр яасан ч их попордог юм. Тэгээд яг өнөөдөр Ерөнхий сайдыг огцруулах яг үндсэн албан бичгээ харах юм бол яг тэр биржтэй холбоотой хуулийн заалт байхгүй байгаа шүү дээ. Тэгээд тэрийг яасан сөргөөр тайлбарладаг юм. Энэ уул уурхайн попорлоо зогсохгүй бол одоо энэ чинь их эмзэг салбар байгаа шүү дээ. 1990 онд л 50-иас дээш хувь нь Монгол Улсын эдийн засаг, уул уурхайгаас хамааралтай байгаа. Тэр олон жил эдийн засгаа солонгоруулъя гээд л намайг дунд сургуульд байхад л ярьдаг байсан улс төрчид энд сууж байгаа шүү дээ. Тэгээд хийж байгаа юм нь хаана байгаа юм. Одоо хамаарал нь ерэн хэдэн хувь болоод явсан. Энэ салбар чинь өөрөө маш эмзэг байгаа шүү дээ. Бид нараас хамаарахгүй. Бид үнийг нь хэзээ ч тооцоолж чадахгүй. Тэгэхэд ингээд л өнөөдөр хэрэлдээд л байж байдаг юм.

Тэгээд яг өнөөдөр Монголд хүний эрх хангагдсан, эрүүл аюулгүй, нийгэмд амьдрах боломж байхгүй байна гэж харж байна. Манай намын сунгаатай холбоотой одоо манай Ерөнхий сайдын гаргасан үйлдлүүд ерөөсөө таалагдахаа больсон. Тэгээд дарга нарынхаа сандал суудлын асуудалтай холбоотой гэмгүй ямар олон залуучуудыг барьж хорьдог юм. Яасан их хэлмэгдүүлэлт явдаг юм. Үүнтэй ерөөсөө санал нэгдэж чадахгүй байна. Тийм учраас ямар шийдвэр гаргах бол гэдэг ойлгомжтой сонсогдох байх. Тэгэхээр одоо цааш цаашдаа хамгийн гол хэлэхийг хүсэж байгаа зүйл бол ганц хоолоо олж идэж байгаа энэ салбар руугаа битгий их буруу гишгэж чихэж хүмүүсийн мэдэх эрхэд бүдүүлгээр халдаач ээ. Ингээд л дуусгая даа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа.

Э.Болормаа: Эрхэм Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд Та бүхэн сайхан амарсан уу? Нэлээн сайхан амарсан шинжтэй харагдаж байна. Өчигдөр үнэхээр гутмаар байлаа. Ерөөсөө гурван төрлийн хүмүүс л орж ирсэнгүй. Эсвэл өөрөө сайд, албан тушаалаасаа буух гэж байгаагаасаа үхтлээ айлаа. Эсвэл ямар нэгэн ашиг сонирхлын нэгдмэл байдалтай. Эсвэл ямар нэгэн дарамтад өртсөн, шантаажид өртсөн, өргөсөн тангаргийнхаа дагуу үүргээ гүйцэтгэх чадамжгүй болсон ийм л төрлийн гишүүд орж ирж чадсангүй. Би өөрийнхөө намын ах нартаа ч гутаж байна, сөрөг хүчиндээ ч гутаж байна. Парламентын засаглалыг хамгаалахын тулд сөрөг хүчин маань хүчтэй зогсох болов уу гэсэн чинь дарамтад өртсөн, шантаажид өртсөн, ашиг сонирхолд нэгдсэн орж ирэхгүй сууж байгаа

хүмүүс байна. Үнэт зүйлээрээ байсан бол бас нэг өөр хэрэг. Энд аль нэг нам ярих гэсэндээ биш. Бид энэ 126 энд Монгол Улсынхаа төлөө шийдвэр гаргах ёстой. Түүнийхээ төлөө үүрэг гүйцэтгэж байгаа юм. Ямар азаар харин үнэхээр 126 гишүүнтэй болсон юм бэ. Өмнө нь 76-тай байхдаа ямар байсан юм бол гэдэг бодол их төрж байна.

Олон нийт шөнөжин харсан байх. Хямарсан олон хүмүүс байгаа байх. Гэхдээ одоо бид үүнийг засаад сайжруулаад явна гэдэгт итгэлтэй байна. Тэгээд бас хурлыг удирдаж байгаа Булгантуяа даргадаа үнэхээр их баярлалаа. Энэ хүмүүс шөнөжин унтахгүй байж байгаад өглөө босож ирээд ганц эмэгтэй хүн рүү дайръя гэж шийдсэн юм шиг байна. Одоо хурдан бүгдээрээ санал хураалтдаа ороод энэ гадаа жагсаж байгаа шийдэх ёстой асуудлууд руугаа оръё. Түүнээс биш нэг сайхан попроод цалин 10 хувь, 20 хувь нэмнэ гэхчээд тэрийгээ гаргах шийдвэр чинь энэ танхим дотор байх ёстой шүү дээ. Төсвөө энэ дотор бид хэлэлцээд, өөрчлөөд, тэр шийдвэрүүдийг хамтдаа энд гаргах ёстой шүү дээ. Зүгээр нэг facebook, reel хийгээд ажил явдаг болсон юм уу.

Х.Булгантуяа: Болормаа гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: Би дахиад хэлье. Болормаа гишүүнтэй адилхан. Манай Засгийн газрын гишүүд сайхан амарцгаасан уу? Нүд цурам хийлгүй та бүгдийг ирцээ бүрдүүлэхийг хүлээлээ. Яг Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэн аппаратаараа яагаад огцрох шаардлагатай вэ? Өнөөдөр улаан буудайн хураалт 60 хүрэхгүй хувьтай, төмс, хүнсний ногоо 60 хүрэхгүй хувьтай, малын тэжээл 30 хувьтай, тосны ургамал 20 хувьтай. Яг өнөөдөр бодит байдал дээр бид ургац хураалтын ажилд учирч байгаа хүндрэлийг ярих юм бол хүн хүч, ажиллах хүч байхгүй, болц дутуу, ногоон тариа ихэссэн, орон нутагт шатахуун тасалдсан. Одоо малчид над руу бичиж байна. Өдөрт 5 литр шатахуун авах боломжтой байсан. Одоо өгөхөө байлаа. Цасан шуурга болж байна. Бидний амьдрал их хүндэрлээ. Бид яах вэ гэдэг асуудлыг бичиж байгаа юм. Гангийн улмаас ихэнх бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн ургац алдсан. Оны тариалалтад шаардлагатай улаан буудай, төмсний үрийн нөөц бүрдүүлж чадахгүй байна. Малчид, тариаланчдын энэ зээлээ авсан зээлээ хугацаанд нь эргэн төлөх чадамжгүй боллоо. Энэ жилийн нөхцөл байдлаас болж 100 мянган тонн хүнсний будаа дутагдах нь. Хүнсний хангамжийн асуудал хүндрэх нь. Хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үүсэх гээд байна. 1 тонн хүнсний буудайн ойролцоогоор 1.2 сая төгрөг байдаг. Ингээд тооцох юм бол энэ жилийн төсөв дээр 120 тэрбум төгрөг улсын төсвөөс шаардагдаж байгаа.

Гэтэл Хөдөө аж ахуйн сайд өөрөө хэлэхдээ Засгийн газрын нөөц сангаас авна гэсэн тооцоотой байгаа гэж байгаа. Одоо Засгийн газрын нөөц санд чинь 10 тэрбум төгрөг л байна. 10 тэрбум төгрөг хүрэх үү, үгүй юу. Бид энэ дутагдаад байгаа хүнсний буудайг 120 тэрбум төгрөгийг хаанаас олох вэ? Импортоор авъя гэлээ. Төсөвт чинь мөнгө алга. Ийм нөхцөл байдалтай бид Засгийн газар улс төр хийж, сандал суудал, албан тушаал хөөцөлдөж явахынхаа оронд үндсэн амьдрал руугаа орж ажиллахгүй бол ард иргэд чинь нурж уналаа шүү.

Тийм учраас би олон ч дахин хэлж байгаа юм даа. Угаасаа ажлаа хийж чадахгүй, ажлаа хийхгүй байгаа сайд нар огцорсон нь дээр шүү дээ. Өөр яах вэ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал.

О.Батнайрамдал: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Яг 24 цаг болж байна. Эрэмбийн асуудал байна. Ард түмнийхээ эрх ашгийг яагаад нэгдүгээрт тавьж болдоггүй юм. Яг үнэнийг хэлэхэд ард түмний хүсэж байгаа зүйл та нарын хүсэж байгаа энэ сандал суудлын маргаанаас чинь шал өөр юм хүсэж байгаа шүү. Өнөөдөр яг ингэж, өнөө шөнө яг ингэж гүрийсэн шигээ та нар Оюу толгойн шийдэл дээр яг ингэж гүрийнэ шүү. Монголчууд бүгдээрээ яг одоо харж байгаа. Ард түмэн минь хараад аваарай. Оюу толгойн асуудал шийдэхэд хэн юу гэж хэлэх нь, яаж хөдлөх нь бүгдээрээ харъя. Яг сандал суудлаа авч үлдэхийн тулд ингэж юу ч хамаагүй бойкотолж, хуулийг өөрийнхөө дураар, өөртөө ашигтайгаар ямар ч хамаагүйгээр тайлбарлаж байсан шиг Оюу толгой дээр яг хэн юу гэж хэлэх нь вэ? Хэн ямар шийдвэр гаргах нь вэ, хэн ирцдээ орох нь вэ? Бүгдээрээ харцгаая. Угаасаа цаг хугацаатай.

Та нар бод доо. Өнөөдөр бидний уг нь батлах гээд байгаа төсөв 33 их наядын орлоготой тийм ээ Оюу толгойн зээлийн хүү дээр бид энэ өнөөдрийн ярьж байгаа төсвөөс 2 дахин их мөнгөний асуудал ярьж байгаа шүү дээ. 12 сарын 31 гээд хугацаа нь дуусах гэж байгаа. Одоо харъя. Ямар шийдэл гаргах нь. Ямар асуудал дээр яаж гүрийж болдгийг харлаа. Хэдэн ч цагаар хамаагүй хуралдаж болдгийг харлаа. Хэдэн ч цагаар Оюу толгойн асуудлыг шийдэхийн тулд парламентын ордонд 48 цаг, 72 цаг хүлээсэн ч хамаа алга. Ард түмний хүсэл зорилго. Бид ард түмнийг төлөөлж энд байж байгаа шүү дээ. Энэ эрэмбээ бүгдээрээ дахин дахин, болохгүй бол өдөр болгон сануулсан ч яах вэ. Одоо яг ямар шийдэл гарах нь вэ харъя. Яг цаг хугацаатай уралдаж байгаа бид нар. Өнөөдөр 10 сарын 17-ны өдөр. 12 сарын 31 хүрэхэд бид нарт ердөө 50 хүрэхгүй л хоног үлдсэн байна. Энэ 50 хүрэхгүй хоногт бид шийдэл гаргаж чадах нь уу, үгүй юу харъя. Энэ дээр парламент өдөржингөө шөнөжингөө ч хамаагүй хуралдах нь уу, үгүй юу бас харъя. Ийм амин чухал Монгол Улсын эрх ашгийг нэгдүгээрт тавьсан асуудал дээр нам хамаарахгүйгээр бүгдээрээ нэгдэх ёстой байхгүй юу. Монгол Улсын эрх ашгийг нэгдүгээрт тавьж нэгдэж чадах нь уу, үгүй юу? Сандал ширээний асуудлаа хойш нь тавьж байгаад Монгол Улсын эрх ашгийг шийдэж чадах нь уу, үгүй юу? Харин ард түмэн энэ дээр харж байгаа Та бүхэн эцсийн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Батнайрамдал гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Буяагийн Тулга.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өглөөний амар амгаланг эрье. Асуулт цуг гэж ойлгож байгаа зөв үү?

Х.Булгантуяа: Тийм. Асуулт асууж, үг хэлж болно. Асуултад Ерөнхий сайдыг огцруулах саналыг гаргасан, гарын үсэг зурсан хүмүүсээс хариулахаар юм билээ Дэгээрээ.

Б.Тулга: Тэгэхээр манай энэ бас шинэ Үндсэн хуулиар энэ 126 гишүүнтэй олон намын төлөөлөлтэй парламент бүрдээд бас эхнийхээ сорилтуудыг туулж байна гэж харж байна. Тэгээд бидний өмнө тулгамдсан байгаа сорилтыг шийдвэрлэхээр энэ танхимд өнөөдөр хуран цугласан бүх гишүүдийн юуны өмнө талархал илэрхийлье. Мэдээж маргаантай янз янзын зүйлүүд яригдаж байх шиг байна. Тэгэхдээ энэ дотор хүний халдашгүй байдал, хэн нэгэн хүнийг сургаар, тэр тусмаа гадна, дотнын хэвлэл мэдээллийн байгууллагын гарсан нийтлэлээр шүүдэг энэ байдал, ингэж шүүхдээ бүр улс төрийн өрсөлдөгчөө онилж авч шүүдэг энэ байдал бол хэзээ ч энэ ардчилсан парламентын түүхэнд, ардчилсан улсад байх ёсгүй гэж үзэж байгаа. Энэ 126.1 дээр ийм байдал үүсэж байна гэдэг бол та бидэн дээр жирийн иргэн дээр энэ бол маш энгийн одоо зүйл болж хувирна гэсэн үг.

Тэгэхээр ийм зүйлийг ярьж байгаа төрийн өндөр албан тушаалтан ёс зүйн байна уу, тодорхой хариуцлага хүлээх ёстой гэж бодож байна. Өнгөрсөн 24 цаг хурлын ирц хүртэл юу болсныг иргэд маш сайн өдөр шөнөгүй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сошиалаар харсан. Маш олон гишүүд өнөөдрийг хүртэл чуулганд орж ирж чадахгүй дарамттай байна. Гадаад, дотоод явуулсан байна. Шоронд хийх янз бүрийн зүйлээр дарамталсан байна. Тэгэхээр энэ бол ардчилсан парламентын түүхэнд байж болохгүй. Энэ бол бид буруу зам руу будаа тээхийн эхлэл болно. Тийм учраас үүнийг таслан зогсоох ёстой.

Энэ Үндсэн хуулийн зөрчил үүсэж байгаа учраас чуулганд орно, орохгүй гэдэг юм ярьж байгаа. Өмнө нь ч гэсэн бид засгийн газраа огцруулах, Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг шинэ батлагдсан Үндсэн хуулийн хүрээнд ч тэр, өмнө ч тэр гаргаж л байсан. Одоо Занданшатар дарга бол Их Хурлын дарга байхдаа Хүрэлсүх даргыг огцруулах энэ шийдвэрийг мөн л 2021 онд гаргаж байсан. Яг л өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндсэн хууль, нэмэлт, өөрчлөлт, дэгийн дагуу. Тэгээд өнөөдөр болохоор өөр дээр нь ирэхээр энэ дэгээр явж болдоггүй. Үндсэн хуулийн зөрчил гэж үздэг энэ байдал байж болохгүй гэж үзэж байгаа.

Тийм учраас огцруулах санал гаргасан хууль санаачлагч П.Сайнзориг гишүүнээс асуумаар байна. Энэ хуулийн дэгээ одоо энэ танхим дотор тайлбарлаж өгөөч ээ. Үнэхээр одоо ингэж Үндсэн хууль зөрчөөд байгаа юм уу, үгүй юм уу гэдгээ та хуулийн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны саналаар хурааж Ерөнхий сайдын огцрох эсэх асуудлыг шийдэж байгаа нь ерөөсөө Үндсэн хууль зөрчөөгүй. Өөрөөр хэлэх юм бол миний болон нийт 54 гишүүний гаргасан саналын агуулга яг хэвээрээ байгаа. Агуулга Ерөнхий сайдыг огцрох эсэх асуудал. Өөрөөр хэлэх юм бол энгийн логигоор Байнгын хороо уг асуудлыг эрхэлсэн Байнгын хороо нь авч хэлэлцээд тэр Байнгын хорооны гишүүд нь өөрийн итгэл үнэмшил, зарчим, байр сууриар саналаа хураалгаж байгаа. Тэр саналын үр дүнгээс томьёолол, Улсын Их Хурал руу орох томьёолол өөрчлөгдөж байгаа болохоос биш агуулга буюу уг санал маань ерөөсөө өөрчлөгдөөгүй байгаа.

Хоёрдугаарт, 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой яриад байна лээ. Үндсэн хуулийн өөрчлөлтийн танилцуулга буюу албан ёсны танилцуулгыг нь би авч үзлээ. Өчигдөр мэдээлэл өгсөн. Уг танилцуулга дээр ерөнхийдөө 76 гишүүнтэй парламент байж байхад 39 гишүүн ирц бүрдээд 20 гишүүнээр Ерөнхий сайдыг огцруулдаг байсныг одоо халж Засгийн газар гэдэг томьёоллоос нь татгалзаад Ерөнхий сайд гэдэг агуулгаар нь буюу кабинетын зарчмаар нь хариуцлага хүлээх ёстой гэдэг үндэслэлээр Ерөнхий сайд гэдэг томьёоллоор үзээд ер нь энэ хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор биш нийт гишүүдийн олонхоор буюу одоо 126 парламентын гишүүдийн 50 дээр нэмэх нь 1-ээр л асуудлыг аль нэг талдаа гаргаж шийдье л гэсэн. Ерөөсөө л зарчим энэ. Аль нэг талдаа 64 хүрэх. Түүнээс биш Байнгын хорооны гаргасан саналуудыг үгүйсгээд, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гаргаж байгаа тэр итгэл үнэмшил, саналаа өгч байгаа байр суурийг үл ойшоогоод асуудлыг алгасаж шийднэ гэсэн ойлголт байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ агуулгаараа ерөөсөө ямар нэгэн байдлаар Үндсэн хуулийг зөрчсөн асуудал байхгүй байгаа гэж харж байгаа. Мэдээж үүнийг тал талаас нь л шөнөжингөө сууж хуулиудыг нь харлаа. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тайлбар, танилцуулгыг харлаа. Та бүгд үүнийг харах хэрэгтэй байх гэж бодож байна. Тэгээд шаардлагатай тохиолдлууд Улсын Их Хурлын Тамгын газар үүнийг дэг сахиулах, дэгийг тайлбарладгийн хувьд анхаарч гишүүддээ өгөх нь зөв байх. Бид хэд өмнө нь хэрэгжиж байсан хуулиа өөртөө ашигтай байдлаар ингээд тайлбарлаад байх тусам л Үндсэн хууль их хэврэг зүйл болно.

Тийм учраас гишүүддээ одоо нэгэнт хууль нь, агуулга нь, текст нь бүх зүйл нь өөрчлөгдөөгүй. Харин 2019 оны Үндсэн хуулийн нэг юм чинь ерөөсөө л огцруулсан тохиолдолд 30 хоногийн дотор Ерөнхий сайдаа томилоорой гэдэг цаг хугацааг л нэмж өгсөн юм билээ бас.

Тэгэхээр бид хэд одоо ийм зүйлүүд дээр ингэж ард иргэддээ төөрөгдүүлсэн мэдээллийг өгч хоёр талд талцаад одоо юу гэх вэ. Мэдээж Байнгын хороо шийдвэрээ гаргах эрхтэй. Байнгын хорооны саналын дагуу явж ирсэн энэ жишиг байна. Хууль нь ч тийм. Тэгээд үүгээрээ саналаа хураагаад явах болов уу л гэж би зүгээр харж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Г.Тэмүүлэн: Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Эдийн засгийн нөхцөл байдал өөрөө сайнгүй байна гэдэг асуудлыг би жилийн өмнө ярьж байсан. Өнгөрсөн оны төсвийг батлах үед бид бүхэнд хүссэн, хүсээгүй бодит эрсдэлээс хамгаалах, макро эдийн засгаа тогтворжуулах, эдийн засгаа эрчимт эмчилгээнд орохоос сэргийлэх бодлого зайлшгүй шаардлагатай байна гэдэг асуудлыг ярьж байсан. Өнөөдөр бид бодит үнэтэйгээ нэг талдаа нүүр тулж байна. 4 сарын өмнө би Монгол Ардын намын Бага хурал дээр эдийн засгийн эрх чөлөөний бодлогыг танилцуулж байсан. Өнөөдөр бид эдийн засгийн энэ хүнд үед бодит өөрчлөлтийг авах үр дүн авчрах алхмууд хэрэгтэй байна гэдэг асуудлыг

хөндөж тавьж байсан. Миний энэ байр суурь ч гэсэн одоо хэвээрээ байгаа. Өнөөдөр аливаа улс оронд аливаа төрийнх нь, улс төрчдийнхнийх нь хийх хамгийн сайн улс төр бол ард түмнээ сайхан амьдруулах, ард иргэдийнхээ амьжиргаа, орлогыг нь дээшлүүлэх асуудал байгаа. Бид бүхэн 35 жил хувийн хэвшилд суурилсан хүчирхэг эдийн засгийг бий болгож чадаагүй. Ядуурлынхаа түвшнийг бууруулж, ядуурлаа шийдэж бүрэн дүүрэн чадаагүй байгаа.

Тэгэхээр үндсэндээ бид өнгөрсөн энэ хугацаанд төсөвт тэлж төр данхайхын хэрээр хулгай ихсэж байна. Эдийн засгаа тогтворжуулах, хүндрэлийг даван туулах энэ асуудал бол бид бүхний номер нэг нэн тэргүүний асуудал. Миний, чиний Монгол гэж байхгүй. Ардын намын, Ардчилсан намын Монгол гэж байхгүй. Манай, танай Монгол Улс гэж байхгүй. Үүний төлөө бид бүгдээрээ нэгдэж нийлэх ёстой. Төрөө жижиглэх, төсвөө танах, хэрэгцээгүй зардлуудаа бууруулах асуудал бол бид бүхний нэн тэргүүний асуудлууд байна. Хамгийн түрүүнд би эдийн засгийн эрх чөлөөний бодлогын хүрээнд энэ эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах 10 бодлогыг танилцуулж байсан. Нэн яаралтай энэ бодлогуудыг 6 сарын хугацаанд авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүний дараагаар магадгүй энэ 6 сараас жилийн хугацаанд бид эдийн засгаа тэлэх зөв үзэл санаанд суурилсан эдийн засгийн бодит өөрчлөлтийг бид авчрах хэрэгтэй байна гэдэг асуудлыг тавьсан. Шинэ Засгийн газар байгуулагдаад 4 сар болсон байна. Өнгөрсөн хугацаанд тодорхой төдийлөн ард иргэдэд болоод бид бүхэнд хүлээлттэй байсан бодлогын өөрчлөлт, хандлагын өөрчлөлт төдийлөн харагдахгүй байна гэж би хувь хүнийхээ үүднээс дүгнэж үзэж байгаа юм.

Өнөөдөр инфляц өөрөө буурсангүй. Улаанбаатарын хэмжээнд 10 хувьтай, улсын хэмжээнд 9 хувьтай. Эдийн засгийн өсөлт ч гэсэн төдийлөн яг өнгөрсөн онтойгоо адилхан хэвээр. Эргээд том макро түвшиндээ бодлогын хүү 12 хувьтай, ханш 3600-тай. Дэлхийд долларын ханш унаж байхад манай Монгол Улсад өсдөг ийм урвуу хамааралтай байгаад байгаа.

Тэгэхээр бид үндсэндээ эдийн засгийн эрүүл өсөлтийг бий болгох, хувийн хэвшлээ дэмжсэн, иргэд, аж ахуйн нэгжүүдээ хөхүүлэн дэмжсэн нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх бодит бодлого хэрэгтэй байна гэдэг зүйл бол эндээс харагдаж байгаа гэж би хар... /минут дуусав/

Х.Булгантуяа: Тэмүүлэн гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Бид нарыг за яах вэ, өөрийнхөө гадарладаг хэсгүүдээсээ хэдэн юм байгаагаа хэлээд тэгээд тодруулах. Ялангуяа энэ хууль зөрчөөд байгаа, Цэцийн асуудал зөрчөөд байгаа, дэгийн асуудал зөрчөөд байгаа гэдэг хүнийг нь бас гадарладаг, хуулиа мэддэг тэр хүмүүсээс асуулт, тодруулалт авч байж шийдвэр гаргах нь зүйтэй байх гэж үзлээ. Бид нарыг олон жил сургаж, багшилж энд тэнд явж байхад ер нь мэддэг мэддэг салбараа л ярьж бай. Мэдэхгүй бол мэдэхгүйгээ мэддэг байжээ гэдэг бүүр хамгийн анхны нэгдүгээр юм.

Хоёрдугаарт, мэддэггүй салбараа мэдэж байж дараа нь юм хумаа ярьдаг, асуудаг, хэлдэг, ярьдаг. Асуулт гэдэг чинь мэдэхийн анхны юм. Энэ утгаараа эрүүл мэндийн салбартаа тэгээд л уул нь бодлогын мэтгэлцээнээ гээд л гоё юм ярих

гэхээр зэрэг наад захын суурь асуудал дээрээ очиж суугаад, тэгээд түүн дээрээ бараг ойлголцохгүй түвшинд очих юм. Бараг нэг төрлийн хүмүүс мөн үү, биш үү гэж бодогдохоор болтол. Жишээлбэл, эрүүл мэндийн салбар дээр оруулж ирж байгаа бодлогыг харахаар зэрэг уг нь бүх гоё үг, үсгийн цуглуулгууд тэнд байгаа байхгүй юу. Үнэхээр уншихаар сэтгэл баясаж, нүд сэргэж баярламаар. Ёстой аргагүй хөгжих нь дээ гэмээр. Зүгээр л нэг жишээ уншаад үзье. Та хэд зүгээр зүгээр логик нь байна уу, үгүй юу гээд нэг хооронд бодоод үз дээ. Хүний хөгжил хамгийн том мега төсөл тэр дотроо эрүүл мэндэд гэж бид дөнгөж л ерөөсөө энэ засаг томилогдсоноо авхуулаад л би хамгийн баярлууштай хүлээж авч байна гэдгээ хэлж байсан, илэрхийлж байсан. Энд ийм өгүүлбэр явж байгаа юм. Эрүүл мэндийн нөөцийг буюу даатгалын сангийн нөөцийг өвчлөл, нас баралтыг тэргүүлэх шалтгаан болгож буй өвчин эмгэг, амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээнд түлхүү зарцуулж, хүлээж болохуйц амьдралын чанар, сайжруулах тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрийг нэмэгдүүлэх замаар шатлал хоорондын урсгалыг зохицуулж, санхүүжилтийн үр ашгийг нэмнэ. Энэ өгүүлбэр дотор хэдэн логикийн алдаа, хэдэн бие биеэ үгүйсгэсэн юм, хэдэн бодлогын асуудлыг явж байна. Та хэдэд сонсогдож байна уу?

Үүнийг уншаад үзэхээр манай салбарын надтай хамт одоо энэ асуудлыг ярьж байгаа хүмүүс хэнийг доромжлоод байгаа юм бэ гэж зарим нь шууд хэлж байгаа байхгүй юу. Энэ дээр жишээлбэл бүх гоё юмнуудыг ярьж ярьж байснаа энэ дээр яах вэ гэхээр иргэний төлөх хамтын төлбөр гэдэг ганцхан л асуудал ороод ирж байгаа юм. Энэ чинь анх томилогдоход л би салбарын сайдаас асууж байсан шүү дээ. Манайх 40 хувьдаа хүрсэн шүү. Out-of-pocket cost-ыг нэмэхгүй шүү гэдгийг. Тийм ээ л гээд байсан. Үүнтэй тэгээд маш богино юун дээр асуултаа нэмвэл... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ганмаа гишүүн нэмж 1 минут тодруулъя.

Д.Ганмаа: Энд саяын ярьсан энэ логик дэс дарааллыг яг ойлгоод, мэдээд ярьдаг, бодлого зохицуулдаг ийм л салбарын сайдтай байхыг хүсэж байна. Хамгийн түрүүнд. Эдгээр асуудлыг ярихаар худлаа ярьж байна, эсвэл хулгайчуудыг өмөөрч байна, эсвэл би тэгээгүй, ингээгүй бүр шал өөр юм болоод, эсвэл хүмүүсийг дуурайсан. Эмч эмнэлгийн цалинг нэмье гэхээр чинь зэрэг хүмүүсийг босголоо энэ тэр гэсэн тийм ойлголтгүй. Цаг хугацаа их бага байгаа учраас би одоо Сайнзориг гишүүн энэ бичгийг оруулж ирсэн хүнээс асууя. Энэ Үндсэн хуулийг зөрчсөн гээд байгаа асуудал дээр би юу байгаад байгаа юм бэ? Үүнийг маш сайн ойлгомжтой энгийн хэлээр тайлбарлаадхаач. Мөн Дэгийн хуулийг зөрчөөд байгаа гэдэг асуудлыг сайн тайлбарлаад яриад өгөөч. Ард түмэнд ойлгогдохоор. Баярлалаа.

Х.Булгантуяа: Эхлээд Сайнзориг гишүүн. Дараа нь Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир гишүүн нэмж хариулъя. Эсвэл Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаас эхлэх үү? Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Ганмаа гишүүнд тайлбарыг өгье.

Ер нь зүгээр яах вэ, яг нөгөө Байнгын хорооны саналаар та Улсын Их Хурал дээр, Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр хураах гэж байгаа асуудлыг л яриад байна.

2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлт маань энэ Үндсэн хуулийн холбогдох заалтыг өөрчлөхдөө тухайн үеийн 76 гишүүнтэй парламентын 39 буюу түүнээс дээш нь цуглаад түүний хуралдаанд оролцсон гишүүдийн 50 дээр нэмэх нь 1 нь Ерөнхий сайдыг огцруулчихаад байсан юм. Өөрөөр хэлбэл 20 гишүүн. Энэ босгыг өндөрсгөж шинэ парламентыг байгуулахдаа цаашдаа ер нь нийт гишүүн буюу ер нь нийт гишүүн гэдэг нь 126-гийн 50 дээр нэмэх нь 1 нь тодорхой хэмжээнд Ерөнхий сайдын огцруулах эсэх асуудал дээр байр сууриа хэлж байж оролцох ёстой гэдэг энэ зарчмыг тогтоож өгсөн ийм агуулгатай заалт.

Хоёрдугаарт, энэ заалтыг засахдаа Засгийн газрыг огцруулах гэж байсныг Ерөнхий сайдыг огцруулах гэж өөрчилсөн юм. Бас агуулгын хувьд. Яагаад гэхээр Ерөнхий сайд бол кабинетаа тэргүүлж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын өмнө энэ хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцаж байгаа хүн юм. Иймд Ерөнхий сайд огцрохоор Засгийн газар бүрэлдэхүүнээр огцордог зарчмын хүрээнд томьёолол, агуулгын хувьд ингээд өөрчлөх нь зүйтэй гэж үзсэн.

Дараагийн асуудал нь Ерөнхий сайд огцорсон тохиолдолд 30 хоногийн дотор Ерөнхий сайдыг томилох асуудлыг л хугацааны хувьд тодорхой болгож өгсөн. Бусад асуудал ерөөсөө л явж байгаа дэгээрээ явж байгаа. Тэгэхээр энд ямар нэгэн зөрчил байхгүй. Би яах вэ зүгээр ингээд өөрийнхөө логигоороо энгийн байдлаар тайлбарлах гээд байгаа юм л даа. Энэ асуудал чинь өөрөө эргээд эрхэлсэн Байнгын хороо орж байгаа. Төрийн байгуулалтын байнгын хороогоор орлоо. Гишүүд маань санал, байр сууриа хэлээд саналаа өгч байгаа. Энэ дэг зөрчсөн гэж яриад байгаа гишүүдийнхээр бол тэнд орж байгаа гишүүд бүгд дэмжиж өгөх болчихоод байгаа байхгүй юу. Дэмжихгүй гишүүн байж болно шүү дээ.

Тэгэхээр өөрийн байр сууриа хэлж байгаа гишүүдийн олонхын байр сууриасаа шалтгаалж томьёолол өөрчлөгдөж байгаа болохоос биш уг 54 гишүүний гаргаж байгаа Ерөнхий сайдыг огцруулах эсэх асуудал агуулгын хувьд ерөөсөө өөрчлөгдөөгүй байхгүй юу. Энэ асуудлыг л одоо ингээд л чуулганы хуралдаанд 64 дээр нэмэх нь, эсвэл 64-өөс хасах нь гэдэг байдлаараа кнопоороо илэрхийлээд л нэг талд нь гаргаад шийднэ. Ерөөсөө л энэ.

Тэгэхээр энэ асуудал дээр Үндсэн хуулийн зөрчил байхгүй. Үндсэн хуулийн агуулга бол энэ нийт гишүүдийн чинь 50 дээр нэмэхээс дээш хувь нь л оролцох ёстой шүү л гэдэг тэр үзэл санааг илүү их бэхжүүлж энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг 2019 онд хийсэн. Энэ асуудлыг нь ч гэсэн яг албан ёсны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тайлбар танилцуулга нь ном хэлбэрээр гарсан нь. Яг л үүгээрээ байж байгаа юм байна лээ. Ийм л зүйл юм гэж ойлгож байгаа.

Х.Булгантуяа: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Үндсэн хуулийн зөрчсөн эсэх, үгүйг Улсын Их Хурлын гишүүд тайлбарлахгүй. Өчигдөр Үндсэн хуулийн цэц дээр 2, 3 гишүүн гүйж очсон юм шиг байна лээ. Очиж байгаа газар нь зөв. Тэр газар чинь тайлбарлана. Тэр газар чинь дүгнэлтээ гаргана.

Тийм учраас Үндсэн хуулийн цэц зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн цэц л тогтооно. Тэрнээс энд байж байгаа 126 гишүүнийг хэн нэг нь тайлбарлаад, өөрт

ашигтайгаар тайлбарлаад ингэж явж болохгүй. Тийм учраас өчигдөр хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хороо, өнөөдөр санал хураах гэж байгаа Улсын Их Хурлын чуулган ямар санал, томъёоллоор хураах гэж байгаа гэдэг бол бүгд хуулийн хүрээнд явж байгаа. 2019 он хүртэлх болоод, 2019 оны өөрчлөлтөөр явж байгаа энэ хуулийн хүрээнд хурлууд явагдаж байна, санал хураалтууд явагдаж байна... /минут дуусав/

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүний микрофоныг нэмж өгье. Гүйцэт хариулъя.

Ц.Сандаг-Очир: Үүнийг одоо тэгээд олон нийтэд өөрсдөд ашигтай байдлаар тайлбарлаад л, хууль зөрчсөн юм шиг. Харин одоо өнөөдөр 11 цаг, 13 цаг хүртэл хугацаанд энэ асуудлаа шийдэхгүй бол ёстой жинхэнэ Үндсэн хуулийн зөрчил рүү орох гэж байгаа шүү.

Тийм учраас өнөөдөртөө багтааж Үндсэн хуулийн зөрчил үүсгэхгүйн тулд 13 цагтаа багтааж өнөөдрийн энэ санал хураалтаа эцэслэн нэг тийш нь шийдэх ёстой шүү. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Өчигдөр өглөөнөөс хойш 24 цаг хамтдаа хүлээсэн 61 гишүүндээ баярлалаа. Ирээгүй байгаа нь тэгээд цагаа ч барьж чаддаггүй, ажилдаа ч ирж чаддаггүй, өргөсөн тангаргаа ч мартдаг юм байна. Томилогдох болохоороо 28 цаг. Бүгдийг сайхан болгоно, бүх асуудлыг шийднэ, цалин нэмнэ, тэтгэвэр нэмнэ гэж ярьж ярьж байгаад үүрээр томилогдоод явдаг. Байнгын хороон дээр ажлыг нь үргэлжлүүлж хийе. Хүрч ирээд та хэд маань дахиад тайлбараа тавиач гэхээр ирдэггүй юм байна. Би хууль тогтоох засаглалд орж ирээд 1 жил болж байна. Би Монгол Улсыг хөгжинө гэж итгэдэг. Залуучуудын ирээдүйг хүсэж байгаа. Ийм олон жил Улсын Их Хурлын гишүүн хийгээд, хууль тогтоогоод, давхар дээлийг хэд хэдээрээ нөмөрч өмсөөд хэдэн удаа сайд хийсэн юм. Багш, эмч нарын цалинг нэмсэн юм уу. Гутарч байна.

2025 оны 6 сарын 17. Би та бүхэнд төрийн сайдын сэнтий бол хүрэх цэг бус эхлэх цэг гэж хэлж байсан. Сүүлийн 2 долоо хоног та бүхэн шалтаг л ярилаа. Шийдэл ерөөсөө ярьсангүй. Сарын өмнө багш, эмч нарын цалин, тэтгэврийг нэмэх боломжгүй гэж орж ирж байсан. Уржигдар 15-20 хувь нэмнэ. Тэвчиж чадах зардлаа тэвчинэ гээд ороод ирж байна. Анхнаасаа тэвч л дээ. Багш, эмч нар, тэтгэврийн хөгшчүүд бүгд тэвчиж байгаа шүү дээ. Өдөр болгон тэвчиж байгаа.

Гэтэл урсгал зардлаа 10 хувь танаад, цалинг нь нэмэх орон зайг нь гаргалаа. Бид сайн ажиллах гэж байна. Одоо бид нарт шийдэл байна гэж ороод ирдэг ямар их шалтаг вэ. Энэ сэнтийдээ ямар их хайртай юм.

Хоёр асуулт байна. П.Сайнзориг гишүүнээс 1 дүгээр заалттай холбоотой. Энэ ер нь гүйцэтгэх засаглал давхар дээлээ өмсөөд яваад 76 гишүүнтэй парламент хөгжих боломжгүй байсан юм гэж одоо харж байна. Ахын дүү чуулгандаа битгий ир, ирцдээ битгий ор гээд сүүлийн 2, 3 хоног тал талаас хэлж байна. Бүх давхар дээлийг болиулах ёстой юм биш үү. Ерөнхий сайд нь дураараа гарч ирээд сайдыг нь томилоод. Хууль тогтоож байгаа засаглалыгаа тоодог ч үгүй.

Үүнийг цаашдаа яаж засвал зүгээр юм. Үндсэн хууль дээр энэ нь уг нь тусгасан байгаа юм уу? Та үүнийг нэг товчхон тайлбарлаж өгвөл зүгээр байна.

Хоёр дахь Батнайрамдал гишүүнээс асууя. Оюу толгойн гэрээг бид ямар боломжийг алдаад байгаа юм? Засаг сүүлийн 100 хоногт их ажил хийлээ гээд л тайлагнаад байдаг. Юуг урагшлуулсан юм? Ямар явц гарсан юм? Тэр дээр та Түр хороог даргалж байгаа хүний хувьд явцыг хэлж өг.../минут дуусав./

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн эхлээд асуултад хариулъя.

П.Сайнзориг: Би ч тэгээд товчхон хариулъя даа. Монголын ард түмэн бүгд харсан. Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ парламент руугаа халддаг энэ тохиолдлыг 1992 оны Үндсэн хуулиас хойш анх удаа харж байна. Арай ч өмнө нь бужигнана бужигнана гэхэд ийм зүйл бол болж байгаагүй. Яах аргагүй энэ 76 биш 126 болж тэссэндээ Засгийн газрын атгад орсонгүй. Засгийн газрын гишүүдийн буюу өөрсдийгөө бид нарын ах гэж хэлээд байгаа хүмүүс камерын өмнө нэг өөр, камерын цаана бол нэг өөр. Үнэхээр хэцүү. Одоо Лувсанжамц гишүүний хэлж байгаа үнэн. Янз янзаар дарамталдаг. Тэгээд яах вэ, би энд зарчим л ярих гэж ирж байгаа учраас үүнийг энд хүргээд зогсёё.

Өнөөдөр төрийн эрх барих дээд байгууллага бол Улсын Их Хурал. Энэ бол ард түмний төлөөллийн байгууллага. Эндээс Засгийн газар бүрэлдэж байгаа шүү. Засгийн газар энэ дээр хууль хэрэгжүүлэх үүргээ тайлагнаж байгаа. Гишүүд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд ийм үндэслэлүүд байна гэдэг зүйлийг гаргаж тавиад үүнийг кнопоороо л шийдэх ёстой. Бүхэл бүтэн төрийн институтийг ард түмэнд ингэж муухай харагдуулах, төрд итгэх иргэдийн итгэлийг уланд нь гишгэх, ер нь цөөхөн хүмүүс засагладаг юм гэдэг зүйлийг харуулах ийм л оролдлого боллоо. Ер нь би хувьдаа бодсон. Энэ манай Үндсэн хуулийн эрх зүй, улс төрийн хичээлүүд энэ тэр дээр бол их сонин кэйсүүд гарах байх. Засгийн газар нь анх удаа Улсын Их Хурлаа бүрэн бүрэлдэхүүнээрээ бойкотолж, халдаж, парламентыг дээгүүр гишгэж болно гэдэг үйлдлийг харуулсан.

Дээрээс нь Үндсэн хуульд байсан суурь зарчмуудыг ерөнхийдөө үгүйсгэсэн. Үүнийг бид л манах гэж ирсэн шүү дээ. Хүнийг хүн алсан гэж гүтгэхээд маргааш нь хариуцлагын асуудал ярьдаг юм байна. Ямар аймшигтай юм бэ. Энэ 1937 оны үед л хэлмэгдүүлэлтийн үе эхэлж байсныг буцааж авчрах гэж байгаа юм уу даа. Бид 1992 оны Үндсэн хуулиараа ийм зүйлийг л устгах гэж, энэ ногоон малгайтнуудыг дахиж сэргээхгүйн төлөө явсан шүү дээ. Тэгээд ийм зүйлүүдийг Засгийн газар ашиглаад тэр хүнээ Хууль зүй, дотоод хэргийн сайдаар тавина гээд. Энэ бол одоо бүр шившиг болсон байхгүй юу. Би энэнээс ичиж байгаа юм. Энэ үйлдэл дээрээ дүгнэлт хийх хэрэгтэй. Бид хэд бөөнөөрөө л энэ асуудлаа шийднэ.

Тэгээд хамгийн гол нь энд дотроо л шийдэх ёстой шүү дээ. Тэгээд энэ дотроо орж ирээд л шийд. Магадгүй зарим бид хэдийн гаргаж байгаа санал үндэслэлгүй байж болж магадгүй. Үүнийхээ тайлбараа хэлээд л мэтгэлцэх ёстой. Ийм л зүйл. Тэгээд бид хэд өнөөдөр бүх зүйлээ энэ шившигийн хөндийгөөр чирч дууслаа. Өнөөдөр харамсалтай энэ зүйлүүдээс болж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 гишүүнийгээ нэг доор ярих гэж байгаад энэ бол төрийн эмгэнэл болж хувирна цаашдаа. Дахиж ийм зүйл битгий гараасай гэж бодож байна. Тэгээд яах вэ, ер нь Үндсэн хуулийг байн байн өөрчлөх боломжгүй.

Тийм учраас тогтвортой үзэл санаа зарчим, энэ мөн чанарыг нь бид хадгалж явах ёстой юм, өнгөлж явах ёстой юм, тордож явах ёстой юм, хамгаалж явах ёстой юм. Энэ Үндсэн хууль парламент ёсыг хамгаалахын төлөө өнөөдөр гишүүд тэмцэж байгаа шүү. Зогсож байгаа шүү. Шөнө өдөргүй энд сууж байгаа шүү.

Х.Булгантуяа: Батнайрамдал гишүүн нэмж хариулъя.

О.Батнайрамдал: Гарын үсэг зурсан гишүүн учраас асуултад хариулах боломжтой гэж ойлгож байгаа.

Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Оюу толгойн алдагдсан боломж ярих юм бол хэдэн тэрбум доллар яригдана шүү дээ. 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаас хойш яг 16 жил өнгөрсөн. 16 жилийн ой 7-хон хоногийн өмнө болж өнгөрч байгаа. Занданшатар Ерөнхий сайдын Засгийн газар 2025 оны 6 сарын 18-нд эмхлэн байгуулагдсан юм байна. Зээлийн хүү бууруулах Рио Тинтоогоос хариу нь 2025 оны 5 сарын 30-нд ирсэн байсан юм шүү. Гэтэл Засгийн газар дээр байгуулагдсан ажлын хэсэг нь дөнгөж сар гаруй хугацааны өмнөөс л дөнгөж ажлаа эхэлсэн шүү дээ. Одоо бид бүгдийг нь хийсэн юм шиг ярих та нар эрх байхгүй шүү.

Х.Булгантуяа: Лувсанжамц гишүүн нэмж тодруулъя. Нөгөө тусгайлан нэр зааж асуусан учраас.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Эс үйлдэхүй хийгээд л яваад байсан гэдгийг та бүхэн харлаа. Маш тодорхой хариултуудыг өгч байна шүү дээ. Би асуултаа асууя сайд нар аа. Их даапаалдаг юм байна. Залуу хүн байна, чи мэдлэггүй юм байна, туршлагагүй юм байна, ах нарын нөлөөнд ордог юм байна, орох юм байна гэж хараад ажилдаа битгий ир ч гэх шиг тийм ээ. Би хэнээс ч хараат бусаар өөрийнхөө зарчимдаа үнэнчээр шийдвэр гаргах мэдлэгтэй. Би зарчимтай. Та хэдтэй би хэрүүл хийдэггүй. Би дандаа л зарчмын шаардлага тавьдаг.

3 дугаар заалт АМНАТ-ын тухай асууя. АМНАТ дээр энэ Засгийн газрын тогтоол гарснаас хойш хэдий хэмжээний орлогыг бид төсөв дээр бүрдүүлж чадах байсныгаа алдсан юм бол?

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Яах вэ, би бас төрийн нууцад хамаарахаас бусад бүх мэдээлэл ил тод байгаа учраас надад бас шударга албан хаагчид бичиг явууллаа. Татварын ерөнхий газар Засгийн газрын 55 дугаар тогтоол Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчсөн гэдгээ Сангийн яаманд мэдэгдсэн байна. Өнөөдрийн байдлаар сар бүр 8 тэрбум төгрөгийн алдагдал АМНАТ-ын орлого орохгүй байгаа. Цаашдаа хамгийн багадаа 29.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт АМНАТ-ын орлого орохгүй, компаниудын орлого нэмэгдэх юм байна гэдэг зүйлээ хүлээн зөвшөөрсөн байна. Энэ бичиг нь өчигдөр Сангийн яаманд очсон байна лээ. Жавхлан сайд бол үүнийг тэмцсэн юм байна лээ. Жавхаа сайд энд тооцооллоо гаргаад болохгүй шүү. Энэ 50 тэрбумын АМНАТ-ын орлого улсын төсөвт орох орлого тасрах гээд байна гээд Жавхаа сайд бол бас зарчмын байр суурийг 2 удаа ч илэрхийлсэн байна лээ шүү дээ. Тэгээд үүнийг нь хүчиндээд гаргасан юм байна лээ. Энэ нөгөө цөөхөн эрх

ашигтай буюу 3, 4-хөн компанид байхгүй юу. Тэгээд жишээ нь биржийн бус арилжаа хийсэн “Эрдэнэс Тавантолгой” 1.8 их наядаас... /минут дуусав/

Х.Булгантуяа: Лувсанжамц гишүүн нэмж тодруулъя.

Г.Лувсанжамц: Сая чухал тоог та хэлэх гэсэн чинь цаг нь дууслаа. Сайнзориг гишүүн та хэдэн тэрбум төгрөг бид авч чадахгүй алдсан юм бэ гэдэг тоог тодруулж хэлж өгмөөр байна. Өнөөдөр Г.Занданшатар Ерөнхий сайдын Засгийн газар үргэлжилнэ үү, үргэлжлэхгүй байна уу хамаагүй. Та бүхэн Их Хуралд ажлаа тайлагнадаг тийм байгууллага шүү. Байнгын хороогоо тасалдаг. Асуулт асуухаар хариулдаггүй. Бичгээр асуулт явуулсан ч хэдэн сараар таг алга болдог. Гүйцэтгэх засаглалаас бид үр дүнг л нэхэж байгаа. Шинэ үе юм мэдэхгүй юм байна. Жоохон залуу улс төр мэдэхгүй байна гэж их ярьдаг юм байна лээ. Хувийн хэвшил дээр байдаг зарчмыг л би та бүхнээс нэхэж байгаа. Та бүхэн татвар төлөгчдийн мөнгөөр цалинжиж байгаа шүү.

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Би үүнийг одоо урьд нь бүр маш их анхааруулсан байхгүй юу. Тэгээд Дээд шүүхийн тогтоолыг барьж байгаад гэдэг нь зөвхөн Дээд шүүх бол жонш дээр гаргасан. Жоншны шийдвэрийг зүгээр Захиргааны ерөнхий хуульд нийцүүлээд шинэчилж батлаарай гэдэг үүргийг далимдуулж байгаад нүүрс, төмрийг давхар оруулаад ингээд явсан.

Энэ мэдээж алдагдлын хэмжээ зах зээлийн эрэлт буюу үнийн өсөлтийн тэр зөрүүгээс шалтгаална. Тэгэхдээ урьдчилсан тооцоогоор Сангийн яам багадаа 50 тэрбум. Өнөөдөр Татварын ерөнхий газар нь өчигдөр Сангийн яаманд өгсөн мэдээлэл дээрээ энэ байдлаараа явах юм бол улсын төсөвт орж ирэх 29.6 тэрбум төгрөг тасрахаар байна гээд бичгээ ямар ч байсан даруухнаар өгсөн байна. Тоог нь бол дарж хэлж байгаа байх. Энэ орлого бол өснө. Харин орлого хаана, хэнд үлдээд байна гэхээр цөөхөн хэдэн компаниуд дээр үлдэж байгаа. Би тэгэхдээ үүнийг буруутгахгүй. Үүнийгээ харин хууль тогтоомжийн дагуу зөв болгох ёстой болохоос биш огт хууль дээр байхгүй дүйцүүлэн тооцох байдлаар АМНАТ-ыг тооцож болохгүй юм. Энэ байгалийн баялгаасаа хүртэх ард түмний үр өгөөжийг ингэж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ингээд парламентын бүрэн эрхээ, парламентын халдашгүй байдлыг хамгаалж бүхэл бүтэн 24 цаг өнөөдөр чуулгандаа өдөр шөнөжингөө суусан энэ 31 гишүүдээ өнөөдөр баярлалаа гэж хэлье ээ.

Та бүхэн мэдэж байгаа 61 гишүүндээ баярлалаа гэж хэлье. Та бүхэн мэдэж байгаа өнөөдөр энэ асуудал юунаас үүдсэн бэ. Энэ уул нь зүгээр л нэг намын даргын сонгууль болсон манайхан. Энэ чинь зүгээр болдог л нэг сонгууль. Гэтэл өнөөдөр түүнээс хойш юу болов. Өдөр болгон ард түмнийг гайхшируулсан ийм үйл явдлууд боллоо шүү дээ. Яаж төр засгийнхаа үйл ажиллагааг гацааж болдог юм, яаж төрийн түшээдээс нь авхуулаад ард түмнийг айлгаж сүрдүүлж болдог юм гэдгээ жинхэнэ утгаар нь харуулсан ийм өдрүүд байлаа. Өнөөдөр хууль биш хүн

засаглах ямар аюултай юм бэ гэдгийг харуулсан өдөр байлаа шүү дээ. Парламентын засаглал ямар чухал юм бэ, ардчилал ямар чухал юм бэ гэдгийг үнэхээр ойлгуулж ухааруулсан ийм өдрүүд байлаа. Тийм ч учраас бид нар өнгөрсөн шөнө 24 цаг энэ парламентын яагаад гэвэл энэ улс орон парламентын засаглалтай. Бүх хүнийг айлгаж сүрдүүлээд байвал энэ улс орны тусгаар тогтнол юу болох юм бэ. Өнөөдөр зүгээр гаднын нэг сайт дээр хэвлэгдсэн ганц мэдээллийг үндэслээд бид нар төрийн гуравхан өндөрлөгөө айлгаж сүрдүүлээд байх юм бол энэ улсын тусгаар тогтнол аюулгүй байдал юу болох юм бэ.

Энэ бүгдийг хамгаалахын төлөө өнөөдөр Улсын Их Хурлын бүх гишүүд зогсох ёстой байсан. Харамсалтай нь 61 гишүүд өнөөдөр өргөсөн тангарагтаа үнэнчээр зогслоо гэж ингэж хэлмээр байна аа. Тэгээд өнөөдөр хар даа бүгдээрээ зүгээр нэг даргын сонгуулийг улс орныхоо үйл ажиллагааг гацаах хэмжээнд ортол нь даамжруулчихаад сууж байна. Би тэгээд Сайнзориг гишүүнээс асууя. Тэр АМНАТ-ын холбогдолтой Оюу толгойтой дээр маш том эрсдэл гарах ийм шийдвэрийг гаргачихсан Засгийн газар өнөөдөр сандал суудалтайгаа зууралдаад сууж байна шүү дээ. Тэгэхээр та тэрийг нэг маш тодорхой тайлбарлаад өгөөч.

Батнайрамдал гишүүнээс асууя. Өнөөдөр Оюу толгойтой гэдэг бол ард түмний өмч ард түмэн эндээс баялгаа хүртэх ёстой. Энэ дээр ямар аюул учирчихаад байгаа юм. Цаг хугацааны уралдсан ийм шийдвэр гаргах юмыг ийм ажлыг хийх ёстой юмыг Засгийн газар хийхгүй суугаад байгааг нэг товч бөгөөд тодорхой тайлбарлаад өгөөч ээ гэсэн ийм 2 асуултыг асууя.

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүний микрофон. Үгүй ээ би асуулт асууж байгаа гишүүнийг хэнээс асууж байгааг нь. Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Би хариулах цаг маань яваад байдаг. Оюу толгой компанитай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ байгаа. Хөрөнгө оруулалтын гэрээний 11.4 дээр байгаа. Засгийн газраас дотоодын аж ахуйн нэгжид өгч байгаа тааламжтай нөхцөлийг “Оюу толгойтой” компани болон түүний хамаарал бүхий этгээдүүд эдэлнэ гэдэг зүйл байгаа. Тэгэхээр энэ Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоолоор 25 хувиа биржээр зараад бусад байдлаар зарсан 75 хувиа 25 хувьд зарсан үнээр тооцож АМНАТ-аар тооцуулах энэ заалтыг Оюу толгой эдэлье гэх юм бол Лондоны биржээс татгалзах нөхцөл бүрдэх гээд байгаа юм. Лондоны металлын биржээр явахгүй ээ дотоодын биржээр чинь 25 хувиа зарчихъя. Лондоны биржээр зарсан 75 хувиа дотоодын тэр арай хямдаар зарснаар чинь тооцуулаад АМНАТ-аа төлье гэх юм бол Монгол Улсын эдийн засагт маш том хохирол учруулах эрсдэлийг Засгийн газар бодит үйлдлээрээ гаргасан. Энэ дээр “Оюу толгой” компани юм уу, “Рио Тинто” компаниас хүсэлт өгөх юм бол бид нар энийг нь ярьж авч хэлэлцэхээс өөр аргагүй. Ийм болчимгүй шийдвэрийг өнөөдөр гаргасан. Энэ тоглоом биш, тоглоом биш.

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээний 11.4-ийг гишүүд маань та бүгд хараарай. Энэ тоглоом биш. Энэ бүгдийг дандаа Засгийн газрын яамдаас болгоомжилж энэ татварын өөрчлөлтүүдийг маш болгоомжтой хийдэг байсан юм. Тэгээд уг нь суурь асуудлууд дээр дуугардаг буюу зарчмын асуудлууд дээр дуугардаг яамнууд нь зөвшөөрөөгүй байж байхад ийм тогтоол гаргаад нүүрс дээр тодорхой хэмжээний улсын төсөвт орох орлого буурахаасаа гадна “Оюу толгой” компани хөрөнгө оруулалтын гэрээн дээр цаашдаа татварын хөнгөлөлтүүдийг

Монгол Улсад ашиггүй байдлаар эдлүүлэх жишгийг тогтоож “Оюу толгой” компанид барьц өгсөн. Энэ бол маш ноцтой. Ийм л зүйл болсон товчхондоо хэлэхэд.

Тэгээд Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ цахим орчинд ил байж байгаа 11.4 дүгээр заалтыг бүгд харчхаарай тэгээд энэ бол би зүгээр өөрөө зохиож яриад байгаа зүйл биш. Энэ бол маш том эрсдэлтэй заалт байхгүй юу. Энийг барьцаж дандаа дотоодын аж ахуй нэгжид өгч байгаа бүх тааламжтай нөхцөлүүдийг эдэлнэ гэдэг зүйлийг “Оюу толгой” компани ярьдаг. Тэгээд энийг өнөөдөр бүрдүүлж өгсөнд туйлын харамсалтай байгаа. Энийгээ тийм учраас яаралтай засах хэрэгтэй байгаа юм.

Х.Булгантуяа: Батнайрамдал гишүүн нэмж хариулъя.

О.Батнайрамдал: Нэг л статистик хэлье. Рио Тинтод төлж байгаа Оюу толгой руу охин компани руугаа өгсөн зээлд бид нар өдөр бүр 10 тэрбум төгрөгийн зээлийн хүүг төлж байгаа шүү, 10 тэрбум. Өнөөдөр бид нар энд 24 цаг байхад бид нар 10 тэрбум төгрөгийн өртэй л боллоо гэсэн үг. Тэр битгий хэл нэг ноцтой зүйл хэлье. Рио Тинтогийн алдаанаас болж гаргасан нэмэлт зардал дээр бид нар хувь нийлүүлэгчийн зээлээр хүүтэй нь төлж байгаа шүү дээ. Иймэрхүү байдалтай байгаа байхгүй юу. Энийг засъя энийг би хэчнээн хэчнээн сар ярьж байна. Нөгөө талаас хэлэлцээрт сууя гэсэн. Сарын өмнө сайд нар нь би мэдэхгүй 2 компанийн асуудал шүү дээ. Надад падлийгүй гэсэн ийм юм ярьж байсан шүү дээ. Харин өнөөдөр та нар одоо тайлбартаа бид нар Оюу толгой дээр ийм ахиц дэвш гаргасан гэж хэлэх эрхгүй шүү. Энийг дахин цохож хэлье. Өнөөдөр нөгөө Оюу толгой нь хүртэл 2 удаа парламент нь дуудаад ирэхгүй ийм байна.

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүн нэмж тодруулъя.

М.Энхцэцэг: Сайнзориг гишүүний АМНАТ-ын асуудал дээр дахиад тодруулга авъя аа гэж бодож байна л даа. Маш олон хүмүүс энэ дээр үгүйсгээд байгаа. Тэр АМНАТ дээр дүйцүүлэх үнэ гээд таны яриад байгаа энийг маш олон хүмүүс эсэргүүцэж ярьж байгаа. Тэгэхээр энийг бас тодорхой тайлбарлаж өгөөч ээ. Юунаас болоод ингэж том алдагдал, улс орон хохирох, төсвийн орлого тасрах ийм эрсдэлд орчхоод байгаа юм бэ гэдгийг маш энгийн үгээр тайлбарлаж өгөөч ээ.

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Ашигт малтмалын хууль дээр ерөөсөө тодорхой байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортод гарвал буюу гадагшаа экспортолж байгаа тохиолдолд олон улсын зах зээлийн үнээр Биржийн бүтээгдэхүүний тухай хууль гарсан. Уул уурхайн биржийн бүтээгдэхүүний хууль гарсны дагуу биржээр зарагдсан тухайн өдрийнх нь зарагдсан үнээс нь 5 хувийн АМНАТ-аа аваарай л гэж үнэ байгаа. Гэтэл энэ 2 аргачлал нь өнөөдөр хүчин төгөлдөр байгаа мөртөө байхгүй дүйцүүлэн тооцох аргачлалыг гаргаж ирээд биржээр 25 хувиа зарчих аа бусад 75 хувиа биржийн бус аргаар зараад тэр нь өндөр үнэтэй байгаа мэдээж. Тэрийгээ биржээр зарсан доогуур үнэ дээр тооцуулж тэр хэмжээгээрээ АМНАТ-ыг тооцъё оо гэж байгаа.

Би ганцхан жишээ хэлье. 8, 9 сард “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1.8 их наяд төгрөгийн биржийн бус байдлаар зарагдсан нүүрс дээрээс Татварын ерөнхий газар 163.9 тэрбум төгрөгийн энэ хасалт, бууруулалт хийж байгаад АМНАТ тооцсон. Энэ нь улсын төсөвт орох ёстой 15.2 тэрбум төгрөг жишээ нь ороогүй байхгүй юу. Энэ байдал ингээд үргэлжлээд явж байна. Энийгээ хурдан засъя л гэдэг шаард.../минут дуусав./

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Энэ танхимд яг энэ Улсын Их Хурлын чуулганы яг энэ танхимд гишүүний тангараг өргөөд ингээд ажлаа хийж байх хооронд яг энэ танхимд болсон увайгүй, ёс зүйгүй 2 үйлдлийг би энд хэлмээр байна зориудаар. Одоо нэг нь сайд, нэг нь Төсвийн байнгын хорооны дарга.

Нэгдүгээрт төсвийн тодотгол хэлэлцэж байх үед Энхбаяр сайд Ардчилсан намын нэг сайд руу нүдээ ирмээд Мандхай гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал буюу хоршоодтой холбоотой саналыг унагаж байсан. Унагасныхаа дараа хоёулаа хоёр биен рүүгээ эрхий хуруугаа гаргасан, нэг.

Би тэндээс ямар ойлголт авсан бэ гэвэл манай сайд нар намтайгаа, бүлэгтэйгээ асуудлаа ярьдаггүй юм байна аа. Би Ардчилсан намын хүнийг нь хэлсэнгүй зориуд. Хэрэггүй байх гэж бодож байна. Тийм. Тэгэхээр би энийг зориуд намынхаа, Монгол Ардын намынхаа сайд нарт зориуд хэл хэлж байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт дөнгөж сая Төсвийн байнгын хорооны дарга Ганхуяг гишүүн яг сайд нартай адилхан байр суурь илэрхийлээд эндээс орилоод. Уг нь Төсвийн байнгын хорооны дарга чинь Их Хурал талдаа байгаад төсвийнхөө асуудалд засаг руугаа шүүмжлэлтэй хандаад асуудлаа ярих ёстой байтал засагтайгаа ингээд холилдоод, орооцолдоод хамтдаа нэг талдаа гарчихсан. Бид нар яагаад ийм хил хязгааргүй байдаг юм. Яагаад ингэж улаан шугам давах ёсгүй хил хязгаараа давдаг юм. Гишүүний мөнгөний асуудал чинь яг л энэ адилхан шүү дээ. Тойргийн мөнгөний асуудал гэдэг чинь. Бид нар хамгийн гол нь шинээр сонгогдсон гээд байгаа юм. Гэхдээ бид нарыг та нар залуу гэж магадгүй. Гэхдээ л бид нар өөрсдийн гэсэн туршлагатай, хангалттай мэдлэгтэй, боловсролтой ийм хүмүүс. Та нар энэ увайгүй ийм хөгийн үйлдлийг чинь хараад бүүр яг үнэндээ үнэхээр жигшдэг юм шүү дээ. Зүгээр л энэ мэт үйлдлээ л боль гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 2 увайгүй үйлдлийг би зориуд хэлж байгаа юм.

Гуравдугаарт өчигдрөөс хойш багш нар ажил хаялт зарласан хугацаагүй. Гэтэл өнөөдрийг хүртэл багш нарын ажил хаялттай холбоотой нэг ч байр сууриа илэрхийлсэн сайд байхгүй. Жагсаалыг эсрэгээр нь бараг бид нарыг турхирсан гээд ярьж байдаг. Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль чинь өөрөө тусдаа хуультай л даа. Ажил хаялт явтал маш удаан процесс явагддаг. Дахиад сайд нар дахиад вакумжиж эхэлсэн. Органикаараа явж байгаа жагсаалыг дахиад л нэг хэн нэгний хийж байгаа ажил мэт харагдуулж эхэлсэн гэсэн үг. Би нэмж асуулт асуух ёстой байгаа. Тийм учраас нэмэлт тодруулга 1 минутаа авъя.

Х.Булгантуяа: Баасанжаргал гишүүн нэмэлт 1 минут.

Х.Баасанжаргал: Төсвөөс бид нар юу хүссэн бэ гэвэл хүний амьдралд ямар өөрчлөлт гарах юм бэ гэдгийг л харах гээд байгаа юм. Тэрнээс биш энд тэнд тийм үйл ажиллагаа хийнэ, ийм зардал гаргана гэдэг зүйл ерөөсөө биш. Тэр зардлыг гаргаснаараа өнөөдөр миний амьдралд ямар өөрчлөлт гарах юм, миний хүүхдүүдийн амьдралд ямар өөрчлөлт гарах юм, Завхан аймагт амьдарч байгаа иргэний амьдралд ямар өөрчлөлт гарах юм бэ гэдэг тэр үр дүнг л хардаг тийм төсөв байгаасай гэж өнгөрсөн жилээс хойш манай гишүүд энэ дээр дуу хоолойгоо илэрхийлж ирсэн. Юу ч өөрчлөгдөөгүй орж ирсэн. Одоо бид нар өөрсдөө энэ төсөв дээр ажиллаж байгаа байхгүй юу.

Асуулт Сайнзориг гишүүнээс тодруулъя. Та сая гишүүдийн чат групп дээр, бас бүлгийн групп дээр бичиг тавьсан. Энийг үр дагаврыг нь тодорхой тайлбарлаж өгөөч? Энэ бичиг яагаад одоо гарч байгаа юм? Яагаад урьд нь Засгийн газар шийдвэр гаргахаас өмнө яагаад энэ бичиг гараагүй юм бэ? Яагаад?

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн тавьсан бичгээ тайлбарлана уу гэж байна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Үгүй ээ тавьсан бичиг ч гэж дээ. Төрийн нөгөө нууцад хамаарснаас бусад юм чинь ил тод учраас энэ мэдээллүүдийг л тавьж байгаа юм. Тэгээд энэ шийдвэрийг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дэмжээгүй байхад баталсан байхгүй юу. Тэр дор нь яах вэ Жавхаа сайдыг ч юм уу Сангийн яамыг л жоохон шахалтад оруулсан юм шиг байгаа юм. Тэгээд нэг ийм дундуур нь бичиг хийж өгөөд засаг баталсан юм байна лээ. Тэгэхдээ энийг зүгээр цааш нь даамжруулахгүйгээр уг нь засъяа гэж байгаа юм. Миний энэ цаг бага байгаа учраас яах вэ нэг зүйлийг л хэлмээр байна. Уг нь аж ахуйн нэгж байгууллагуудаа яг тэр бодитой АМНАТ-ыг нь тогтоож өгөх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдээд өгчих юм байгаа юм.

Одоо манай жишээ нь төмөр энэ тэр дээр АМНАТ-ыг тооцохдоо Тяньжиний боомтоор авч байгаа нь буруу байхгүй юу. Тэрийг илүү их наашлуулаад хамгийн олон улсад ойрхон зах зээлийн боомт чинь ерөөсөө Эрээн, Мандал, Ганцмод байгаа шүү дээ. Гэтэл өнөөдөр биржээр жишээ нь нүүрс 90 доллароор зарагдаж байхад Ганц мод дээр 130 хэдтэй байгаа байхгүй юу. Яах вэ мэдээж тээвэр орно. Хятадын татвар орж байгаа. Тэгэхдээ энэ Монгол төрийн бодлого шүү. Бид ямар арга зүйгээр энэ байгалийн баялгийнхаа үр өгөөжийг тэр компаниуд олборлосны төлөө авах гэж байгаа төлбөрөө бид нар тогтоох аргачлал нь энэ бид нарын бодлогын асуудал Монгол төрийн.

Тэгэхээр энийг шударгаар, ил тодоор, компаниудтай, харилцан ашигтай байдлаар л шийдэж өгөх ёстой хуулийн хүрээнд. Үнэхээр энд АМНАТ-ыг төлж чадахгүй бол тэр компаниуд энэ тусгай зөвшөөрлөө өгөх хэрэгтэй. Дараагийн энэ тусгай зөвшөөрлийг нь аваад ажиллуулъя гэдэг байгууллагууд нь байгаа байхгүй юу. Яагаад ингэж ард түмний баялгийг цөөхөн хэдэн компаниуд, цөөхөн хэдэн хүмүүс ховх сорих ёстой юм бэ? Энийгээ сүүлдээ ингэж лиценз хэлбэрээр авчхаад одоо сүүлдээ ингээд АМНАТ-аа хөнгөлүүлж авдаг ийм юм руу орлоо шүү дээ. Энэ шийдвэрийнхээ үр дагаврыг ерөөсөө тооцоогүй байж байтал Оюу толгойтой хүртэл ингээд авцалдахаар гарсан. Тэгээд би яах вэ Засгийн газарт өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд асуулга тавьсан байгаа. Энэ асуудлыг яаралтай шийдээч ээ, үр

дагаврыг нь томрохоос өмнө цаасаа яаралтай шийдээч ээ гэхээр арга хэмжээ авахгүй байгаа.

Тийм учраас огцруулах үндэслэл дээрээ бичсэн. Тэгээд энэ Сангийн яаманд өгч байгаа энэ татварын тайлбар юм байна лээ. Үнэхээр одоо энэ байдлаар явбал энэ чинь улсын төсөвт орох ёстой. АМНАТ-ын орлогууд буурахаар эрсдэлүүд үүсчихлээ. Бодит эрсдэл нь 8 сард ийм байна аа. 9 сард 8 тэрбум байна аа. Энэ байдлаар явбал 29.5 тэрбум төгрөгийн алдагдал гээд яах вэ их л даруухнаар бичээд байна. Тэгэхээр ийм зүйл байж болохгүй байхгүй юу даа. Тэгээд хамгийн нөгөө бага үнэтэй байгаа дээр баахан цаасан дээр нүүрс зарах гэж байна шүү дээ. Энэ нүүрсийгээ энэ жил гаргаж чадахгүй, дараа жил гаргана. Хил гааль нь ингээд бөглөрнө. Дараа жил нүүрс өсөхөөр бид нар яг шинэ зах зээлийг олж юм уу, шинэ гэрээгээр борлуулсан нүүрсээ аваачиж өгч чадахгүй байхгүй юу. Ингээд Монгол Улсын төсөвт орох энэ үр өгөөжүүд байхгүй болох юм аа, ийм хортой шийдвэрийг гаргасан учраас энийгээ яаралтай засаад өгөөч ээ л гэдэг зүйлийг би зарчмын хувьд тавиад байгаа байхгүй юу.

Х.Булгантуяа: Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Бид нар яагаад энэ АМНАТ болоод Оюу толгойн асуудал дээр ингэж нэгдмэл байр суурьтай байгаа вэ гэвэл бид нар олох ёстой байгаа, байсан орлогоо цалин, тэтгэврийг нэмэх боломжтой байгаа тэр нөөцөө Засгийн газар бүрэн дүүрэн ашиглахгүй байна аа л гээд байгаад гол асуудал байгаа юм.

Дахиад нэг увайгүй үйлдэл хэлье. Манай бүлгийн зарим нэг гишүүдийн зүгээс цалин, тэтгэврийг нэмэх гэдэг шийдвэрийг гаргахдаа дахиад улс төрийн акц хийж бүлгийн даргыг солих ийм акц доор цалин тэтгэврийг нэмж байгаа гэдэг сайхан мэдээ дуулгаж байгаа мэтээр ийм улс төрийн акц хийсэн хүмүүсийн цалингаар. Дахиад шүүхийн шийдвэрээр дахиад улс төрийн акц хийсэн. Тэр Дээд шүүхийн шийдвэр чинь жонштой холбоотой асуудал байсан шүү дээ. Тэгээд л тэрийг далимдуулаад л ийм улс төрийн акц хийгээд л өөрсдөдөө хэн нэгэнд давуу байдал олгоод байдаг. Энийгээ яагаад болихгүй байгаа юм. Энэ нөөцөөр бид нар цалин тэтгэвэр нэмэх боломжтой.../минут дуусав./

Х.Булгантуяа: Хэн хариулах вэ? Сайнзориг гишүүнээс гэж байна.

П.Сайнзориг: Ер нь тийм ээ тийм. Би тэгээд халаглаад байгаа чинь л энэ. АМНАТ гэдэг бол бид нарт энэ Монгол Улсын эдийн засаг ерөөсөө уул уурхайгаас хамааралтай байгаа шүү дээ. Эдийн засгийн бүтцийн хувьд 90 хувь уул уурхайн хамсаатай. Тэр дундаа нүүрс, зэсээс. Тэгээд энэ дээрээс авч болох АМНАТ-ын орлогоо бууруулж ард түмэн буюу эмч, багш нарынхаа цалинг тавих ёстой мөнгийг ингээд компаниудад нь үлдээнэ ээ гэдэг зүйл бол байж болохгүй ээ. Магадгүй тэр Эрдэнэс Тавантолгой дээр 163.9 тэрбум төгрөгийн бууралт хийж байгаад АМНАТ-ыг тооцож авсан байгаа. Тэр 163.9 тэрбум төгрөгөөр ашиг сонирхолтой этгээдтэйгээр шатахууны гэрээ хийсэн байхыг үгүйсгэхгүй байгаа шүү дээ. Ерөөсөө л энэ. Тэгээд энэ багш, эмч нарын цалин тавих эх үүсвэр буюу энэ Орон нутгийн хөгжлийн санд орох ёстой, Баялгийн санд орох ёстой мөнгө яагаад ингэж хулгайд алагдаад байгаа юм бэ? Яагаад энэ хулгайд алдагдах боломжийг хууль тогтоомж зөрчиж олгоод байгаа юм бэ? Энийг нь хэлээд яаралтай засчихын оронд энийг.../минут дуусав./

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай.

Н.Алтаншагай: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 24 цагийн хугацаанд Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага парламент маань яаж үнэгүйдэж хүчгүйдэхийг харлаа. Тэгээд алдах юмтай, айх юмтай ийм нотой нөхдүүдийн маань зүгээр хонь болгодог юм байна шүү дээ. Нөгөө нөхдүүд маань ордон руу орж ирж чадахгүй, чуулгандаа сууж чадахгүй. Өдөржингөө туулайчилж байгаа шүү дээ. Кофе барьцан л тойроод гүйгээд байдаг. Эгцэлж харж чадахгүй. Чуулгандаа суугаач гэхээр суудаггүй. Ийм нөхцөл байдлыг бид бүхэн яг бүгдээрээ харлаа, мэдлээ, мэдэрлээ шүү дээ. Нийгмийн олон асуудлууд шил шилээ даран хүлээж байна гээд байна. Яг сүүлийн 1 сар бид бүхэн зүгээр яг хэрүүл дунд байлаа шүү дээ. Өнгөрсөн жил бид бүхэн иргэдээсээ сонгогчдоосоо гуйж, гуйж, Их Хурлын гишүүн болж энд орж ирээд тангаргаа өргөөд л шүлс нь хатаагүй байгаа шүү дээ. Багш нар нь, эмч нар нь ажил хаячихсан, ахмадууд маань тэтгэврээ нэмүүлэхээр гудамд гараад суучихсан, аж ахуйн нэгжүүд нь энэ татварын реформ, энэ хөнгөлөлтүүдээ хийж өгөөч гээд нүдээ ширгэтэл харж байгаа шүү дээ.

Тэгээд ийм бодит нөхцөл байдал тулгарчихсан байхад ингээд зарим нэг нөхдүүд маань бүр улам л өнгөлөг болоод л, улам л тарган болоод л, хацар нь цулцайгаад л, инээд нь хүрээд л. Та нарт инээдэмтэй байж болно оо. Ард түмэнд ханиадам байгаа шүү. Нийгмийнхээ сэтгэл зүй рүү, нүд рүү нь нэг өнгийгөөд харвал маш аймшигтай дүр зураг байгаа. СХД-ийн олон сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид ажил хаяж байна. Зарим нь утсаар холбогдож байна. Архины хамааралтай аав, ээжтэй хүүхдүүд маань цэцэрлэгтээ ирмээр байна аа, гэртээ хариад хоол байхгүй гээд уйлаад байхад бид бүхэн үнэхээр ажлаа хаяж чадахгүй байна гээд уйлаад ярьж байна шүү дээ.

Энийг өмнө нь төсөв хэлэлцэхэд оруулж ирж болох л байсан шүү дээ. Бид нар яагаад оруулж ирээгүй юм. Ерөнхий сайдыг томилогдож байхад би анх ороод хэлж байсан. Гишүүдтэйгээ уулзаарай, тойрог тойргоор нь уулзаарай, саналыг нь аваарай, төсөвтөө тусгаарай гээд. Наадмын дараа нэг төсөв дээр санал авч байгаа гээд хэлсэн, саналаа өгсөн. Бүүр ямар ч санал тусгагдаагүй. Тэгээд жил болгон л төсвөө боож оруулж ирээд шидчихдэг. Энэ дээр тэгээд л тал еэвэнгийн үлгэр шиг юм ярьсаар байгаад л бид бүхэн батлаад л явуулж байгаа шүү дээ. Үр дүн байхгүй. 35 жил энэ иргэд чинь хүлээж байна шүү дээ. Баянхошууныхан хүлээж байна, Дарь эхийнхэн хүлээж байна. Амьдрал нь яг л бахь байдгаараа. Бодлого, шийдвэр нь энэ хаалгыг нь давж гэр рүү нь орж чадахгүй байна шүү дээ. Нийгмийн баталгаа нь сайжирч чадахгүй байна шүү дээ.

Тэгэхээр энэ ард иргэд чинь бухимдалгүй яадаг юм, шахалгүй яадаг юм. Энийгээ бид бүхэн онцгойлон анхаарах хэрэгтэй байна. Тэгээд Ерөнхий сайдаас асууж байгаа юм. Яагаад гишүүдээс санал авч тусгаж болдоггүй юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь цалин, тэтгэврийг нэмэх асуудлыг төсөв өргөн барихдаа яагаад шийдэж болоогүй юм. Энэ дээр хариулт авъя.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Алтаншагай гишүүнд баярлалаа. Үг хэлэх боломж олгосон явдалд. Парламент бол нотлогч, няцаагч хоёр талын мэтгэлцээний талбар байх ёстой. Энэ хэрүүлийн танхим биш. Мэтгэлцээний талбар байхыг бид зорьсон. Ингэж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Ийм ч зорилгоор 126 гишүүнтэй болох санаачилгыг анх 2019 онд гаргаж 108 гишүүнтэй болгох санаачилга дэвшүүлж байсан боловч хэрэгжүүлж чадаагүй. 2023 онд гүйцээж хийсэн. Харамсалтай нь өнөөдөр бол дэглэсэн жүжиг шиг хуйвалдааны шинж чанартай огцруулах гарын үсэг зурсан нь огцруулах гарын үсэг зурснаасаа асуугаад ингээд няцаах, нотлох боломжгүйгээр ийм мэтгэлцээн өрнөж байгаа. Өрнөж байгаад гайхаж байна.

Нэгдүгээрт түрүүн Лувсанжамц гишүүн ч гэсэн асуусан. Яагаад цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж болоогүй юм бэ гэж. Засгийн газар хууль биелүүлэх үүрэгтэй. Засгийн газарт олгогдсон хүрээ хязгаарын хүрээнд бид төсвийн төслийг боловсруулдаг. Энэ төсвийн төсөлд Улсын Их Хурал урсгал зардлыг 24 хувиас хэтрүүлж болохгүй ээ гээд заачихсан. Саяын хэмжээгээр нэмэх юм бол ДНБ-д эзлэх урсгал зардлын хэмжээ 25, 26 хувь болж нэмэгдэхээр байсан. Бид арайхийж төсвийн тодотголоор энэ 26-г 24 болгож бууруулсан байсан. Тэгэхээр бид энэ төсвийг хэлэлцүүлэхийг эхний ээлжид энэ жилийн төлөвлөгөөтэйгөө нийцэж байна аа гэсэн санал хураалт явуулах ёстой. Жилийн төлөвлөгөөтэйгөө нийцэж байна гэж санал хураалт явуулбал бид хоёрдугаар хэлэлцүүлгээр энийг нэмэх бололцоог үүсэх байсан.

Гэтэл энийг ерөөсөө хэлэлцээгүй өдий хүрсэн. 6 цаг боллоо. Хөдөлмөрийн хууль боллоо. Шөнө орой хэлэлцэхээр хулгай хийх гээд байна гэж ард иргэд хардаад байна гээд л 6 цаг гэж таслаад л ингээд явсаар. Тийм учраас эхлээд төсвийн төлөвлөгөөнд нийцэж байна гэсэн санал хураалт явуулсны дараа энэ төсвийн хязгааруудаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төлөвлөгөөнд заасан тэр 24 гэсэн хязгааруудыг эхлээд тэр хүрээнд төсвийн төслийг боловсруулах үүрэгтэй учраас Засгийн газар тэрийгээ авчихвал энэ төсвийг цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх боломжийг бүх талаар гаргая гэж ингэж Төсвийн байнгын хороон дарга, Эдийн засгийн байнгын хороон дарга, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга нартай ойлголцоод бүлгийн хуралд танилцуулах гэсэн боловч олонхоороо хуралдаагүй. Хуралдаад ингээд ийм боломж байна гэдгийг, бид ийм шийдэл гарц байна гэдгийг Улсын Их Хуралд танилцуулъя гэж шийдвэрээ гаргаж танилцуулсан.

Хоёрдугаар асуудал энэ ташрамд хэлэхэд Оюу толгойн асуудал ч гэсэн Батнайрамдал гишүүнийг би дуудаад Онтрэгийн асуудал ярьж байхад зээлийн хүүгийн асуудал хамгийн гол нь байгаа юм. Энэ чинь Монголын талыг ашиггүй ажиллуулаад байгаа юм. Энэ дээр анхаарал төвлөрч ажилла. Бид нар энд ажлын хэсэг гаргаад ажиллаж байна. Бид бүүр 7 сарын эхээр ажлын хэсэг байгуулсан. Бид нар энэ олон улсын гэрээ, хэлэлцээрийн асуудлыг чинь нээлттэй зарлаад яв явдаггүй. Тэгээд өнөөдөр бид нар саяхан Оюу толгойтойгоос бидний саналыг хүлээж, шаардлагыг хүлээж аваад зээлийн хүүгээ бууруулах хэлэлцээр эхэлсэн ийм баяртай мэдээ сонсож байгаа. Энэ түүхэн бол бодит шийдвэр болж байгаа. Та бүхэнд нэг баяртай мэдээ дуулгая. Дандаа хэрүүл шуугианы дундуур өчигдөр Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулж Монгол Улс 20 жилийн өмнө байсан “B+” зэргэлдээ орлоо. Энэ бол Засгийн газрын бодит ажлуудын үр дүн. Энэний чинь үр дүн дээр Оюу толгойн зээлийн хүүг бууруулах

бодит ажил хийж ард түмэнд үр өгөөжтэй болно. Энэ АМНАТ өмнө нь Засгийн газар 10 удаа ийм журам оруулж өөрчилж байсан. Хууль, дүрэм зөрчсөн байхгүй бол хангалттай тайлбарууд нь явчихсан. Нэг талын мэдээлэл өгөөд ард иргэдэд, нэг талын мэдээллээр гуйвуулах явдал бол буруу.../минут дуусав./

Х.Булгантуяа: Алтаншагай гишүүн нэмж тодруулах уу? Алтаншагай гишүүн нэмж тодруулъя.

Н.Алтаншагай: Энэ 24 хувь гээд яригдаад байгаа. Улсын Их Хурал энийг батлагдсан. Тэгээд Засгийн газар энийг өөрсдөө оруулж ирчхээд буцаад Их Хурлаа буруутгаад байх шиг байна. Энэ дээр тайлбар авъя.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Алтаншагай гишүүн ээ энийг аль нэгийг буруутгаад байгаа юм биш л дээ. Энийг өмнөх Засгийн газрын үед гэсэн утгаар биш. Засгийн газар Улсын Их Хуралаас 24 болгож тухайн үеийн Эдийн засгийн хөгжлийн сайд Гантөмөр сайдын санаачилгаар 24 гээд жилийн төлөвлөгөөнд баталчихсан юм байна лээ. Одоо Их Хурал Засгийн газар ямар төсөв өргөн бариулах вэ гэхээр яг энэ жилийн төлөвлөгөөнд нийцүүлж өргөн барих ёстой гээд заачихсан. Энийг аудит хянана, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хянана. Одоо бид уул нь энэ жилийн төлөвлөгөөнд энэ төсөв нийцэж байна уу, үгүй юу гэдэг санал хураалт явагдах ёстой юм. Би жилийн төлөвлөгөөнөөс хасаад 24-өөс 25 болохоор оруулах юм бол жилийн төлөвлөгөөнд нийцээгүй байна аа гээд төсвийн төслийг буцаачихна.

Тийм учраас энэ жилийн төлөвлөгөөндөө нийцүүлж бид төсвийн төслийг заавал өргөн барих ёстой, тийм санал хураалт явагдах ёстой. Харамсалтай нь 47, 48 дахь хоногтоо энэ төсвийн төсөл жилийн төлөвлөгөөндөө нийцэж байна уу, үгүй юу гэдэг санал хураалт явагдсангүй. Энэ санал хураалт явагдсаны дараа төсвийн хоёрдугаар хэлэлцүүлэг дээр бид.../минут дуусав./

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Монгол Улсын Ерөнхий сайд аа ийм тайлбаруудаа боль оо. Хэнийг хуураад байгаа юм. Урсгал зардлаа нэм гээгүй хас гээд байна шүү дээ. Тэндээс зай гаргаад цалин, тэтгэврээ нэм л гэж байна шүү дээ.

Одоо Ерөнхий сайд аа, энэ багш, эмч нарын ажил олгогч нь та байхгүй юу. Та ажил олгогч нь. Та хүнээр ажил хийлгээд байдаг нөгөө хүмүүсийн амьжиргаа нь улам унаад байдаг байж болох юм уу л гээд байгаа шүү дээ. Унаад байна шүү дээ. Урсгал зардлынхаа таазыг нь нэмчихсэн, таазыг нь тогтоочихсон учраас болохгүй байна аа гээд байх юм. Төрийн захиргааны хэсгийнхээ ядаж энэ зардлыг тана л даа. Энэ Монгол Улс чинь нэг бол дарга, нэг бол ядуучууд. Яг ийм болчихлоо шүү дээ. Даргын улс болчихсон шүү дээ үнэн шүү дээ. Үгүй ээ энэ зардлуудаа тана л даа. Тэр нэг дампуурчихсан хэдэн компаниуд төрийн өмчийн компаниудаа хувьчлаад дампууруулаад эндээсээ гарсан юмаа та нар энэ ажил хийлгэж байгаа юм бол хүмүүст цалинг нь өгөх ёстой шүү дээ. Хаа газрын багш нар энэ дундаж давхаргаасаа доошоо байдаг энэ Монгол л байх нээрээ. Энийг л хэлээд байгаа шүү дээ. Энэ дээрээ 100 хоногт яг ямар шийдэл гаргаж ирсэн юм та нар? Ямар

шийдэл гаргаж ирсэн юм, ямар шийдэл гаргах гэж байгаа юм? Юу ч байхгүй. Тэгээд гадаа ажил хаялаа гэнгүүт Сангийн сайд нь гарч ирээд болохгүй гэж ярьж ярьж байснаа ажил хаянгуут гарч ирээд нэг ямар ч байсан ингэхээр боллоо шүү баяртай мэдээ хэнийг дооглоод байгаа юм. Сайд нар чинь галзуурчихсан байна лээ шүү дээ Ерөнхий сайд аа. Багш нар асуудлаа хэлэхээр хариуцлага тооцно, шүүх дээр уулзъя гэж заналхийлдэг. Шатахуун нь тасалдаад байна аа гээд хүмүүс мэдээлэнгүүт мэдээлсэн хүмүүсийг нь цагдаагаар айлгаж байдаг.

Энэ Эрүүл мэндийн сайд Чинбүрэн байна уу? Энэ хүнийгээ тэр эмнэлгээр явуулаач. ЭМД-аар авч чаддаг үйлчилгээ байхгүй болчихсон байна шүү дээ. Ахмадууд чинь аппликэйшний зээлээр авч байгаа тэтгэвэр дээрээ нэмж аппликэйшний зээл тавиад тэгээд эрүүл мэндийн үйлчилгээ авдаг болчихсон байна хөөе. Энэ Монгол төр чинь ядаж боловсрол, эрүүл мэнд энэ суурь хоёр асуудлаа ядаж ингээд шийддэггүй юм уу? Үгүй ээ яах гэж энэ төр байгаа юм бэ? Одоо ингээд сандал суудлын хэрүүл хийгээд. Нэг нь нүүрсчин, нөгөө нь нүүрсчин биш гээд. Худлаа шүү дээ. Та нар бүгд нүүрсчин шүү дээ. Та нарын түүх бол тэр чигтээ нүүрсний хулгайн түүх шүү дээ. Байгалийн баялгийн хулгайн түүх. Танай нам бол нүүрсний нам. Ямар ч ялгаа байхгүй. Одоо энэ дээр сууж байгаа энэ 3 индрийг бүтнээрээ хүмүүс нь дүүргэчихсэн байхад надад зүгээр л хулгай, дээрмийн түүх харагддаг. Энэ тэнэг яриагаа болиод төр нь ажлаа хиймээр байна. Асуултад хариулаад өг.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя аа.

Энэ цалин, тэтгэвэр, тэтгэмжийн асуудал бидний ажиллаж байсан энэ 3, 4 сарын дотор бий болчихсон асуудал биш ээ. Нүүрс, зэсийн үнэ өндөр, эдийн засгийн орлого нэмэгдэж байсан тэр үетэй харьцуулах юм бол энэ олон жил овоорсон асуудал, овоолсон хогийг 3 сарын дотор бүгдийг шийдэхгүй ч углуургаар нь цэгцлэн цэвэрлэж, бид энэ данхар төсвийг түүхэнд анх удаа та бүхэнтэй хамт 2.2 их наядаар танасан. Тэгэхгүй бол энэ 7 сард инфляц 15 хувьд хүрэх долларын ханш 4000 төгрөгт авах тооцоотой байсан. 2.2 их наядаар танасан. Ингэж их танаж байхад байна шүү дээ. Төсвийн орлого 3.3 их наядаар тасалдах эрсдэлтэй болчихсон байсан. Ийм хүнд нөхцөлд бид цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэх нь битгий хэл төрийн үйл ажиллагаагаа яаж саадгүй явуулах вэ гэдэг ийм эрсдэлтэй болж ирсэн.

Харин одоо энэ эрс шинэчлэлүүдийг хэрэгжүүлсний үр дүнд 1.3 их наядын өссөн дүнгээрээ алдагдалтай явж байсан төсөв 8 сард 8 сарын дүнгээрээ 50 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж ирсэн. Ийм шинэ боломжууд бий болсон. Ийм учраас бид боловсролын жил гэж зарласан учраас бид 3 жилийн хугацаанд 3.5 саяд багшийн цалинг хүргэх, түүнээс дээш болгох, багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж Боловсролын яаманд даалгавар өгч энэ ажил хэрэг болгосон. Ингээд уул нь үйлдвэрчний эвлэлтэй яг зохицоод 100 тэрбум төгрөгийн багшийн ачаалалд суурилсан нэмэгдэл олгохоор тохирсон юм.

Ер нь багшийн цалингийн санд, боловсролын цалингийн санд 2.8 их наяд төгрөг тусгагдсан. Энэ багш нарын цалин хөлсийг хөдөлмөрийн ачаалал ур чадварт нь нийцүүлэх, үр дүнд чиглэсэн, гүйцэтгэлд чиглэсэн багш нарын цалин,

урамшууллын тогтолцоог бий болгох ийм цогц шинэчлэлийг хийх замаар мөн дижитал боловсролын шинэ платформыг нэвтрүүлсэн. Энэ боловсролын салбарын цогц шинэчлэлийг хийж, багш нарын цалинг нэмэгдүүлэх ийм цогц бодлогыг хэрэгжүүлж байгаа. Энэ талаар манай Наранбаяр сайд дэлгэрэнгүй хариулж болно. Ийм учраас бид энэ нөөц боломждоо тулгуурлаад 8 сард төсөв өргөн барих 8 сарын дүн чинь 9 сарын дундуур гарч байна шүү дээ. Статистик дүн чинь. 9 сарын 1-нд төсөв өргөн барьдаг болчихсон.

Ийм нааштай үзүүлэлтүүд төсөв өргөн барьснаас хойш гарч байна. Тэгэхээр энэ үзүүлэлт дээр тулгуурлаад бид энэ цалин, тэтгэмж, зөвхөн боловсролын салбарын цалин гэхэд 509.9 тэрбум төгрөгөөр буюу 20 хувиар нэмэгдүүлэх тооцоо, судалгааг хийгээд ингээд энийг ажил хэрэг болгоё оо гэж Их Хурлын Төсвийн байнгын хороондоо танилцуулсан юм. Харамсалтай нь өнөөдөр ёстой таны хэлдгээр ширээ, сандлын асуудал хэлэлцсээр байгаад таарлаа.

Нүүрсний хулгай, нүүрсний асуудал аль нэг намд хамааралтай биш, Ардчилсан намын үед ч гэсэн энэ анх Эрдэнэс Тавантолгой байж байх үед яригдаж л байсан асуудал яригдаж л байсан асуудал. Хамтарсан Засгийн газар бид ажиллаж байсан. Аль нэг нам руугаа шахдаг, шийддэг ч асуудал биш. Гэхдээ шатыг дээрээс нь эхэлж шүүрдэх ёстой. Бид энэ улс орон авлигал гэдэг бол ард түмний кармагаас л хулгайлж байгаа хэрэг.

Тийм учраас энэтэй тэмцэх нь бол энэ эдийн засгаа сэргээх хамгийн чухал хөрс нь болох юм байна лээ. Аль нэг хүнтэй биш асуудалтай өрсөлдөх нь Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын үндсэн үүрэг гэж өндөр итгэл үнэмшилтэйгээр л бид энэ ажлыг хэрэгжүүлж байсан. Үнэнтэй нүүр тулсан, нүүрсний үнийн өсөлтийг өгөөж болгохын оронд өөрсдөө томроод байгаа төсөв, үрэлгэн төсвийг бид 2.2 их наядаар танаснаараа өнөөдөр энэ боломж чинь гарч ирж байгаа. Ийм учраас бид цаашдаа ч гэсэн энэ нүүрсний хулгайтай тэмцэж, төсвөө тэлж үүгээрээ багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх ийм бодит боломж бий болж байна аа гэдэг нь 8, 9 дүгээр сангийн сарын төсвийн үр дүнгээр харагдаж байна аа. Ийм учраас бид энэ өөрчлөлтийг тууштай хэрэгжүүлж энэ.../минут дуусав./

Х.Булгантуяа: Лодойсамбуу гишүүн нэмж тодруулна.

Ч.Лодойсамбуу: Боломж гарч ирж байна гэж манай ажил олгогч хэлж байна. Уучлаарай танай нам засаглаж байгаа 10 жилийн хугацаанд төсвийн зарлага 5 дахин нэмэгдсэн, 500 хувь нэмэгдсэн, орлого нь 5 дахин нэмэгдсэн. Компаниар ярих юм бол орлого нь 5 дахин нэмэгдээд байхад ажилладаг хүмүүсийнх нь амьжиргаа 5 дахин уруудаад байж болдоггүй юм аа. Тэгээд ингээд асуудал ярихаар өөдөөс ямар ч шийдэл байхгүй ингээд итгэл төрөхгүй байна л даа. Бид нар ингээд та нар шиг ийм олон жил зүгээр нэг хэдэн улс төрийн зураг зурчхаад тэрийгээ нэг биелүүлээд тэрийгээ их мундаг гээд бодчихсон хүмүүс биш. Залуучууд чинь ийм гэгээн мөрөөдөлтэй. Одоо танай намын жагсаалтын нэгээс авхуулаад хэлж байна шүү дээ. Бид нарын энэ улс орныг сайхан болгоно гэдэг итгэл байдаг юм аа гэж. Аргацаадаг байдлыг чинь бид нар хараад байна шүү дээ. Мэдээд байна шүү дээ залуучууд нь. Тэгээд нэхээд байна л даа. Танд одоо яг ийм энэ орлого нь нэмэгдээд байдаг төрд ажиллаад байгаа хүмүүсийнх нь амьжиргаа буураад байдаг. Энэ төрийг жохон .../минут дуусав./

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулъя

Г.Занданшатар: Лодойсамбуу гишүүн яг бид нарын хийж байгаа ажлыг асуулаа. Энэ төсвийн тодотголоор төсвийн зардлыг 2.2 их наядаар танасан гол шинэчлэл чинь төрийн албаны данхар бүтцүүдийг цомхотгож, 9 хувиар цомхотгож, үргүй зардлуудыг хэмнэснээр эхэлсэн. Таны яг хэлээд байгаа тэр шинэчлэл чинь харин энэ хэмнэсэн төсвөө багш, эмч нартаа зарцуулдаг ийм шинэчлэлийг хийж эхэлж байгаа. Өнөөдөр мэдээж эдийн засгийн байдал амаргүй байна. Гэхдээ бид энийг даван туулж чадаж байна. Оны эцсийн үр дүнгээр илүү сайжирна. Бид гарц, шийдэл ярьж байгаа. Ийм ч учраас өнөөгийн парламентыг олон гишүүнтэй энэ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ард түмэнтэй Зөвлөлдөх ардчиллаар хэлэлцэж байхад хамгийн гол нь энэ баялгийн хулгайтайгаа тэмцэж байж энэ юм чинь сайжрах юм байна аа гэсэн агуулгаар Үндэсний баялгийн сангийн санг би өөрөө санаачилж 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулж байсан юм. Энийгээ бид хэрэгжүүлэхийг зорьж байгаа юм. Энэ.../минут дуусав./

Х.Булгантуяа: Лодойсамбуу гишүүн нэмж тодруулна.

Ч.Лодойсамбуу: Ойлголоо. Нэг их тийм хүлээлт алга л юм байна.

Хоёрдугаарт тэр ЭМД-ын тухай асуусан. Чинбүрэн сайд орж ирэхгүй байна. Тэр сайд руугаа залгадаг юм уу, яадаг юм. Энэ эрүүл мэндийн даатгалаар ахмадууд үйлчилгээ авч чадахаа больчихсон. Энийг яг та мэдэж байгаа юу, сонссон уу, судалсан уу? Сайд чинь юм хэлдэг үү? Одоо энийг яах вэ? Бас ингээд мөнгөгүй гээд суух уу? Одоо байгаа боломж нь байхгүй байна гээд суух уу? Та нар баталж өгсөн төсвийн хүрээн дотор л бид нар ярьж байна шүү дээ гээд ингээд зовлон тоочоод суух уу? Үгүй ээ яах вэ нээрээ яаж асуухаа ч мэдэхгүй, ийм арга хэлбэрээ олохгүй байна. Энэ дээр тодорхой, яг яах вэ? Эндээс яаж гарах вэ? Хэзээ, ямар алхам хийсэн 100 хоногт reel-ээсээ гадна?

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Лодойсамбуу гишүүн ээ бодитой алхмууд хийгдэж байгаа гэдгийг тодруулж хэлье. ЭМД-ын сангаас өнөөдөр эмнэлгүүд өртэй, энэнээсээ шалтгаалаад даатгалын санхүүжилтүүд саатаж байгаа бодит байдал бий болсон. ЭМД-ын сангийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Бүр эмийн мафиас авхуулаад тэнд КОВИД-ын үеийн булхай, луйвраас авхуулах 300 тэрбум төгрөгийн өр үүсчихсэн. Энэ хулгай зэлгий чинь л энэ сангуудыг чинь хоослоод байна шүү дээ.

Тийм учраас тэр сангийн захирлыг нь чөлөөлөөд, өөрчлөөд, хяналт шалгалт явагдаад, энэ хулгай зэлгийтэй тэмцсэний үр дүнд энэ даатгалын сангаа нөхөн төлүүлэх ажлыг шалгуулж байна. Энэ бүхэнд чинь эгдүүцээд нэг огцруулах олон шалтгааны нэг чинь бодит байдал нь яг үнэндээ энэ байгаа. Жишээлбэл, ЭМД-ын сан бол солидарнист буюу эв санааны нэгдлийн зарчмаар энэ эмнэлгүүдээ ч санхүүжүүлж байна. Одоо хүүхдүүдийнхээ өвчлөлийг хүртэл санхүүжүүлж чадахгүй хэмжээнд хүрчихсэн байна шүү дээ. Энэ ерөөсөө өмнөх олон жил, өмнөх КОВИД.../минут дуусав./

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Эх оронд минь хулгай нүүрлээд хулгайлсаар л байна. Урдуур сууж байгаа бүх хүмүүс 9 жилийн туршид би та нарын хулгайг ярьсан, тэр хулгайг өнөөдөр хоёр хуваагдаад нэгнийхээ хэргийг хаах болох, нуух болох дээрээ бүгдээрээ ярьж эхэлж байх шиг байна. ЖДҮ-ийн хулгай, Төсвийн хулгай, Тендерийн хулгай, Хөгжлийн банкны хулгай, КОВИД-ын хулгай, төмөр замын хулгай, автобусны хулгай, нүүрсний сериал хулгай.

Нүүрсний хулгай нэг. 44 их наядаар хулгайлсан. КОВИД-ын үед та нар Си зөвшөөрлөөр хааж байгаад 29км газарт 3 сая төгрөгөөр тээвэр хийдэг байсныг 120 сая төгрөг болгож байгаад өдөржингөө, шөнөжингөө зөөж хулгайлцгаасан.

Нүүрсний хулгай хоёр. Оффтейк гэрээгээр замбараагүй өндөр үнэ тавьж байгаад тэндээ хамгийн хямдхан нүүрсээ зарж хулгайлцгаасан.

Нүүрсний хулгай гурав. Бор тээг 400 их наядын хохиролтой.

Нүүрсний хулгай дөрөв. Гэрээний хулгай. 4, 5 компаниуд бүгдээрээ өнөөдрийг хүртэл 50-хан доллароор авдаг. Тэрийгээ бүгдийг нь зөрүү мөнгийг нь хилийн цаана авчхаад тээврийнхээ нэрээр оруулж ирж хулгайлцгаадаг та нар.

Нүүрсний хулгай тав. Харбины гэрээ 10 их наядын хохиролтой. Энэ бүх хулгайнууд чинь бүгдээрээ илрэх болохоор та нар бүгдээрээ энэ аль нь түрүүлж хулгайгаа дарах вэ гэдэг ийм л уралдаанд явж байгаа. Том хулгайчид нь жижиг хулгайч энэ нөхдүүдээ бүгдийг нь хулгайныхаа мөнгөөр худалдаж аваад 2 талдаа гаргачихсан хойноосоо жиргүүлчихсэн. Ямар ичих эрээ цээргүй юм бэ. Энэ ард түмэн гэж зүгээр л дорд хаядаг. Та нарын хулгайн мөнгө чинь ерөөсөө ил гарч ирдэггүй.

Тэр Богд уулын ам болгонд байгаа тэр хауснууд бүгдээрээ харанхуй байгаа. Хотын төвийн Зайсангийн үнэтэй байрнууд бүгдээрээ харанхуй байгаа. Тэр мөнгөөр бүгдээрээ та нарын худалдаж авсан байрууд шүү дээ. Хулгайч нар мөнгөө дандаа дэрнийхээ доор нуудаг. Тэр чинь эдийн засагт орж ирэхгүй, хүмүүс ядуураад байна, та нар баяжаад л.

Тэгээд өнөөдөр энэ хулгай нь ингээд өнөөдөр бүгдээрээ ингээд жоохон удах юм бол та нар чинь ёстой нэг пөөх ёстой нэг дэлгэж дуусах нь ээ. Үгүй ээ тэр тэрний хулгай, чиний тэрний хулгай, тэрний тендерийн хулгай, энэний хулгай сошиалаар нэг юм. Тэгээд бид нар бас дээрээс нь мэднэ л дээ. Жижиг сажиггүй тэр БЭТ хийсэн хулгайнууд нь тэр гэрээ мэрээний хулгайнууд ёстой нээрээ. Луйварчид нээрээ дүүрэн сууж байна даа. Яана даа та нар.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Нүүрсний хулгайны асуудал анх 2002 онд ард иргэдийн, залуучуудын жагсаалаар энэ Сүхбаатарын талбай дээр юу болсныг та бүхэн сайн санаж байгаа байх аа. Энэний өмнө Адьшаа гишүүн санаачлаад Ганболд нарын гишүүд санаачлаад энэ нүүрсний сонсголын ажлын хэсэг, хяналт шалгалтын ажлын хэсэг анх байгуулагдсан.

Энэ шаардлагын дагуу Улсын Их Хурал дээр нээлттэй сонсгол зохион байгуулагдаж байсан. Энэ нүүрсний салбарын ил тод байдлыг хангах, төрийн хяналтыг сайжруулах анхны томоохон алхам байсан. Ер нь тэгээд нүүрсний хулгай гэх тодотголтой хэргүүд төмөр зам, олборлолт, тээвэрлэлт, борлуулалт, худалдан авалттай холбоотой системийн ийм цогц зөрчлүүд хамаарч байгаа юм. Нийтдээ 124 хэргийг мөрдөн шалгаж 88 хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдээд байна. 20 хэрэг шүүхээр шийдвэрлэгдээгүй, хэлэлцэгдээгүй байна. 48 хэрэг мөрдөн байцаалтын шатад байна. Энэ 2025 онд нийтдээ 48 хэргийг үндэслэлгүй хөрөнгөжсөн үндэслэлээр хэрэг нээн шалгаж байна. 40 хэрэг мөрдөн байцаалтын шатад байна. Энэ бол Ерөнхий сайд Тавантолгойд онцгой дэглэм тогтоосны дараа хулгайн олон хэлбэрийг ээлжилж, компанийн орлого, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд нөлөөлсөн. Одоо таны яриад байгаа тэр олон гэрээнүүдийг ил тод болгож ард түмний хяналтад орууллаа. Манай Засгийн газар нэг ч нууцаар гэрээ хийгээгүй. Цаашдаа ийм зарчим байж болохгүй гэсэн зарчим гаргасан. Ард түмний хяналтад бай гэсэн ийм зарчмыг гаргаж байгаа. Энэ тэгвэл хар сэр нь дийлдэхгүй юм байна лээ. Үнэн ч бай, худлаа ч бай, зөв ч бай, буруу ч бай. Ингэж байж бид нөгөө баялгийн менежментээ зөв хэрэгжүүлж Баялгийн сангаа хэрэгжүүлж чадна гэж үзсэн. Энэ бид нарын нөгөө хамтарч хийсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн маань амин сүнс учраас энэнийхээ төлөө л би зүтгэж байгаа юм. Хэн нэгнийг буруутгах гээд байгаадаа биш. Энийг чинь нийтээрээ ойлгож, хэрэгжүүлж байж төр дээрээсээ парламент, Засгийн газар хамтарч ажиллаж байж би энэ бодитой хэрэгжинэ гэж итгэсэн.

Одоо онцгой дэглэмийн хугацаанд гэхэд АМНАТ энэ тэр гээд шүүмжлээд байна. Өнгөрсөн 15 жилийн хугацаанд түүхэнд хамгийн өндөр борлуулалт биет хэмжээгээрээ хийлээ шүү дээ. Сарын дундаж борлуулалтыг 1.6 дахин нэмэгдүүлсэн энэ хулгай зэлгийтэй тэмцсэнээрээ Тавантолгой дээр. Биржийн тээвэрлэлтийг 2 дахин, экспортыг 1.3 дахин, орлогыг 1.3 дахин, олборлолтыг 1.2 дахин нэмэгдүүлсэн нь энэ онцгой дэглэмийн хугацаанд бүх шатад нь байсан хулгай зэлгий тэр хулгай зэлгийн цана нөгөө хүнд суртал, чирэгдэл байдаг байхгүй юу. Тэгчихвэл ингээд хөдөлнө, ингэчихвэл ингээд хөдөлнө гээд дандаа ийм тээг, саадууд байдаг. Эднийг арилгаж байж энэ өөрчлөлт, шинэчлэлтүүд хийгдэж байгаа юм аа. Энэнтэй чинь тэмцэж байна дээрээсээ доошгүй бүгдийг нь анхаарах юм байна гэж шаардлага тавьж байж тэгэхгүй бол дээрээ заачихдаг. Дээд дарга нар аа яах ч үгүй байж та нар, доороо болохоороо бүгд ингэж байна гэсэн. Энэ Тавантолгой төрийн өмчийн компаниудад тогтсон бараг соёл болчихсон ийм хулгайн схем байна гэж бид үзэж энийг шалгуулсан юм. Шалгалтын ажил явчихсан юм. Сүүлийн 3 сарын хугацаанд нийт 81 удаагийн биржийн арилжаа амжилттай хийж, 392.8 сая долларын үнэтэй 7.1 сая тонн нүүрс биржээр арилжлаа. Энэ өнгөрсөн 7 сарынхаасаа өндөр үнэ байгаа шүү. Ингэж бодит үр дүн өгөөд байгаа байхгүй юу.

Одоо 9 дүгээр сард бол Монголчууд түүхэндээ хамгийн өндөр буюу анх удаа 3.2 сая тонн нүүрс экспортоллоо. Энэ бол онцгой дэглэмийн хугацаанд нүүрсний экспортыг Тавантолгойд нэмэгдүүлсний үр дүн байгаа юм. 2025 онд 7 дугаар сард гэхэд 1.9 сая тонн, 8 дугаар сард 2.7 сая тонн, 9 дүгээр сард 3.2 сая тонн нүүрсийг Гашуунсухайт, Хангийн боомтоор экспортолсон. Энэ бол хулгайтай тэмцсэний үр дүн. Ингэж байж бид нар энэ эдийн засгийн эргэлтээ сайжруулж, энэ багш, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлж эдийн засгийн.../минут дуусав./

Х.Булгантуяа: Одоо Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: 20 гаруй цагийн дараа ирц бүрдлээ. Эзэн сэрсэн үү нойрноосоо? Орцгоо гэсэн үү? Урьд шөнө кноп хэд хүрэв? Хэдэн хүнд сайдын суудал амлав? Хэд нь эх орноосоо урвав? Хэд нь найз нөхдөөсөө, намаасаа урвасан бэ? Хулгайтай тэмцэнэ гэнэ ээ Занданшатар сайд аа. Адилхан хулгайч байж юу яриад байгаа юм. Өнөөдөр та хулгайч нарыг бүгдийг чинь огцруулна аа. Засгийн газрыг огцруулна. Амарбаясгаланг огцруулна, кайфтай өдөр. Эрдэмтэн, судлаач шударга юм гэж бодож явсан хүмүүс энэ төрөөсөө урвалаа шүү дээ та нар. Парламентад тангараг өргөдөг, парламентад ажлаа тайлагнадаг Засгийн газрын хулгайчуудыг өмөөрч бойкот хийлээ. Би та нарын ах нартай 28 жил үзсэн юм аа. Одоо шинэковтой нь үзэх юм байна л даа. Нэг их хэцүү байдаггүй юм. Дайснууд байж байхад нэг их хүчирхэг юм шиг байдаг юм. Дараад авчихсан хойно гөлөгнөөс ч дор л байдаг байхгүй юу даа.

Ухаа худгийн эзэн Роберт Куок Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 6-ны өдөр ирсэн. 7-нд Баянхонгорын Шинэжинстийн уурхайгаа эргэсэн. Холбогдох хүмүүсийг дуудаж уулзсан. Эзэн нь юмаа мэдэж, эрэг нь усаа хашдаг Монгол үг бий шүү гэж хэлсэн. Тэр өдөр яасан. Төрийн байгуулалтын байнгын хороо гацсан. Засгийн газар Их Хуралд бойкот хийсэн. Ухаа худгийг шалгах хянан шалгах түр хороог Эдийн засгийн байнгын хорооноос буцаасан. Би та нараас асуулт асуухгүй. Одоо тэртээ тэргүй та нарыг зайлуулах учраас. Зүгээр нэг баримт үзүүлчихье.

Оюу толгойн аудитын дүгнэлтийг нууцад авах ямар ч үндэслэлгүй гэж Тагнуулын ерөнхий газраас ирсэн бичиг энэ байна. Гэхдээ хулгайтай тэмцэж байгаа юм бол энийг гаргачих л даа Монголын ард түмний өмнө. Батнайрамдал гишүүний ахалж байгаа Хянан шалгах түр хороо Оюу толгой, Монголын төр 34 хувийг нь эзэмшдэг Оюу толгойтойг 2 удаа Их Хурал дээр дуудлаа. Барахгүй байна шүү дээ. Та нар ёстой том байна аа. Цээж нь түрчихсэн, кармандаа гараа шаачихсан, харц нь дээгүүр инээд алдчихсан. Урьд шөнө өнөөдөр энд парламентыг сахиж суухад өлсөөд байна уу, хоол явуулах уу эд нар гэж даапаалж байна шүү дээ. Том байна тийм үү. Тэгэхдээ том хулгайч нар их олон унахыг би харсан юм аа.

Монголын төр Засгийн газраа олон удаа огцруулж байсан. Их Хурлын даргаа 3 дахь удаагаа огцруулах гэж байна. Та нар шиг байгаагүй шүү. Их Хурлаа бойкот хийж байсан түүх байхгүй шүү. Энд орж ирээд өнөөдөр энэ пээдэлзээд байгаа кармандаа гараа шаачхаад энэ дундуур алхаад байгаа хүмүүсийг улс төрийн “А” ч үгүй байхад ах нарын чинь хулгайг би дэлгэж явсан сэтгүүлч юм. Өнөөдөр Их Хурлын гишүүн болсон. Хэний мориор газар дөхсөнөө санаарай. Монголын ард түмний мориор та нар Монголын ард түмний саналаар газар дөхөж.../минут дуусав./

Х.Булгантуяа: Мөнхбаясгалан гишүүн нэмэлт 1 минут.

Л.Мөнхбаясгалан: Хорин хэдэн цаг хүлээсэн юм чинь ганц минут байх байлгүй дээ. Хэний мориор газар дөхсөнөө Монголын ард түмний саналаар энд гарч ирснээ санаарай. Үнэнд гүйцэгддэг юм аа. Танай нам бол дандаа нэгнийгээ

удирдагч болгоод өөрсдөө барьж авч иддэг, алдаг, шорон оронд нь хутгадаг, шороотой нь хутгадаг нам за юу. Одоо яг тэр түүхээрээ явж байгаа. Та нар өмнөх удирдагч дарга нараа хараарай. Одоо энэ Занданшатарыг ч барьж иднэ, дараа нь Хүрэлсүхийгээ барьж иднэ. Ийм л түүхтэй шүү дээ.

Өнөөдөр Ардчилсан нам та нарыг бүгдийг чинь огцруулж өгөөд бах таваа хангах өдөр. Монголын ардчиллыг хамгаалж үлдэх өдөр. Монголыг парламентын ёстой нь үлдээх өдөр. Дарангуйлалд оруулахгүй. Асуух юм байхгүй. Битгий хариулна гээд гоншигноод байгаарай.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе та бүхэнд. Ёстой нөгөө та бүхэн чинь ч ёстой нэг шившгээ дэлгэж байна даа гэдэг шиг л юм болж байна даа.

Энэ ирцэд орсон, ороогүй гээд нэг баахан гишүүдийг доромжлоод байна аа. Энэ болохгүй шүү дээ та нар. Энэ чинь яахаараа дийлэнх олонх нь ирэхгүй байхад яагаад ирдэггүй юм гэдэг талаас нь харж болдоггүй юм уу? Энэ чинь бид нар чинь өөрсдийн үзэл бодолтой хуулиа биелүүлчихье гээд сууж байгаа улсууд шүү дээ. Энэ Үндсэн хууль дээр энэ Засгийн газрыг чинь огцруулъя гэдэг дээр дэмжинэ, дэмжихгүй гэдэг саналаар л санал хураах юм байна лээ. Би тэгж хараад л байгаа. Тэгээд энийг иргэдэд нэг ойлгомжтой хэлчихгүй тойруулаад л янз янзаар худлаа яриад л ингээд хачин юм яриад байх юм. Би энэ сууж байгаа энэ Занданшатар дарга, Амарбаясгалан даргатай энэ хувийн болон аж албан ажлын талаар ямар ч асуудалгүй харьцаатай байдаг. Үгүй ээ тэгээд энэ чинь уул нь Үндсэн хуулиа дагаад явчихъя гэхээр энэ хурал даргалагч гэдэг хүн чинь л их чухал хүн байдаг юм байна аа.

Булгантуяа дарга өчигдөр их муухай харагдлаа. Шөнөжингөө л муухай харагдлаа. Нэг айлын 2, 3 настай эрх охин дэлгүүрт орчхоод би заавал энийг авна гээд тийчлээд хэвтчихдэг шиг л юм харагдаад байна шүү дээ. Энэ чинь дийлэнх нь яагаад ирэхгүй байгаа юм бэ гэдэг талаас нь та нар яагаад хардаггүй юм. Тэгээд Ардын нам чинь өөрөө 68 гишүүнтэй энэ ирцээ бүрдүүлээд ингээд явчих бүрэн боломжтой байж байж бусад намууд руу яасан муухай дайрдаг юм. Бусад намын гишүүд энэ олуулаа байж байгаад Ардчилсан намынхан хэлэх байлгүй дээ. Миний нэр ч дуулдаад л байна лээ. Манай 2 гишүүн зайлуул гадаадад томилолттой явж байхад. Нара орчихсон байсан. Тэгж болохгүй шүү дээ та нар.

Тэгээд 2 талын харилцан саналуудыг нь нэг сонсчихмоор санагдаад байх юм. Тэр АМНАТ-тай холбоотой асуудлыг энэ Эрдэс баялгийн яамных нь сайд нь хариулмаар байх юм. Цалин нэмж болох, болохгүй талаар нь Сангийн яам нь хариулмаар байх юм. Би одоо асууж байгаа шүү. Тэгээд ер нь бол би 200 хууль бичсэн, барьсан энэ хуульч гишүүд энэ тэрнээсээ жоохон урам хугарчихлаа. Энэ Үндсэн хуулиа яаж тайлбарлах гээд байгаа юм. Бид нарын энэ өнөөдөр яригдаад байгаа юм чинь Үндсэн хуулийн цэц дээр очоод уначихвал яах гэж байгаа юм, яах юм? Өнөөдөр огцруулчихна, дараа нь яах юм? Буруу байна аа гээд буцаагаад тавих юм уу? Энийг хэн хариулах юм?

Тэгээд Үндсэн хуулийг бид нар тайлбарлахгүй Цэц тайлбарлана гэсэн ийм сонин юм яриад байх юм. Өчигдөр энэ Бум-Очир гишүүн бүүр аргаа бараад ярьж

байна лээ шүү дээ. Үгүй ээ энэ улаан гэрэл асчхаад байхад ор ор гээд байх юм. Тэгэхээр чинь би орох юм уу, орохгүй байх юм уу та нар юу гэж бодож байна аа гээд байх юм. Үгүй ээ энэ чинь урд улаан гэрэл асчхаад байна аа л гэсэн үг юм шиг надад санагдаад байх юм. Тэгээд энийгээ нэг аятайхан шиг шийдчихэж болохгүй юм уу?

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Батболд гишүүний асуултад хариулъя маш чухал асуулт байна аа. Би энэ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн голлох эрх баригчдын нэгээр ажилласны хувьд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт бол Засгийн газрын тогтвортой байдлыг хангахын тулд оруулсан юм. Засгийн газрын дундаж нас 1.4 жил байна аа. Энэ процесс нь тодорхойгүйгээс болоод янз бүрийн зөрчил гарч байсан байна аа. Ийм учраас процессыг нь тодорхой хуульчилж Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэг нь огцруулах санал гаргана. Уг саналыг, огцруулах саналыг гэсэн үг. Уг саналыг нийт гишүүдийн олонх дэмжсэн бол Засгийн газрыг огцорсонд тооцно оо гэж цагаан дээр хараар Үндсэн хуулийн 43.1-д хуульчилсан. Процесстой нь заачихсан. Үндсэн хуульд процесс заадаг тийм жишиг байдаг юм. Яагаад гэвэл процесс эвдэгдээд байвал. Яагаад гэвэл Засгийн газрын тогтвортой байдал алдагдаад хулгайтай тэмцэхээр нь ч юм уу, аль эсвэл шударга ёсны төлөө ажиллахаар нь ч юм уу огцруулаад байдаг хуйвалдааны ийм шинж чанартай юм болохоос урьдчилан сэргийлж зориуд энэ заалтыг оруулсан юм.

Өмнөх жишгүүд энэ кэйсээс хойш өөрчлөгдсөн. Үндсэн хууль нэмэлт, өөрчлөлтөө дагах ёстой. 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 126 гишүүнтэй болсон. 126 гишүүнтэй болсон учраас тэр 76 гишүүнтэй байх үеийн дэг тэр 2021 онд Хүрэлсүх дарга дээр жишээд байгаа дэг Улсын Их Хурлын тухай хууль бүгд өөрчлөгдсөн. Энэ шинэ парламент чинь шинэ уур амьсгалтай мэтгэлцээний талбар байгаасай гэж бодож бид нар энэ Дэгийн тухай хууль, Их Хурлын тухай хуулиа өөрчилсөн. Энэ хамгийн сүүлийн хурлын дэг хуулиар заах ёстой. Дэгийн тухай хуулийн 101.4-д яг энэ процессоор нь заачихсан байгаа. Засгийн газрын Ерөнхий сайдыг огцруулах саналыг нийт гишүүдийн олонх дэмжсэн бол огцорсонд тооцно оо. Тэр битгий хэл Төрийн байгуулалтын байнгын хороогоор тэр тогтоолын төсөл хэлэлцэгдэх ёстой. Хэлэлцэгдээгүй одоо орж ирсэн Үндсэн хуулийн зөрчилтэй. Ийм олон асуудлууд гарсан учраас Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хууль зөрчсөн асуудлаар чуулганы хуралдаанд орохгүй байж болно гэсэн эрхийнхээ дагуу ороогүй юм байна аа. Энийгээ залруулаач ээ гэсэн шаардлага тавьсан гэж бид ойлгосон.

Тэгтэл тэр шаардлага тавиад Үндсэн хуулиар олгогдсон ард түмний төлөөлөгчийнхөө хувьд эрхээ эдэлж байгаагийнх нь төлөө яллаж энэ шүүх танхим биш зарим талаар доромжилж ингэж муутгах нь бол Үндсэн хууль зөрчсөн алхам болно гэж үзэж байгаа. Яагаад гэвэл бид Үндсэн хуульдаа хууль дээдлэх ёсыг л зарчмаа, удирдлагаа болгож ажиллахыг заасан. Тийм ч учраас Улсын Их Хурлын гишүүд нийт төр, ард түмний эрх ашгийг эрхэмлэж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж төр, ард түмэндээ зүтгэнэ гэсэн агуулгатай тангаргийн үгийг хүртэл оруулсан. Хууль дээдлэх ёсоо баримтлах ёстой.

Тэгтэл 76 гишүүнтэй байсан үеийнхээ дэгээр бид нар шийдэж байх ёстой гээд яахад чинь өнөөгийн бидний парламентын ардчиллаа төлөвшүүлэх гэсэн, төгөлдөржүүлэх гэсэн бүх өөрчлөлтийн маань амин сүнсийг алдагдуулна шүү дээ. Тэгвэл бид 126 болсноо үгүйсгэж байна гэсэн үг шүү дээ гишүүд ээ. Яагаад энэ амин сүнс парламентын ардчиллаа бэхжүүлж, төлөөллийг сайжруулж, төлөөллийн ардчиллаа бэхжүүлэх гэсэн энэ зарчмаасаа ухрах гээд байгаа юм бэ. Энэ чинь буруу практик болно.

Ийм учраас энэний төлөө гишүүдийгээ ялладаг, шүүдэг индэр байж болохгүй. Хуралдаан даргалагч бол нийт гишүүдэд тэнцвэртэй мэтгэлцэх боломж олгох зорилготой. Ийм ч учраас энэ мэтгэлцээний энэ 1, 2 гээд индрийг хүртэл тавиад бид нар чинь нэг нотлогч, няцаагч тал хүртэл мэтгэлцдэг болоод бид мэтгэлцээд байгаа биз дээ тийм ээ? Ингэж ард иргэдийнхээ мэдэх эрхийг хангаж, аль аль талынх нь мэдээллийг сонсож, тэгээд тэрэн дундаас зөв шийдвэр гаргах нь парламентын мэдэгдсэн энэ үндсэн зарчим юм байгаа юм.

Өнөөдөр нэг юманд гайхаж байгаа нь нэг тал нь энэ 70-аад оныхон бүгдээрээ ийм муу хүмүүс, нөгөө залуучууд нь шинэчлэгч, аль эсвэл юм мэдэхгүй байгаа юм шиг ийм яриа байж болохгүй. Манай залуучууд сайхан залуучууд. Би энэ залуучуудын шинэ санаачилгыг дэмжиж ажил.../минут дуусав./

Х.Булгантуяа: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Батболд гишүүнтэй би санал нэг байна аа. Би Үндсэн хууль тайлбарлаагүй байхгүй юу Батболд гишүүн ээ. Үндсэн хуулийг баталсан тэр архив, танилцуулга нь энэ байгаа. Энэ ингээд ном болоод хэвлээд гарчихсан. Би энийг л яриад байгаа юм. Редакцын зөвлөл Лүндээжанцан гуай, Өлзийсайхан одоо Цэцийн гишүүн. Танилцуулга бичсэн Хатанбаатар, Товуусүрэн, Лувсанжав, Болормаа. Би ерөөсөө Үндсэн хуулийг зохиож тайлбарлаагүй. Юу батлагдсан бэ тэрийг нь, танилцуулгыг нь та бүгдэд хэлж өгч байгаа юм. Энэ дэг зөрчигдөх юу ч байхгүй. Өнөөдөр харин Монгол Улсын Ерөнхий сайд, нэр бүхий сайд нар Цэц рүү халдаж Цэцийг улс төрийн зорилгодоо ашиглаж энэ гараагүй шийдвэр дээр яаж Цэцийн маргаан үүсгэж чадаж байна аа? Би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Ийм шийдвэрийг тухайн үедээ 1 удаа гарч байсан юм. Тэгээд Амарсанаа гээд Цэцийн гишүүн өөрөө огцорч байсан байхгүй юу. 3.Энхболд даргын үед.

Х.Булгантуяа: 1 номер Баасандорж дарга үүн дээр тайлбар өгөөдөх өө. Сайд нар асуултад хариулна гээд байх юм. 1 номерын микрофон.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу гишүүд асуулт асууж, үг хэлэх эрхтэй. Ерөнхий сайд болон санал гаргасан Сайнзориг нарын 54 гишүүн бол асуусан асуултад хариулах үүрэгтэй. Энэ бол чуулганы хуралдааны дэгийн зарчим байгаа.

Х.Булгантуяа: Батболд гишүүн нэмж асууя.

Р.Батболд: Нөгөө энэ чинь хэзээний ч үг байдаг юм. Алах хүний үгийг сонс ч билүү нэг тийм л юм байдаг юм байна лээ уул нь. Тэгээд энэ огцрох гээд байгаа сайд нар нь хариулахгүй, тэгээд шийдвэр гарга гэдэг нэг ийм юм руу явж байгаа юм байна. Яах вэ, яах вэ болж л байна.

Энэ Сандаг-Очир гишүүнээс нэг юм асуучих уу, болохгүй билүү? Энэ чинь яасан нөгөө гарын үсэг зурсан гишүүн мөн үү, биш үү? Мөн үү? Сандаг-Очир гишүүн ээ та зурсан уу айн? Энэ асуудлыг бид нар түрүүчийн долоо хоногт уул нь шийдчих боломжтой байсан юм аа. 18 цаг болоод ажил тарсан гээд хаачихсан 10 хүний асуултыг байхгүй, завсарлуулсан. Гэтэл өнөөдөр ч өчигдрийн хурал чинь ирц нь хүрээгүй, эхлээгүй хурлыг өнөө өглөө болгоод ингээд өнөөдрийн хурал ч байгаад байгаа юм уу, өчигдрийн хурал ч байгаад байгаа юм уу. Энэ чинь өчигдөртөө оччихсон ч юм шиг ийм хачин юм яваад байх юм. Энийг та хэд.../минут дуусав./

Х.Булгантуяа: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандаг-Очир дарга хариулъя.

Ц.Сандаг-Очир: Манай Байнгын хороо яагаад завсарласан юм бэ гэж асууж байх шиг байна. Манай Байнгын хороо Үндсэн хуульд заасны дагуу нэр бүхий гишүүд Ерөнхий сайдыг огцруулах асуудал албан ёсоор өргөн барьсан учраас Үндсэн хуульд заасан 3 хоногийнх хугацаа 3 хоногийнх нь дараа хэлэлцэж эхлээд 10 хоногт нь хэлэлцэж дуусах асуудал түрүүлж Байнгын хорооныхоо хурлаар оролцож санал, дүгнэлтээ гаргах ёстой. Энэ хуулийн дагуу, чуулганы хуралдааны дэгийн дагуу Байнгын хорооны хурлууд явагдсан. Завсарлуулах үндсэн шаардлага 2 удаа завсарлуулсан нь үнэн. Баасан гаргийн хуралдаан бол 18 цаг дууссан байсан учраас хуралдааныг завсарлуулсан. Энэ нь өөрөө Дэгийн тухай хууль дээр хуралдаан даргалагчийн эрхийн хэмжээнд санал хураалтыг товыг тогтоох эрхтэй гэж заасны дагуу хойшлуулсан. Даваа гарагт.../минут дуусав./

Х.Булгантуяа: Сандаг-Очир гишүүний микрофоныг нэмж өгье.

Ц.Сандаг-Очир: Даваа гаргийн хойшилсон учир шалтгаан Баасан гаргийнхаа ирцээр эхэлсэн боловч хурал 35 минут хүлээгээд нэг намын төлөөлөл 4, 5-хан хүн ирсэн байсан. Бүхэл бүтэн Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах хэмжээний асуудал ярьж байхад нэг намын 5 хүн сууж байгаад 32 гишүүнтэй Байнгын хорооноос 5 хүн сууж байгаад тэгээд 5-уулаа санал хураагаад шийдэж болохгүй юм аа. Байнгын хорооны даргын нэг үүрэг бол Байнгын хорооныхоо гишүүдийн оролцоог хангаж, намуудын төлөөллийг хангаж тэнцвэртэй байх үүднээс ийм байдлаар хуралд явж болохгүй ээ, ирцээ бүрдүүл ээ гэдэг үүднээс Даваа гаргийн хуралдааныг хойшлуулсан, эрхийн хүрээнд хойшлуулсан. Ингээд өчигдөр 3 дахь удаагийн хурал хуулийн дагуу хугацаандаа эхэлж асуудлаа шийдээд явсан. Энд ямар нэг дэг зөрчсөн асуудал байхгүй ээ.

Х.Булгантуяа: Батболд гишүүн нэмж тодруулъя.

Р.Батболд: Энэ сүүлчийн асуух минут учраас юуг нь түрүүн хэлчихье. Би энэ та нартай та нар дундаас нэг ч хүнтэй нэг хамтарсан компани ч байхгүй, бөлдөгдүүлэх хэрэг ч хийгээгүй хүн байгаа шүү. Тийм учраас надад үгээ хэлэхэд их амар байна. Тэгээд энэ би уул нь бас нэг эдийн засгийн сургууль төгссөн эдийн засаг халти ойлгодог гэж өөрийгөө бодоод байдаг юм. Тэгээд энэ Ерөнхий сайдаас нэг юм асуучихмаар байна. Үгүй ээ энэ 3, 4 сарын дотор улсын хэмжээнд нийт төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлээд эдийн засгийг сэл хийтэл аваад явчих тийм бодлого гаргах боломж байдаг юм уу ер нь? Энэ ч би энэ

Засгийн газар ч уул нь 4 сар л болж байгаа. Одоо 4 сар болох гэж байна уу гэж бодоод байгаа юм. Үгүй ээ мэдэхгүй тэр сайд нь хэвээрээ байдаг юм уу, үгүй байдаг юм уу мэдэхгүй. Ийм юм л асуучихмаар санагдаад байгаа юм.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулья.

Г.Занданшатар: 30 жил шийдэж чадаагүй асуудлыг 3, 4-хөн сарын дотор шийдчихнэ ч гэж юу байх вэ. Тэр тусмаа гадаад нөхцөл байдал, хүнд нүүрсний үнэ манай экспортын гол бүтээгдэхүүн нүүрсний үнэ 2 дахин буурсан. Инфляц өссөнөөс ард иргэдийн амьдрал хүндэрсэн. Өндөр инфляцаас болоод зээлийн хүү өндөртэй, төсвийн алдагдал үлэмж нэмэгдсэн ийм нөхцөлд тэгээд төсвийн орлого нь 3.3 их наядаар тасарч байхад, орлого нь тасарч байхад яаж зардлаа нэмэгдүүлэх вэ? Харин нийт ард иргэдийнхээ татварын ачааллыг бууруулаад, дарамтыг бууруулаад, татварын дарамтыг бууруулаад эдийн засгийн эрс шинэчлэл хийхэд ийм бодлогыг танилцуулсан. Харин ч энэ эрс шинэчлэл шинэ итгэл иргэдэд төрж эрс шинэчлэл хийх 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулсан. Харамсалтай нь энэ нөгөө цаг хугацааны зөрүү гарчихсан. 9 сарын 1-нд төсөв.../минут дуусав./

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж 1 минут.

Г.Занданшатар: 9 сарын 1-нд төсөв өргөн барьдаг. Харин 10 сарын 31-нд 5 жилийн үндсэн чиглэлээ өргөн барьдаг ийм зөрүүтэй. 5 жилийн үндсэн чиглэлээ урьдчилж батлаад түүндээ нийцүүлж төсвөө боловсруулж өргөн барьдаг байх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн зарчим алдагдсан зөрчсөн юм байна лээ. Энэ хүрээнд эдийн засгийн бүтцээ өөрчлөх, энэ үр дүнгүүдийг сайжруулах, эрс шинэчлэл хийх урт хугацааны төлөвлөгөөгөө танилцуулах боломжгүй болчихсон байна өнөөдөр. Ер нь бид итгэлтэй байгаа. Энэ чигээ бариад явчих юм бол Монгол Улсын эдийн засаг сэргэнэ, хөгжинө, 5 жил дотор хийж чадаагүйг бид 5 сарын дотор хийж чадна гэдэгт итгэж байгаа.

Үүний тулд л өнөөдрийн шинэчлэлт, өөрчлөлтүүд төсвийн реформыг гүнзгийрүүлэх хэрэгтэй байна. Татварын реформыг гүнзгийрүүлэх хэрэгтэй байна. Засаглалын реформыг гүнзгийрүүлэх хэрэгтэй байна. Төсвөө танаж засаглалын шинэчлэл хийж байна. Энэ авлига, хулгайтай хийх тэмцлийг бодитой болгох хэрэгтэй байна. Энэ цогц шинэчлэл.../минут дуусав./

Х.Булгантуяа: Хуралдаан даргалагчийн хувьд хуралдааны дэгийг сахиулах үүрэгтэй байгаа. Тийм учраас өнөөдөр Улсын Их Хурлын та бидний өнөөдрийн мөрдөж байгаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн, эс үгүй бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг, гишүүн хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно гэж заасан байгаа.

Дээрээс нь нэмээд энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцох нь Улсын Их Хурлын гишүүдийн бидний үүрэг. Энэ бол эрх бол биш, цөөнхийн төлөөлөл арай илүү давуу эрхтэйгээр дуртай үедээ тааллаараа орж ирж оролцдог зүйл байхгүй. Монгол Улсын чуулганы хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч л өөрийн тааллаараа оролцдог. Цөөнхийн төлөөлөл нь тааллаараа оролцоно, олонх

нь харин заавал суух үүрэгтэй гэсэн зүйл байхгүй. Гэхдээ нөгөө талдаа таны хэлж байгаа саналыг би ойлгож байна. Улсын Их Хурлын өнөөдөр Монгол Ардын намын бүлэг ийм олуулаа байж байж ирцээ бүрдүүлсэнгүй ээ гэж гэдэг утгаар хэлж байх шиг байна.

Гэхдээ нийт ард түмэн биднийг аль алиныг нь л чуулганы хуралдаандаа сууж дуу хоолойгоо болго гэсэн үүднээс дэгээ сахиулахыг шаардах нь нөгөө талдаа миний үүрэг юм. Энэ дэгийг сахиулахгүй бол би эсрэгээрээ нөгөө талдаа асуудалтай. Тийм учраас ирцдээ ор, хуралдаа суу, цаг хугацаатай асуудлыг хэлэлцье. Үндсэн хуулиар энэ цагтай юм аа гэж би та бүгдэд удаа дараа л индэр дээрээс сануулсан юм.

Улсын Их Хурлын гишүүд ээ одоо 1 гишүүний асуулт аваад тэгээд санал хураалт руу орох цаг болчихлоо. 12 цаг 30 минутаас санал хураалтыг явуулахаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 12 цаг 30 минутаас санал хураалгахаар тохирсон.

Улсын Их Хурлын гишүүн Ардчилсан намын дарга Цогтгэрэл дарга.

О.Цогтгэрэл: Энэ өдрүүдэд Монголын төр хэрхэн яаж доройтолд орсныг, дампууралд орсныг, идээ бээр хэрхэн, яаж гадагшийгаа хагарч байгааг та бүхэн бүгдээрээ харж байна аа. Юун тэр парламентат ёс, хууль дээдлэх ёс, Үндсэн хуулийг дээдлэх, зөрчсөн эсэх асуудлыг тоож байгаа ч юм тал талдаа алга. Ийм л нөхцөл байдалтай тэр хэлэгдэж байгаа хулгай зэлгээний тоо хэмжээ, гэмт хэргийн хүрээ хязгаар зах хязгаараа алдчихсан ийм л нөхцөл байдалд бүгдээрээ ард иргэд гайхах нь гайхаж, шогшрох нь шогшорч, зэвүүцэх нь зэвүүцэж байгаа байх. Ийм л нөхцөл байдалд хэдүүлээ ингээд сууж байна. Тэгээд энийгээ бид нар бүгдээрээ улс төр хийж байна гэж ярьдаг. Улс төр хийж байна гээд. Яг үнэндээ тэр улс төр гэдэг үгний нөгөө талд нь төр улс гээд нэг ойлголт байх шиг байгаа юм. Төр улсын тухай ойлголт. Та бид нараас яг улс төрөөсөө гадна тэр төр улсын ойлголт, төр улсын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг яг одоо цагт бас энэ нийгэм, олон нийт, Монгол улсын эрх ашиг бид нараас шаардаж байна гэж бид бүхэн үзэж байгаа.

Тийм ч учраас Ардчилсан нам болоод Ардчилсан намын бүлгийн зүгээс тодорхой шийдвэр гаргасан. Яг одоо төрийнхөө дээр гарчихсан зөвхөн институтийн дээр гарсан албан тушаалтнууд энэ институтийг нураах хэмжээнд хүрчихсэн байгаа энэ нөхцөл байдалд дүгнэлт хийх ёстой, цэг тавих ёстой гэж Ардчилсан нам болоод Ардчилсан намын бүлгээс тодорхой шийдвэр гаргаж эдгээр хоёр төрийн өндөр албан тушаалтныг хоёуланг нь огцруулах санал өгөх нь зүйтэй гэдэг ийм нэгдмэл байр суурь гаргасан, нэгдүгээрт.

Тэгээд энэ нь өөрөө зүгээр нэг албан тушаалтнуудыг огцруулахын төлөө хийж байгаа үйлдэл гэж бид бүхэн үзэхгүй байгаа. Энэний цаана төр нь төр шиг, олонх нь олонх шиг, цөөнх нь цөөнх шиг байх ёстой юм байна аа. Тэр тусмаа олонх олонх шиг байж чадахгүй болчихсон байгаа тохиолдолд бид нар цөөнх нь ядаж цөөнх шиг байхыг хичээе ээ. Нэгдмэл байр суурьтай байя. Асуудалд зарчимтай хандъя. Ард иргэд нь төрөө барьдаг ёстой юм бол, олонх нь засаглах ёстой юм бол цөөнхөд ноогдсон үүргээ цулаараа бид нар биелүүлье ээ. Ийм учраас цөөнх нэг талдаа зарчмын шаардлагыг тавих ёстой гэдэг үүднээс эдгээр

өндөр албан тушаалтнуудыг хоёуланг нь огцруулах энэ зарчмын байр суурь дээр Ардчилсан нам хүрсэн.

Тэгээд өнөөдрийн 2 санал хураалтад Ардчилсан намын бүлгийн гишүүд нэгдмэл байр суурьтай хоёуланг нь огцруулах ёстой гэдэг байр суурин дээр бид нар байр сууриа, кнопоо илэрхийлэх ёстой. Тэгээд энэ бүгд ер нь шударга ёсны төлөө, Монгол Улсын Үндсэн хууль парламентын засаглалын төлөө хийж байгаа, олонх нь олонх шиг байх, цөөнх нь цөөнх шиг байх ёстой энэ зарчмын байр суурийн төлөө хийж байгаа үйлдэл гэдгийг та бүхэндээ хэлье ээ. Ингээд Ардчилсан нам тодорхой байр суурьтай энэ хуралд бүлгийн нэгдмэл байр суурийг дэмжиж илэрхийлж оролцох ёстой гэдгийг дахин давтан хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу энэ асуудлыг хэлэлцэж байхад Монгол Улсын Ерөнхий сайд үг хэлэх эрхтэй байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд таныг индэрт урьж байна.

Асуулт, санал дууссан. Санал хураалтдаа бэлдэнэ үү.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Яг 4-хөн сарын өмнө 92 хувийн саналаар Монгол Улсын Ерөнхий сайдаар итгэл хүлээлгэн дэмжсэн эрхэм гишүүд та бүхэнд үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ гэдэг үнэн үгэнд итгэдэг учраас үнэн бодит байдлын талаар хэдэн үг хэлье ээ.

Өнөөдрөөс 125 хоногийн өмнө төрийн чадамж суларч иргэд төрдөө итгэх итгэл алдарч, эдийн засгийн өсөлт 2 дахин унаж, 2.6 хувь болж, гадаад валютын нөөц огцом буурч, 1 долларыг 4000 төгрөгөөр худалдаж авах үнийн өсөлт 15 хувийг давах, төсвийн орлого 3.3 их наядаар тасрах бодит гадаад, дотоод эрсдэлтэй бид нүүр тулсан.

Ийм учраас Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдохдоо үнэнийг хэлдэг Засгийн газар байна гэсэн хэлсэн үгэндээ эзэн байж, олон түмний хүсэж шаарддаг, овоорч хураагдсан асуудлын томыг, бэрхшээлийн хүндийг шууд барьж авч шуурхай шийдэхээс ажлаа эхэлсэн. Мэдээж 4 жил овоорсон асуудал, овоолсон хогийг 3 сарын дотор бүгдийг нь шийдэхгүй ч үндэс углуургаар нь цэгцлэн цэвэрлэж эхлэн үрэлгэн данхар төсвийг түүхэнд анх удаа та бүхэнтэй хамт 2.2 их наядаар танасан.

Энэ хүрээнд бид төрийн албаны шинэчлэл, засаглалын шинэчлэл, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн шинэчлэл, дижитал шинэчлэл гэсэн 5 цогц шинэчлэлийн бодлогыг дэвшүүлж тавьсан. Энэ бүхний үр дүнд эхний 7 сард 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай байсан улсын төсөв 8 дугаар сард 8 дугаар сарынхаа дүнгээр 53 тэрбум төгрөгийн ашигтай болж эргэн ирсэн. Аль нэг хүнтэй биш асуудалтай өрсөлдөх нь Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын үндсэн үүрэг гэсэн өндөр итгэл үнэмшилтэйгээр ажилдаа шууд орсон. Бид үнэнтэй нүүр тулсан. Нүүрсний үнэ өндөр байхад олсныхоо хэрээр цацаж өв биш өр үлдсэн үнийн өсөлттэй тулсан. Нүүрсний үнийн өсөлтийг өгөөж болгохын оронд өөрсдийгөө илүү хангадаг данхар төр үрэлгэн тансаг төсвийн гашуун үнэнтэй тулсан. Ард түмний баялгийг бид тамга дарж нуусан үнэнтэй ч тулсан. Эмч, багш, ахмад энгийн иргэд

орлого нь хүрэлцэхгүй амаргүй, эрх мэдэлтнүүд нь орлого, зарлагаа нотолж, авлигал, хээл хахуультай тэмцэхээс хойш сууж байна гэсэн ард иргэдийн шүүмжлэлийн гашуун үнэнтэй нүүр тулсан.

Баялгийн эсрэг тэмцэл, эдийн засгийн сэргэлт хоёр бол нэг зоосны хоёр тал юм. Сүлдтэй тал нь тэмцэл бол тоотой тал нь эдийн засаг гэсэн юм. Хулгай тонуулд өнгөтэй өөдтэй өмч хөрөнгө, үр өгөөжөө алдаад байгаа айл өрх, хүн ч гэсэн өөдөлдөггүйтэй адил бид энэ шүүрхий шанага шиг эдийн засаг, төсвөө бөглөж тэмцэж байж эдийн засаг сэргэж болохыг бид бодит гүйцэтгэлээр харуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-д бид 7 дугаар сарын 9-нд онцгой дэглэм тогтоосон. Энэ хугацаанд нүүрсний олборлолтын борлуулалтыг 1.6 дахин өсгөсөн. Улсын гадаад валютын нөөц ердөө 3, 4-хөн сарын дотор 1 тэрбум доллароор нэмэгдэж эдийн засгаа сэргээлээ. Валютын ханшийг тогтворжууллаа, үнийн өсөлтийг ч гэсэн тогтворжууллаа.

Төрийн албаны шинэчлэлийг зоригтой эхлүүлж данхар төрийг чадварлаг төрөөр халах үндсийг тавьж амжлаа. Төрийн албан хаагчийн тоог 14.4 мянгаар бууруулж, давхар бүтэц, үр ашиггүй зардлыг танаж, 261 тэрбум төгрөгийн бодит хэмнэлт хийлээ. Уул уурхай, нүүрснээс хамааралтай манай эдийн засгийн гол бас нэг хөдөлгүүр бол “Эрдэнэс Тавантолгой” компани юм. Стратегийн орд юм. Ард түмний эзэмшлийн стратегийн орд юм. Нүүрсний эдийн засгийн экспортын талаас илүү хувийг эзэлдэг нүүрсний үнэ 2 дахин унасан энэ хүнд үед биржийн арилжаа, худалдаа нь үндсэндээ зогссон “Эрдэнэс Тавантолгой” компанид 7 дугаар сарын 9-ний өдөр дэглэм тогтоосныхоо дараа газар дээр нь очиж 7 дугаар сарын 19-ний өдөр хяналт шалгалт хийж ажилласан.

Ингээд газар дээр нь очоод ажиллахад тус компанид ажиллаж байгаа Дотоод хяналт шалгалтын хэлтсээс ирүүлсэн мэдээллийн дагуу олон асуудлууд ил тод болж эхэлсэн. Ингээд энэ 7 дугаар сарын 19-ний өдөр Тавантолгой уурхай дээр очиж ажиллахад ёстой нөгөө мянга сонсохоор нэг үз гэдэгчлэн ямар их үрэлгэн зардал, үр ашиггүй хөрөнгө оруулалт, тэр баяжуулах үйлдвэр, конвер, нүүрсний хулгай ямар олон хэлбэртэйг олж мэдэн үүнийг засахгүйгээр, гол хөдөлгүүрээ засахгүйгээр эдийн засгийн локимотив урагшилж ажиллахгүйг бид бол баттай ойлгосон. Энэ ард түмний эзэмшлийн компанид асар их хулгай, луйвар л нүүрлэсэн байсан.

Ийм учраас энэ хулгай, луйвруудыг хянаж шалгуулахыг тэдний дотоод хяналтын газарт нь үүрэг болгосон. Энэ компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар хянаж шалгаж, хууль хяналтын байгууллага Авлигатай тэмцэх газарт энэ асуудлуудаа шилжүүлсэн юм байна лээ. Үүний үр дүнд нэг талаасаа хяналт шалгалт яваад ирэхээр Эрдэнэс Тавантолгойн онцгой дэглэмийн үйл ажиллагаа ч сайжирсан, үр ашиг ч нэмэгдсэн. Нөгөө талдаа тэнд байгаа олон асуудлуудыг хууль хяналтын байгууллагууд шалгаж энэ хяналт шалгалтын ажлаа улам эрчимжүүлж, өмнө нь шалгаж байсан асуудлуудтайгаа холбож эрчимжүүлж эхэлсэн юм билээ.

Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийг хангахын тулд улсын, Засгийн газраас баялагтаа эзэн байх энэ зорилтыг хэрэгжүүлж Засгийн газрын хуралдаанаас Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан стратегийн орд газруудад бас хяналт шалгалт хийхийг, зөрчлүүдийг хууль хяналтын

байгууллагуудаар шалгуулахыг үүрэг болгосон. Тэр Төгрөг нуур, Цайрт Минерал, Ухаа худгаасаа аваад бүх стратегийн орд газрууд дээр хяналт шалгалтыг эрчимжүүлэх үүрэгтэй. Тавантолгой дээр ч гэсэн энэ хяналт шалгалтын ажил эрчимжсэн.

Нүүрсний хулгайн эсрэг тэмцэл эрчимжихийн хэрээр улс төрийн элдэв саад, тээг Засгийн газрын өмнө босож эхэлсэн. “Эрдэнэс Тавантолгой” компанид онцгой дэглэм тогтоож, хулгайтай тэмцсэний үр дүнд нүүрсний экспортын орлого сүүлийн 2 сард 513.8 сая доллароор өссөн нь одоо энэ бодит үр дүн, жишээ. Тоо худлаа хэлдэггүй. Энэ Эрдэнэс Тавантолгой дээр ганцхан улирлын дотор гарсан эрс өөрчлөлт нь эдийн засгийн сэргэлтийн, эргэлтийн шинэ гараа болсон. Улсын валютын нөөц 5.9 тэрбум доллар болж түүхэн дээд хэмжээндээ хүрлээ. Эдийн засгийн өсөлт 2.4 хувь болж унасан байсныг 5.6 хувь болж 2 дахин нэмэгдлээ. Яг өчигдөр олон улсын байгууллагууд тухайлбал Moody’s агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг өсгөж, 11 жилийн дараа B1 зэрэглэлд дэвшин орсон түүхэн сайн мэдээг бас та бүхэндээ дуулгахдаа баяртай байна. Энэ бол манай улсын эдийн засгийн сэргэлтийг олон улсын түвшинд үнэлсэн бодит факт, баримт юм.

Үүний үр дүнд гадаад, дотоод зээлийн хүү буурч, хүүгийн зардал хэмнэгдэх боломжтой болж байгаа юм. Зээлжих зэрэглэлээ дагаад энэ гадаад бонд, хүүгийн бүгдийнх нь хүү буурдаг. Зээлийн хүүгээ бууруулах шаардлагыг бид Засгийн газар байгуулагдсан анхны өдрөөсөө авхуулан Оюу толгой компанийн бүх уулзалт дээр тавьж ирсэн. Энийг Оюу толгой, Рио Тинто хүлээн авч хамтран ажиллахаа илэрхийлсэн бичгээ ирүүлсэн саяхан бас. Ингээд хүүгийн зардлыг бууруулах хэлэлцээр эхэлж Оюу толгойн төслийг ард түмэнд илүү үр ашигтай, өгөөжтэй болох ажил урагшиллаа. Энэ бодитой ажил хэрэг болж байна. Энэ асуудлыг бид 2018 онд тэр Дубайн гэрээнээс өмнө хүчингүй болгохдоо бид Засгийн газар Улсын Их Хурал дээр тавьж dividend ноогдол ашиг хүртэхгүй байгаа 34 хувийн чинь гол шалтгаан нь хүүгийн зардлаа өсгөх замаар ашигт ажиллагааг бууруулж байгаа үндсэн шалтгаан байна. Энэ хүүгийн зардлаа бууруулах ажлыг бид шаардаж байсан юм. Харамсалтай нь энэ ажил хаягдчихсан байсан. Өнөөдөр хүүгийн зардал бодитой буурах ажил бодитой боллоо.

Төр түмэн нүдтэй, түмэн олон түмэн нүдтэй гэдэгчлэн манай Засгийн газар тамга дарж нуусан бүхнийг илчилж, үнэнийг илчлэн дэлгэж, ил тод болгож, ард түмний хяналтад оруулах алхмыг хийж байна. Цаашдаа энэ ил тод байдал бол албан тушаалтны хяналтаас илүү ард түмний хяналт илүү бодитой. /минут дуусав./

Х.Булгантуяа: Гишүүд. Ерөнхий сайдын микрофоныг нэмээд өгье.

Г.Занданшатар: ... хийсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол зорилго бол Улсын Их Хурал хэрүүлийн талбар биш мэтгэлцээний танхим байх ийм зарчмыг сонгосон. Өнөөдөр харамсалтай нь асуултад хариулах ч боломж олдсонгүй. Тийм учраас үгээ дуустал хэлэх боломж олгохыг бас хүсэж байна.

Эдийн засгийн энэ сэргэлт бол баялгийн хулгай, нүүрсний хулгайтай хийсэн тэмцлийн гарцаагүй үр дүн юм. Иргэндээ нээлттэй нийгэм бол эрүүл, зөв байдаг зүйл зарчмыг бид ягштал баримталж ажиллаж байна. Энэ бүх тэмцлийн эцсийн эрхэм дээд үр дүн бол өсөлтийг өгөөж болгон Монгол айл, өрх болгонд хүрэх

явдал юм. Бид бүх Монголыг дээрэмдсэн баялгийн хулгайтай тэмцээд эмч, багшийн цалин, ахмадын тэтгэврийг өсгөх гэж Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдсон. Энэ бол бидний санаачилж хэрэгжүүлсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн бас амин сүнс нь учраас үүнийгээ бид бодитой хэрэгжүүлэх үүрэгтэй гэж ойлгосон. Бид Монгол Улсын Засгийн газар баялагтаа эзэн Монголчуудын төлөө ухрах эрхгүй тэмцэх гэж бүрдсэн. Хүний хөгжил бол манай Засгийн газрын хамгийн том төсөл гэж зарлан ажилдаа орсон үр дүн ч гарч байна. Хүний хөгжлөө дэмжихийн тулд бид баялгийн хулгайтай тэмцсэн тэр орлогоор Үндэсний баялгийн сангаа арвижуулж байж, бодитой хэрэгжүүлж байж энэ үр дүнд хүрнэ гэж үзсэн юм.

Одоо цалингаа нэмэгдүүлэхээр эмч, багш нар жагсаж, цас шуурга орон даяар дэгдэж, хахир өвлийн аман доор ордонд ажил биш улс төр буцалж байна. Хэрүүл биш ажлаа хий, өвөл айсуй, өвс тэжээл, гэрэл цахилгаан, ус дулаан, түлш шатахуунаа анхаар гэж цаг улирал, ард түмэн, амьдрал өөрөө та биднээс шаардаж байгаа. Бид Улсын Их Хурлын даргыг нүүрсний хулгайтай тэмцэж, эдийн засгаа сэргээн шийдэмгий ажиллаж буй ийм бодит үр дүн гаргаж байгаа засгийн газраа дэмжиж ажиллана гэж ч бодсон болохоос өөрөө гардан зохион байгуулах, огцруулах ийм ёс зүйгүй, хууль, дүрэмгүй төрийн ажлыг гацаасан үйлдэл, эс үйлдлүүд нь Үндсэн хууль, засаглалын хямралд түлхэн оруулсанд Ерөнхий сайдын хувьд ч гэсэн харамсаж байна аа.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид энэ парламентын засаглалаа бэхжүүлж, цэгцрэх хөдөлгөөн өрнүүлж, хагарсан цонхнуудаа шиллэж чадна гэж итгэж бид сүүлийн 12 жилийн эрдэм судалгааны болон хууль тогтоох ажлаа зориулж ажилласан. Үүний үр дүнд бид энэ 126 гишүүнтэй төлөөллийн чадавхтай парламентыг бүрдүүлэх энэ боломжийг хамтдаа шийдсэн. Бид зөвлөлдөх ардчиллын үзэл санааг нэвтрүүлж, ард иргэдтэйгээ зөвлөлдөж 2017 онд Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулж, 2023 онд Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулж энэ 126-тай ард иргэд дэмжихгүй байхад энэ төлөөллийн чадавхыг хангасан парламентыг бүрдүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж чадсан. Энийг бид 12 жилийн өмнө санаачилж байсан юм. Гишүүдийнхээ тоог нэмж, парламентын ардчиллын төлөөлөх чадавхаа бэхжүүлэе гэж. Тухайн үед 108 гишүүнтэй болъё гээд 2, 3-хан гишүүнээр 2019 онд унаж байснаа бид 23 онд гүйцээсэн юм. Энэ бол зөвхөн миний санаачилга биш Ардчилсан нам, Ардын намын олон гишүүд энийг санаачилж ажиллаж байсан.

Гэтэл 126 гишүүнтэй болсон парламент маань 76 гишүүнтэй байсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр тэр үеийн Үндсэн хуулийн заалтаар асуудал шийдэх гэж зөрүүдэлж байгаа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн энэ үзэл санаагаа, 126 гишүүнтэй болсон парламентизмын үзэл санаагаа гуйвуулж байгаа хэрэг мөн. Энэ танхимд 2 өдөр хуулийг бас уландаа гишгэж Үндсэн хууль зөрчсөн асуудлаар чуулганд оролцохгүй эрхээ эдэлж байгаа ард түмний төлөөлөгч гишүүдийг нэг хүн өдөржин хууль зөрчин тайлбарлаж, доромжилж, хязгааргүй эрх эдэлж байгаа дабл стандарт үйлчлэхийг харлаа. Хэдхэн хоногийн өмнө Төрийн байгуулалтын байнгын дээр 6 цаг боллоо гээд хурал хааж байсан, Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар хамаагүй Үндсэн хуулийнхаа саналаар, заалтаар санал хураалт явуулна гэж байсан энэ шаардлага гэнэт нэг өдөр өөрчлөгдөхийг ч бас харлаа. Ийм учраас бид парламентын ардчиллын үзэл санаандаа үнэнч байх нь бидний тангараг өргөсөн Үндсэн хуульдаа үнэнч байх

явдлаар илэрхийлэгдэнэ ээ. Ийм учраас Үндсэн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн үзэл санаандаа үнэнч байж энэ санал хураалт явагдах ёстой гэж үзсэн гишүүдийг буруутгах ёс байхгүй.

Дэлхийн жишиг Монгол Ардын намын дүрмийн дагуу намын дарга Ерөнхий сайд байх гэсэн зарчмыг ажиж болохоос биш албан тушаал, сандал суудалтай зууралддаг хүн би биш ээ. Монгол Ардын намын Бага хурлын гишүүдийн 67.8 хувь нь надад итгэл хүлээлгэж Ерөнхий сайдаар томилохдоо тийм шийдвэр гаргаж байна л гэж ойлгосон.../минут дуусав./

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын цагийг 3 минутаар. Бид нар санал хураалтын энэ нөгөө Үндсэн хуулийн цагтай байгаа юм гишүүд ээ. Энэ өөрөө, үгүй ээ харин тэр 1.30-даа санаа зовоод байсан юм бол та бүхэн өчигдөр цагтаа ирэхгүй дээ. 3 минутаар сунгая.

Г.Занданшатар: Авлига, хулгайтай тэмцэж улам бүр суларсан төрийн нэр хүнд, эдийн засгаа сэргээхэд зөвхөн захиргааны эрх мэдэл хангалтгүй улс төрийн эрх мэдлээр хүч нэмэх нь ард түмнээс авсан үүрэг, даалгавраа биелүүлэх илүү үр дүнтэй ажиллах боломж юм.

Тавантолгойн нэг толгой Бор тээгийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж, хүний хөгжлийн төлөө зарцуулах тогтоолын төслийг 9 дүгээр сарын 1-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Гэвч Ерөнхий сайдаа намын дарга болох дүрмээ хэрэгжүүлбэ гэж ажиллаж байсан нөхөд маань үүний дараа бодол, санал нь гэнэт өөрчлөгдсөн. Нүүрсний хулгай Бор тээгийн ордтой Амарбаясгаланг холбоо хамааралтай гэдгийг би итгэхийг хүсээгүй ээ. Харамсалтай нь нүүрсний сонсголоор олон нотлох баримтууд нь шалгагдаж саяын энэ Тавантолгой дээр явагдсан хяналт шалгалтын үед сэргэсэн юм байна лээ. Би гаднын нэг сайтын мэдээллээр ийм асуудал яриагүй. Сайт дээр 2 жилийн өмнө гарсан мэдээллийг яагаад няцаагаагүй юм бэ л гэж асуусан. Үнэн хариулаагүй. Тагнуулын шинжээчийн дүгнэлт гэж худлаа хэлсэн. Тэр дүгнэлтээ бол гишүүдэд тарааж өгөх хэрэгтэй. Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн бүхэл бүтэн нүүрсний тээврийн худалдааны сүлжээг open data эх сурвалжуудаар нотолж, нүүрсний сонсголоор олон нотлох баримтаар үндэслэн шалгагдаж байгаа юм билээ. Ерөнхий сайд Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ийм учраас Баттөмөрийн Энхбаярыг томилох шийдвэр гарган Улсын Их Хуралд танилцуулахаар хүргүүлсэн боловч одоо хүртэл хойшлуулсаар байгаа.

Харин өнөөдөр энэ нь намайг огцруулах шалтаг, шалтгаан болж байна. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нүүрсний сонсгол зохион байгуулж, нотлох баримтуудаа нийгэмд дэлгэн шүгэл үлээж 2 жил гаруй хугацаанд шударга ёсны төлөө тэмцэж байгаа Амарбаясгалангийн зүгээс энэ асуудлаар давуу эрх олгосонтой холбоотой асуудлаар гүтгэсэн хэмээн нэг ч удаа хууль хяналтын байгууллагад өгч байгаагүй нь анхаарал татдаг учраас энэ асуудлаа энэ танхимдаа шийд гэж би энэ шийдвэр гаргасан юм.

Би хулгайтай эвлэрэх гэж тэмцээгүй ээ. Би хулгайтай хамт унах гэж тэмцээгүй. Харин ард түмэнтэйгээ хөгжил дэвшил өөд хамтдаа босох гэж тэмцсэн. Хулгайтай эвлэрдэг хууль гэж байх ёсгүй. Монгол Улсын Ерөнхий сайд би улс

орноороо наймаалцахгүй, нүүрсний хулгайч нартай тохиролцохгүй, эв нэгдэл, зөвхөн шударга ёсонд үндэслэн тулгуурлах учиртай. Улсын төсвөө хэлэлцэн батлах, улс орны өмнө тулгамдсан асуудлаа шийдэх, урдах ажлаа хийхгүй бол аймаг, нийслэл, сум, дүүрэг төсвөө баталж чадахгүйд хүрнэ. Эмч, багшийн цалинг нэмэх нь бүү хэл төрийн албан хаагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өл залгах төдий болох аюулын ирмэг дээр байна. Өнөөдөр уг нь энэ танхимд 47 хоногийн өмнө өргөн барьсан эдийн засгийн эргэлтэд Бор тээгийн ордыг эргэлтэд оруулах асуудлыг хэлэлцэх байлаа. Харин энэхүү тогтоолын төсөл Засгийн газрын өмнө босгосон саад, тээг болж байна аа.

Гэвч үзэл санаа зөв зарчим дээрээ байх цагт үнэн хэзээд ялна гэдэгт би итгэдэг. Өнөөдөр.../минут дуусав./

Х.Булгантуяа: Бүгдээрээ. Үндсэн хуулийн цаг нартай асуудал явагдаад байгаа юм аа гишүүд ээ. Ерөнхий сайдын минутыг 2 минутаар сунгая.

Г.Занданшатар: Эв нэгдэл, шударга ёсонд үндэслэн тогтох учиртай. Тийм учраас би үгээ товчилъё. Өнөөдөр уг нь бид эмч, багш нарын цалин, ахмадуудын тэтгэврийг өсгөх, нэмэх талаар ухаан бодлоо уралдуулах байлаа. Харамсалтай нь Монгол Улсын Засгийн газыг 100 гаруйхан хоногийн дараа огцруулах эсэх хэрүүл хийгээд сууж байна. Монгол Улсад тогтвортой хэрүүл бус тогтвортой засаг хэрэгтэй. Монгол Улсад хулгай засаглах уу, хууль ёс засаглах уу гэдэг салаа замын уулзвар дээр та бид ирээд байна. Ийм учраас хууль ялах уу, хулгай ялах уу гэдэг хурууны хээтэй, төрийн тамгатай түүхэн сонголтын өмнө та бүхэн зогсож байна аа. Эдийн засгийн сэргэлт, нүүрсний хулгай хийх тэмцэл бол нэг зоосны хоёр тал юм аа.

Монгол эх оронд минь хууль ёс ялах болтугай. Мөнх хөх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай.

Х.Булгантуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар үг хэллээ.

Үндсэн хуулийн зүйл, заалтын дагуу 3 хоногийн дараагаар хэлэлцэн эхэлж, 10 хоногийн дотор хэлэлцэж дуусах ёстой байгаа. Бидний цаг одоо тулаад байгаа учраас саналын томьёоллоосоо авхуулаад Тамгын газраас тодруулах зүйлүүд байна. Үүнийг тодруулаад санал хураалтдаа орох ёстой байгаа.

Нэгдүгээрт 1 номерын микрофон дээрээс энэ саналын томьёоллыг Үндсэн хууль зөрчөөд байна аа гээд бүтэн 24 цагийн маргаан боллоо. Нэг хэсэг гишүүд маань чуулганыхаа хуралдаанд орсонгүй. Бид уг нь үүнийг нээлттэйгээр хэлэлцээд, бүгдээрээ үгээ хэлээд, асуултаа асуугаад ингээд явах цаг хугацааны хувьд бол бүрэн боломжтой байсан. Харамсалтай нь ингээд тулгачихаар хэн хэндээ хэцүү болчихлоо.

1 номерын микрофон дээрээс Улсын Их Хурлын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж дарга саналын томьёолол энэ Үндсэн хууль зөрчиж байна уу, үгүй юу, өмнө нь ямархуу явж байсан энэ талаар гишүүдийн энэ асуугаад байгаа асуултыг хариулаадхаач, тайлбарлаач.

Б.Баасандорж: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Би ямар нэгэн хууль тайлбарлахгүй ээ. Яг хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу Дэгийн хуулийг хэрхэн, яаж хэрэглэх талаар зөвлөх үүрэгтэйгийн үүднээс би та бүхэндээ зөвлөө. Би бол хууль тайлбарлах ер нь хэн ч, гишүүн ч тэр, манай багш нар ч тэр хэн ч Үндсэн хуулийг зөрчсөн гэж дүгнэхгүй зүгээр саналаа илэрхийлэх эрх нь бол мэдээж байгаа байх аа.

Ирцтэй холбоотой, ирц бүрдүүлэлттэй холбоотой гишүүд маань нэлээн олон гишүүд өнөөдөр хөндлөө. Тэгэхээр манай Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйл бол хуралдааны тов, дараалал тогтооход баримтлах журам гэж байдаг. Энэ журмын 6.2 дээр нэгдсэн хуралдаан 7 хоног бүрийн Пүрэв, Баасан гарагт хуралдана. Пүрэв, Баасан гаргийн 10 цагаас хуралдахдаа гишүүд өглөө 09 цагаас эхлэн ирцэд бүртгүүлж хуралдаанаар асуудал хэлэлцэхэд бэлтгэнэ гэсэн.

Өчигдөр буюу 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 09 цагаас ирцэд бүртгүүлж эхэлсэн. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг ирцэд бүртгүүлсэн 61 гишүүн чуулганы танхимд байсан. Манай Тамгын газраас хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх хүрээнд энэ чуулганы хуралдааны ирц бүртгэлийн ажлыг хариуцан 9 цагаас эхлээд 25 цаг 15 минут 61 гишүүн, мөн манай Тамгын газрын холбогдох нэлээд албан тушаалтнууд ажилласан гэдгийг хэлье. Мөн гишүүд бас өчигдөр, өнөөдөр болон нэлээд олон өдөр энэ Ерөнхий сайдыг огцруулах эсэх асуудал дээр тэр дундаа Дэгийн хуультай бас холбоотой асуудал хөндлөө.

2000, би зүгээр та бүхэнтэй товчхон дэгийг ярихад 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш нийтдээ 1992 онд анх Улсын Их Хурлын тухай хууль дээр дэгийн асуудлыг Их Хурлын үйл ажиллагаа аль алийг нь зохицуулдаг байсан.

1997 онд Дэгийн хууль тусдаа батлагдсан. Ингээд хуулиар зохицуулж байгаад 2001 оны 61 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын тогтоолоор зохицуулдаг болсон.

Дараа нь 2006 оны 14 дүгээр Их Хурлын тогтоолоор ахиад шинэчилж батлагдсан. Ингэж явж байгаад Цэц дээр Улсын Их Хурлын үйл ажиллагааг хуулиар зохицуулна гэж Цэцээс холбогдох шийдвэр гарсны дагуу 2007 онд буцаад хуулиар зохицуулж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, 2007 оны Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тэр дундаа 35 дугаар зүйлээр 2014 оны 3.Энхболд даргыг Улсын Их Хурлын дарга байхад тухайн үеийн Алтанхуяг Ерөнхий сайдын Засгийн газрын асуудлыг шийдвэрлэсэн. Мөн 2017 онд М.Энхболд Их Хурлын дарга байхад Жаргалтулгын Эрдэнэбатын Засгийн газрыг одоо энэ 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр шийдвэрлэсэн. Тэн дээр юу гэж байсан гэхээр нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны цэг, цэг, цэг, түүний дүгнэлтийг сонсож, илээр санал хураалт явуулж, гишүүдийн олонх дэмжсэн бол огцруулах тухай тогтоол батлагдсанд тооцно. Өөрөөр хэлбэл, 2020 оны хууль 2024 оны хуультай агуулга, зарчмын хувьд яг адилхан байгаа. Сонсож, илээр санал хурааж.

Ингээд 2019 онд өнөөдөр гишүүд нэлээн ярьсан. Мөн Ерөнхий сайд ярьсан. 2019 онд манай Үндсэн хуульд өөрчлөлт орсон. 43.1 дээр өөрчлөлт орсон. Энэ Үндсэн хуулийг маш олон хуульч гишүүд ярьсан учраас би одоо тодруулж хэлэх нь илүүц байх. Харин энэ 2019 оны Үндсэн хуульд нийцүүлж өмнөх парламент буюу

76 гишүүнтэй парламент Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг баталсан.

Мөн энэ 2019 оны Үндсэн хуульд нийцүүлж 2024 онд 126 гишүүнтэй парламентын Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг баталсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3.3-д чуулганы хуралдааныг хүчин төгөлдөр мөрдөж байгаа дэгийн дагуу явуулна гэж зааж өгсөн байдаг. Энэ 2 хууль маань ялангуяа сүүлийн 24 оны хууль өнөөдрийг хүртэл Цэц дээр ямар нэгэн Үндсэн хуулийн зөрчилтэй гэдэг дунд суудлын болон их суудлын ямар нэгэн шийдвэрүүд гараагүй байна аа гишүүд ээ.

Ингээд би 20 оны хууль, 24 оны Дэгийн хуулийн заалт нь дугаар нь л өөр болохоос биш 20 оны хуулийн дугаар нь 99 дүгээр зүйлээр зохицуулж байсан. 24 оны хууль нь 101 дүгээр зүйлээр зохицуулж байгаа. Бусдаар бол үг, цэг, таслал бүх зүйл яг энэ 2 зүйл адилхан байгаа гишүүд ээ.

2021 онд сая мөн гишүүд нэлээн ярилаа. 2021 онд тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайдын асуудлыг, огцруулах өргөдлийг шийдвэрлэхдээ ийм асуудлууд яригдсан байгаа. 2021 оны 1 дүгээр сарын 21-ний Пүрэв гаргийн чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс би та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Ерөнхий сайдын тухай асуудлыг хэлэлцэнэ ээ. Улсын Их Хурлын Бямбацогт гишүүн горимын санал гаргасан. Горимын санал нь хэлэлцэх асуудалтай холбоотой горимын санал гаргая аа. Би өөрийнхөө энэ саналаар огцорч байгаа тохиолдолд энэ анх удаа зохицуулах гэж байна аа, 19 оны Үндсэн хууль батлагдаад анх удаа зохицуулах гэж байна. Сая Төрийн байгуулалтын байнгын хороо бол 5.1-д заасан тухай асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг хуулиараа зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэж батална гэж заасан. Үүний дагуу бид нар Дэгийн тухай хуулийн 99 дүгээр зүйл Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх энэ дэгээр 99.2-оор Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдсан. Одоо бол 99.4-өөр одоо хуралдах шаардлагатай байгаа юм. Зохицуулсан асуудал байхгүй учраас тийм болохоор анх удаа зохицуулагдаж байгаа дэггүй таслал, хуульгүй энэ заалтыг бас бид нар 99-ийн 4-өөрөө барьж шийдвэрлэх ёстой гэж горимын санал гаргаад, хуралдаан даргалагч горимын саналаар санал хураалт явуулаад горимын санал дэмжигдсэн.

Ингээд энэ горимын санал дэмжигдсэн учраас өөрөөр хэлбэл би та бүхэндээ ахиад тодруулж хэлэх юм бол Үндсэн хуулийн 43.1 дээр Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол “Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд баталсанд тооцож, таслал шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно гэж байгаа. Яг манай одоо 101.1 дүгээр зүйл, 99.4, 101.4 хоёрт энэ 43 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэртэй яг адилхан. Уг саналыг гэдэг нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг л гэж өөр байгаа. Бусдаар агуулга, зарчим яг энэ Үндсэн хуулийнхаа дагуу Дэгийн хууль дээрээ хийж өгсөн байгаа. Ингээд санал хураалтаа хийгээд одоо хуралдаан даргалагч тухайн үед бол Монгол Улсын Их Хурлын даргаар Занданшатар дарга байсан. Занданшатар дарга Байнгын хорооны саналаар Ерөнхий сайдыг огцруулах саналыг дэмжье гэсэн горимын санал гаргая аа. КОВИД-ын үе байсан учраас 4-5 танхимаас санал хураалтын дүнг нэгтгэсэн. Ингээд санал хураалтын дүнг танилцуулсан.

Занданшатар дарга энэ санал хураалтад 63 гишүүн оролцож, 60 гишүүн дэмжиж, 95.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ. Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо. Өөрөөр хэлбэл, энэ 43 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрийг 99, Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 99-ийн 4-өөрөө Байнгын хорооны саналаар санал хураах нь зүйтэй гэж горимын санал гаргаад энэ дэмжигдсэн байна.

Тэгээд төгсгөлд нь би та бүхэндээ хэлэхэд энэ манай багш нар бас Үндсэн хуулийн зөрчилтэй энэ саналын томьёолол байна аа гэж их санал хэлсэн. Тэгэхээр яг Үндсэн хуулийн эх баригч бидний багш бол Чимэд багш нэг үгийг хэлсэн байдаг яг энэ Үндсэн хуультай, яг энэ асуудалтай холбоотой. Үндсэн хууль бол юм бүхний цуглуулга, бүхий л ажлын заавар, арга ажиллагааны технологи, горим биш ээ. Харин нийгмийн суурь харилцааны зарчмын үндсийг тогтоодог хууль юм аа. Түүний нэг үг, томьёолол нь нэг буюу хэд хэдэн зөв хууль болж дэлгэрэн хэрэгждэг ээ, дэлгэрэн хэрэгждэг жамтай. Өөрөөр хэлбэл, яг энэ Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэг маань манай Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйл болж дэлгэрэн одоо ингэж нарийвчилж зохицуулж байгаа юм гэдэг зүйлийг та бүхэндээ би Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд хариуцлагатайгаар хэлье.

Х.Булгантуяа: Үүнтэй холбоотой асуулт байхгүй. Одоо Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалтын томьёоллыг та бүхэнд танилцуулъя. Сая Ерөнхий нарийн бичгийн дарга бас ер нь танилцууллаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар өмнө нь санал хураалтыг явуулж байсан байна гээд.

Санал хураалт, саналын томьёолол Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг дэмжээгүй байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Эхлээд энэ эхний санал болж байгаа учраас ирцийн санал явуулъя. Би уг нь сая тэгээд хуруундаа ороодхооч юуг нь харъя гэж хэлсэн юм. 77 гишүүн, 33 гишүүн ороогүй байна шүү. Хуруугаа уншуулаагүй байна. Алтанхуяг гишүүн, Амарбаясгалан гишүүн, Батбаяр гишүүн, Батцэцэг сайд, Батчимэг гишүүн. Одоо уучлаарай энд ганцхан Ерөнхий нарийн бичгийн дарга үүн дээр хууль зүйн бид нарт Улсын Их Хурлын Тамгын газраас зөвлөгөө өгдөг. Тэрнээс биш хувь гишүүн нэмж дэг дээр зөвлөгөө өгдөг тийм дэг байхгүй байгаад байгаа юм.

Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар тэгэхээр санал хураалт явагдана гэсэн үг. Эхлээд ирцийн санал хураалтыг явуулъя. Ирцийн санал хураалт. Ирцийн санал хураалт.

Төрийн байгуулалтын. Сая Баасандорж дарга нэгд нэгэнгүй та бүхэнд уншиж танилцууллаа. Нийгэм олон ч гэсэн сонссон байх.

Улсын Их Хурлын гишүүд ээ санал хураалтыг явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг дэмжээгүй байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор тэгэхээр санал хураалт явуулна гэсэн үг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл.

Улсын Их Хурлын гишүүд ээ Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, саналаар санал хураалт.

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хурлын гишүүдийн нийт гишүүний олонх буюу 71 гишүүн, энэ бол яг ирцээр хэлэх ёстой. Нийт гишүүний 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нийт гишүүний олонх нь дэмжсэн бол гэж. Тэгэхээр 71 гишүүн дэмжсэн байна. Ингээд олонх дэмжсэн тул “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Та бүгдэд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай”

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.4 дэх хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулсугай.

2.Шинэ Ерөнхий сайд томилогдох хүртэл хугацаанд үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Гомбожавын Занданшатарт даалгасугай.

Энэ тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа эсэхийг асууя. Эцсийн найруулга.

Ж.Энхбаяр гишүүн эцсийн найруулгатай холбоотой. Найруулгатай холбоотой биш байвал би бас саналыг таслах эрхтэй байгаа шүү.

Ж.Энхбаяр: Хөөе Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Үндсэн хууль зөрчсөн томьёоллоор сая санал хураалт явчихлаа. Энэний үндсэн дээр Ерөнхий сайд нарыг огцруулах асуудлыг шийдэж байна. Энэ нь өөрөө нэг ёсондоо төрийн эрхийг хууль бусаар авах...

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр гишүүнээ энэ найруулгатай холбоотой ...

Ж.Энхбаяр: ... асуудал болж хувирч байна.

Х.Булгантуяа: ... та яг энэ дээр үг, үсгийн ямар найруулгын асуудал байна аа?

Ж.Энхбаяр: ... наад чинь би найруулга хэлж байна шүү дээ. Маш том найруулгын алдаа гарч байна.

Х.Булгантуяа: ...түрүүн өнөөдөр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга тайлбарлалаа. Улсын Их Хурлын Тамгын газарт та хууль, арга зүйн зөвлөгөө үзүүлдэг субъект биш байгаа.

Ж.Энхбаяр: ... чи дуугүй байж бай Булгантуяа чи. Наанаасаа битгий орилоод бай. Найруулгын буюу агуулгын маш том зөрчил рүү орчихлоо. Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг Байнгын хороо шийддэггүй. Зөвхөн Их Хурлын онцгой бүрэн эрх. Яагаад гэвэл Ерөнхий сайд огцроход Засгийн газар, Засгийн газрын мөрийн хөтөлбөр өөрчлөлтөд ордог.../минут дуусав./

Х.Булгантуяа: Энэ микрофоныг хаая аа. Та энэ найруулгатай холбоотой асуулт, санал хэлэх ёстой.

Эцсийн найруулгыг. Бямбацогт гишүүн эцсийн найруулгатай холбоотой.

С.Бямбацогт: Тэгээд Улсын Их Хурлын гишүүд хууль дээдэлнэ, хуулийг чанд баримтална гэж тангараг өргөдөг. Монгол Улсад хүн засаглах уу, хууль засаглах уу гэж бид ярьдаг. Ерөнхий сайдыг огцруулах асуудал өргөн барьсан цагаасаа эхлээд Монгол Улсын Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль маш олон зүйл, заалтыг зөрчлөө. Эцсийн санал хураалт хүртэл Үндсэн хуулийн томъёоллыг зөрчсөн ийм санал хураалт болж байна. Анхнаасаа бас дэглэсэн ийм найруулгаар микрофон, алх барьж, хүч түрж, хууль зөрчиж ийм асуудал шийдэж байгаад харамсаж байна ...

Х.Булгантуяа: Бямбацогт сайд аа яг найруулалтай холбоотой үг, үсэг ...

С.Бямбацогт: ... холбогдох хууль хяналт, Үндсэн хуулийн цэц анхааралдаа авах байх ...

Х.Булгантуяа: ... цэг, таслал үүнтэй холбоотой ямар санал байна вэ? Тэрнээс биш Үндсэн хууль зөрчсөн асуудал байвал Үндсэн хуулийн цэц үүнийг шийдэх байх аа.

С.Бямбацогт: ... Монгол Улсын бас Ерөнхийлөгч хориг тавих байх. Хууль үйлчлэх үү, хууль үйлчлэхгүй юу гэдгийг харъя. Монгол Улсад хууль үйлчлэх ёстой шүү. Хууль засагладаг байх ёстой. Хууль засагладаг байх ёстой шүү.../минут дуусав./

Х.Булгантуяа: Дараагийн асуудал. Ингээд эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Миний хувьд бол муухай л юм байна. Үгүй ээ харин тийм.

Ингээд нэгдүгээр асуудлыг Үндсэн хуулийн цаг хугацаатай асуудлыг бид хэлэлцэж дууслаа. Хэлэлцэж дууслаа.

12.59 цаг

1 цаг болж байна Улсын Их Хурлын гишүүд ээ та бүгдийг зарим нэг нь хүлээгээд нийтдээ 23, 4 цаг болсон байна. 25 цаг болсон байна тийм ээ. 25 цаг хүлээсэн байна аа. Цайны завсарлага, цайны завсарлагаа хийчхээд.

Дараагийн хоёрдугаар асуудлыг бид нар өнөөдөр 25 цаг энэ чуулганы хуралдааны ирцийг бүрдүүлэх гэж суусан гишүүд маань та бүхэн маань ядаж хүндэтгээд бид нар цагийн цайны завсарлага, ганц цагийн цайны завсарлага явах шаардлагатай байна. 14 цагийн цайны завсарлагын дараа.

13.00 цаг

Баасан гараг 17 Аравдугаар сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 02 минут

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд ээ,

Үдээс хойших чуулганы хуралдаан эхлэхэд бэлэн болж байна. 14 цаг 02 минут болсон байна. Гишүүд чуулганахаа танхимд хүрэлцэн ирнэ үү.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал

Хоёрдугаар асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал хоёрдугаар асуудал.

Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаасаа өөрөө чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг хүсэлтийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасныг баримтлан 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан өөрөө хүсэлтээ гаргасантай холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг асуулт, хариулт, үг хэлэхгүйгээр явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 73.9 хувь нь дэмжсэн болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгаланг өөрийн хүсэлтээр Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлаар ил санал хурааж, хуралдаанд оролцсон гишүүд 100 хувийн саналаар хүлээж авах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын дарга Амарбаясгалангийн Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Х.Булгантуяа: 2 цагаас үдээс хойших чуулганы хуралдаан хуралдаж байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

10,12 гишүүнээр, 13 гишүүнээр тасаллаа. Энэ нь ирцээр дахиж шинэчлэгдэх ёстой байгаа. Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайхан, Улсын Их Хурлын гишүүн Батболд нарын нэрийг, Үүрийнтуяа нарын нэрийг нэмээд оруулчхаарай.

Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд.

Р.Батболд: Энэ чинь нөгөө шөнийн хүмүүс байхгүй тэгээд өглөө ирснээрээ би хамгийн түрүүн асуух болчихлоо. Тийм, Их Хурлын дарга ер нь их чухал хүн байдаг юм байна аа гэдгийг би бас түрүүн хэлсэн. Одоо дахиад хэлмээр байна. Яагаад гэнэт огцрох болчхов гэж өөрөөс нь асуумаар байна. Огцрох юу байх дээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх гэх юм уу. Энэ сүүлийн үед жоохон эвгүй байдал харагдаад байгаа юм. Даргын зөвлөлийн хурлаар гишүүдийн бичээд өгсөн саналыг хуралд оруулахгүй байдаг, эсвэл ажил тарах гээд 5 цаг болж байхад өргөдлөө өгдөг. Тэр нь хэлэлцэх асуудлын, чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд ордог энэ тэр гээд. Тэгэхээр яах вэ нэг энэ даргын үзэмжээр явдаг ийм байдал бас байж болохгүй байх л даа. Тэгээд энэ дээр ер нь та өөрөө яг өөрийнхөө ажлыг юу гэж дүгнэж байгаа вэ? Яагаад өргөдлөө өгчхөв гэдэг.

Х.Булгантуяа: Асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эс үгүй бол өргөдлөө өгсөн Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан хариулахаар байгаа. Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Пүүжээ дарга хариулах уу? Үгүй ээ өчигдөр Даргын дэргэдэх зөвлөл дээр би өргөдлөө өгсөн. Та дэмжээд гар өргөөд хэлэлцэх асуудалд оруулаад явсан шүү дээ тийм.

Х.Булгантуяа: Амарбаясгалан гишүүний микрофоныг өгье.

Д.Амарбаясгалан: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Пүүжээ гишүүн өчигдөр Даргын дэргэдэх зөвлөл дээр өөрөө орж ирээд хэлэлцэх асуудалд энийг Төрийн байгуулалтын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааныг хэлэлцэх асуудалд оруулъя гэдгийг өөрөө дэмжсэн. Би хажууд нь сууж байсан, бас дэмжээд үг хэлж байсныг нь би санаж байна.

Батболд гишүүн яагаад өргөдлөө өгөх болчхов гэж байна. Мэдээж бас 126 гишүүнтэй парламент бүрдээд жил гарны хугацаа болж байна. Тэгээд энэ хугацаанд бас та бүхнийхээ итгэл, дэмжлэгийг авч Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлыг бас хариуцлагатай хийхийг зорьж ажилласан. Их Хурлын даргаараа ажиллаж байх хугацаандаа үндсэндээ бол олон намын оролцоотой парламентын тогтолцоог төгөлдөржүүлэх, намуудын тэгш оролцоог хангах, энэ парламентын гаргаж байгаа шийдвэрийн чанарт илүү анхаарах, парламент үндсэндээ Монгол Улсад хэрэгжиж байгаа хууль, эрх зүйн орчныг сууриар нь сайжруулах чиглэл дээр голчлон анхаарч ажиллаж ирсэн.

Мэдээж өнгөрсөн хугацаанд Монгол Ардын намын даргын сонгуульд нэр дэвшсэнтэй холбоотойгоор сүүлийн бараг 2 сар орчмын хугацаанд үндсэндээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр, тэгээд олон янзын хэлбэрээр бас нэр төрд халдсан, холбогдсон гэж олон янзаар гүтгэгдсэн ийм зүйлүүд болсон. Үүнтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс 67 гишүүн гарын үсэг зурж, огцрох шаардлагатай гэж шаардлага бичиг ирсэн. Гэхдээ уг шаардлага бичиг нь өнөөдөр хэрэгжиж байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиараа үндэслэл бүхий шаардлагатай байхыг шаардсан байсан. Хуулийн заалт нь.

Гэтэл надад ирсэн шаардах бичиг маань нэр нь холбогдож хэвлэлээр бичигдэж байгаа зүйлүүдээ түдгэлзэж шалгуул гэдэг ийм шаардлага байсан. Гэтэл яг хууль, эрх зүйн орчиндоо түдгэлзэж шалгуулах тийм нөхцөл, боломж бол байдаггүй. Тэгэхээр би тэр шаардлагыг хангаагүй гэдэг шалтгаанаар огцруулах шаардлагыг араас нь авч байгаа. Тэгэхээр нөгөө хууль, үндэслэл бүхий шаардлагаар огцруулах шаардлага яг тавигдаагүй учраас миний зүгээс та бүхний тавьж байгаа шаардлагыг хүндэтгэн үзэж өөрийн зүгээс өргөдлөө гаргаж огцрох нь зөв юм байна, парламентын үйл ажиллагаа хэвийн явагдах зайлшгүй шаардлагатай. Энэ 126 гишүүнтэй парламент Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллагын хувьд илүү дархлаатай, олон нийтийн дунд илүү нэр хүндтэй байх зайлшгүй шаардлагатай гэдэг энэ агуулгын үндсэн дээр өөрийнхөө өргөдлийг өгсөн байгаа гэдгийг бас хэлье.

Үзэмжээр ерөөсөө асуудал шийдсэн зүйл Батболд гишүүн ээ байхгүй. Та бас энэ Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд суудаггүй учраас мэдэхгүй байгаа байх. Миний хувьд Их Хурлын даргын хувьд Даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөж дан ганц намын бүлэгтэй намууд Даргын дэргэдэх зөвлөлийг бүрдүүлдэг байсан бол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулж Улсын Их Хуралд суудалтай намуудын бүлэгтэй, бүлэггүйгээс үл хамааран

дарга, зөвлөлийн дарга нар орж сууж, намын бүлгийн дэд дарга нар хуулиар таслах эрхгүйгээр орж суудаг байх буюу олон ургалч үзлээр асуудалд хандах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажилласан. Энэ ч утгаараа Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүдийн зүгээс гаргасан санал болгоныг дэмжиж ирсэн гэдгийг бас хэлье.

Х.Булгантуяа: Цогтгэрэл Ардчилсан намын бүлгийн дарга завсарлага авахтай холбоотойгоор үг авч байна аа гэж байна. Горимын саналыг бол Дэгийн тухай хуулийн дагуу өмнөх өдрийнх нь 17 цагаас өмнө албан бичгээр горимын санал гаргах ийм албан бичиг хүргүүлэх ёстой байгаад байгаа юм. Бид нар тийм дэгтэй юм байна. Тэгэхээр би бас дэгээ сахиулах ёстой болчихоод байна. Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Горимын санал гаргана. Горимын санал дээр та өмнөх өдрийнх 17 цаг гэж байна. Бид нар бүр 7 хоногийн өмнө Ардчилсан намын бүлгээс албан ёсны шаардлага өгсөн. Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг хамтад нь хэлэлцэх ёстой. Тэгэхдээ 3 шаардлагын 1 нь Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж энэ хуралдааныг удирдах нь зүйтэй юм аа гэдэг горимын шаардлагыг бүүр өмнөх өдөр биш 7 хоногийн өмнө өгсөн. Ер нь яагаад гэдэг нь бас өнөөдөр ингээд нотлогдож байна. Өнөөдөр хурал удирдаж байгаа Булгантуяа дэд дарга бас огцрох асуудалд нь орж байгаа Ерөнхий сайдад асуултад хариулах боломж олгохгүй байна та. Хамгийн сүүлд төв индэрт гараад олон нийтэд бас хандаад тэр хүн нь бэлдсэн үгээ хэлэхэд нь Монгол Улсын Ерөнхий сайдыг үгийг нь хэлүүлэхгүй байна. Хэт ингэж нэг талыг барьсан хэлэлцүүлгийг удирдаж байгаа чинь үнэхээр бас лав л энд бид нар хэдийгээр Ерөнхий сайдыг огцрох ёстой гэсэн байр суурьтай байсан ч гэсэн наадах чинь зарчмын хувьд, ёс суртахууны хувьд үнэхээр зохисгүй харагдаж байна таны хувьд. Үнэхээр зохисгүй харагдаж байна энэ. Энэ нь бид нарын 7 хоногийн өмнө гаргасан санал үндэслэл бүхий байсныг бас харуулж байна гэж үзэж байна.

Тийм учраас эрхэм гишүүдэд би бас яг бид нарын энэ Ардчилсан намын бүлгээс гаргасан горимын саналыг та бүхэн дэмжиж өгөөч. Бүгдээрээ энд санал хураагаад өнөөдрийн хуралдааныг танай маргалдаж байгаа, олонхын маргалдаж байгаа хоёр талын нэг талд нь 100 хувь гарчихсан байгаа нэг хүн ингэж хэтийдсэн байдлаар нэг талыг барьж шийдэх биш, цөөнхийн бүлгийн төлөөлөл, цөөнхөөс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргаар энэ асуудлыг удирдуулах боломжийг олгож өгөөч. Энэ асуудлаар санал хураалгаж өгөөч.

Х.Булгантуяа: 1 номерын микрофон Баасандорж дарга тийм албан бичиг ирсэн юм уу? Энэ нь тийм горимын саналаар хурал даргалагчийг томилдоггүй шүү дээ та бүхэн мэдэж байгаа. Та дэд даргаар та өмнө нь бас ажиллаж байсан сайн мэдэж байгаа. 1 номер Баасандорж дарга.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс, таны би ирсэн бичгийг танилцуулах гэж байна шүү дээ. Үгүй би танаас, Ардчилсан намын бүлгээс ирсэн бичгийг танилцуулах гэж байна шүү дээ шаардлагыг.

Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 2025 оны 10 дугаар сарын 13-ны огноотой. Гэхдээ манай бичиг хэрэг дээр 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүлээлгэж өгсөн Шаардлага хүргүүлэх тухай гэдэг бичиг ирсэн. Яг энэ шаардлага дээр бол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдааныг Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдоржоор удирдуулахыг шаардаж байна гэсэн. Энэ бол гишүүд ээ шаардлага.

Горимын санал гэж юу вэ гэхээр би та бүхэндээ Дэгийн хуулийн горимын саналыг уншиж өгье. Горимын санал гэж 4.1.3 дээр горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гарсан горимын саналыг хэлнэ гээд.

Тэгээд яг энд хуралдаан даргалахтай холбоотой Ардчилсан намын бүлгийн дэд дарга, Тэмүүжин дэд дарга хэвлэл мэдээллээр маш тодорхой зарчмын байр суурь илэрхийлсэн. Үүнтэй би Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд санал нэг байгаа. Энэ санал дээр бол энэ Ерөнхий сайдын асуудал болон Улсын Их Хурлын даргын асуудлыг ашиг сонирхлын зөрчилгүй буюу аль ч талд нь гарын үсэг зураагүй хүн энэ хурлыг дарлах ёстой гэж хэлсэн. Тэгэхээр чуулганы нэгдсэн хуралдаан өөрөө ямар нэгэн маргаангүй, ямар нэгэн эргэлзээгүй явах ёстой. Тэр үүднээсээ Пүрэвдорж дэд дарга бол Улсын Их Хурлын даргыг огцруулах дээр гарын үсэг зурсан. Өнөөдөр бол Булгантуяа дэд дарга бол аль ч талд нь гарын үсэг зураагүй. Тэмүүжин бүлгийн дэд даргын хэлснээр бол ямар нэгэн ашиг сонирхолгүй, зөрчилгүй гэж үзэж байна.

Х.Булгантуяа: Тамгын газраас сая горимын саналын тухай танилцууллаа. Ингээд үргэлжлүүлээд Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин.

Б.Түвшин: Өнөөдөр та бүхэн маань ингээд Монголынхоо төрөөр бас нэлээн их оролдож байх шиг байна. Өчигдөр Ардчилсан намын бүлэг үдээс хойш, орой тийшээгээ шийдвэр гаргаад бүлгээрээ орж ирж байгаа асуудлыг хоёуланг нь бол огцруулъя гэдэг ийм шийдвэр гаргасан. Тэгээд орой харанхуй болсон, 6 цагаас хойш ажил тарчихсан учраас энэ ирцийг бүрдүүлэхгүй явсаар байгаад өнөөдөр 10 цагаас явж байна. Ер нь энэ төрөөрөө тоглох хоорондын энэ хагарлаа Монгол Ардын нам жоохон бодооч ээ. Дараагийн төрөө яаж байгуулах юм? Ер нь энэ гадаад, дотоод орчин, геополитикийн орчин эвгүй, эдийн засгийн ийм тогтворгүй үед энэ төрөөрөө ингэж тоглож болж байгаа юм уу? Үнэхээр манай Монгол төр өөрөө тогтвортой байж байж явна шүү дээ. Бид нарыг чинь Монгол Ардын Монгол, Ардчилсан намын Монгол гэж байхгүй шүү дээ.

Тэгэхлээр энэ төрийг тогтвортой байлгах талаар та нар цааш цаашдаа бодоорой. Өнөөдөр Ардын намын даргын төлөөх уралдаан өнөөдөр Монгол төрийн хямрал болоод магадгүй Үндсэн хуулийн ч маргалдаан болж мэдэхээр ийм хүнд байдал руу орж байна. Эндээс ард түмэнд нэг л юм хожиж байгаа. Хэн, хаанаас юу хийж байна, хаана их мөнгө байна, хулгай зэлгий хаагуур хийгдэж байна гэж. Энэ дээр дараагийн хэн ч болсон байсан Засагт нэг даалгавар өгөх хэрэгтэй. Та нар энийг бас томъёолоод оруулж өгөөрэй. Үнэхээр бид нар Монгол Улсын төсвийг ярьж байгаа. Бид нарын яриад байгаа мөнгө бол ерөөсөө энэ төрийн хэрэглэгдэж байгаа нийт мөнгөний ердөө л гуравны нэг нь юм байна. Үүнээс хэд дахин их мөнгө ТӨК-удын дээгүүр явж байна. Тэр нь дандаа буруу замаар явж байна. Ерөөсөө энэ ТӨК-удын мөнгийг л идэж уудаг энэ тогтолцоо руу

цаашаа явчихсан юм байна. Тийм учраас ТӨК-удын хувьцаа эзэмшигчийг Улсын Их Хуралд шилжүүлэх ёстой. ТӨК-ийн үндсэн үйл ажиллагаанаас бусад компаниудын бусад зардлуудыг олон нийтэд ил болгодог байхгүй бол энэ хулгай тасрахгүй юм байна. Энэ бол төсвийн нэгэн бүрэлдэхүүн байх ёстой юм байна гэдгийг бас хэлье.

Дээрээс нь энэ Монгол төрөөрөө цаашдаа та нар бага тоглоорой. Монголын ийн төр мөнгөнд орших ёстой. Ер нь бол энэ засаг барьж байгаа 68 хүнд Монголын ард түмэн итгэж та нарыг Монгол Улсаа хөгжүүлнэ гэж найдаж явж байгаа шүү. Ардчилсан нам бол өөрийн үүрэг хариуцлагаа нэр төртэйгөөр биелүүлээд явж байгаа. Өчигдөр Үндсэн хуулийн маргаантай байж магадгүй асуудал дээрээс ингээд шөнө орой болсон хойно засгаа унагааж, унагаахгүй ер нь бол нь энэ засгийн хэрүүлд оролцохгүй өглөө цагтаа эхэлье гэсэн гишүүдийг Их Хурлын даргын индэр ашиглаад их харлуулсан шүү Булгантуяа гишүүн. Энэ дээрээ бас уучлалт хүсэх ёстой гэж ингэж бодож байна. Энэ бүгд гишүүд их ажлаа хийгээд өөр өөрийнхөө эрх мэдэл, үүрэг, хариуцлагын хүрээнд энэ хуралдаа оролцоод явж байгаа шүү. Тийм учраас Монгол Ардын намынхан минь ээ бага хулгай хийгээч, төрөө тогтвортой байлгаач, ард түмнээ бодооч гэдгийг та бүхэндээ хандаж хэлэх гэсэн юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан асуултад хариулъя. Үг хэлчихсэн үү Түвшин гишүүн? Үг хэлчихлээ.

Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан.

Д.Жаргалсайхан: Миний минутыг эхнээс нь явуулаад өгчих өө. Сая ерөөсөө үг хэлүүлсэнгүй.

Х.Булгантуяа: Жаргалсайхан гишүүний микрофоныг эхнээс нь өгье.

Д.Жаргалсайхан: Манай эрх баригч нар маань хэд хоног сайхан хулгайгаа ярилаа. 9 жил яаж төрийг барьсан, ямар хулгай гарсан, хэн нь яаж идэж уусан бэ гэдгээ бол нэлээн ярьсан. Ингээд би энэ Б.Энхбаяр гишүүнээс асуух гэсэн юм. Одоо энэ Засгийн газар ингээд огцорлоо гээд энэ асуудал ингээд дуусах ёстой юу? Энэний араас яаж тэмцэх ёстой юм? Тэгээд энэ Амарбаясгалан энэ Их Хурлын дарга өргөдлөө өгөөд огцорлоо гээд энэ асуудал зогсох ёстой юу? Энийг яаж мухарлах ёстой вэ гэдгийг Б.Энхбаяр гишүүнээс асуумаар байна.

Мөн дээрээс нь ард иргэдийн амьдрал ахуй маш их хүнд байдалтай байна аа. Гадаа багш нар маань, эмч нар маань, тэтгэврийн хөгшид маань цалин хөлсөө нэмүүлэх гэж, амьдрал ахуйгаа сайжруулах гэж, өлмөн зэлмэн амьдралаасаа гарах гэж тэмцэж байна. Тэгэхэд үнэхээр энэ ард түмний итгэлийг авсан энэ эрх баригч нам маань өнөөдөр ингээд суудлын хэрүүл, хүн засаглах уу, хууль засаглах уу, хулгайч засаглах уу гэдэг юм ингээд яриад сууж байна аа. Энэ дээр яг ямар шийдэл, гарц байна вэ? Энийг бол би Ардын нам ингээд 2 бүлгийн даргатай болчихсон байгаа. Тэгээд аль бүлгийн даргаас нь асуух юм, эс үгүй бол энэ чинь Засгийн газар огцорчихсон. Хаанаас нь асуух юм? Ийм л эргэлзээтэй байдалд орчихлоо л доо. Бид нар хүртэл эргэлзээтэй байдалд орчихлоо. Хулгайтай тэмцье гээд гараад ирсэн Засгийн газраа унагаагаад авлаа. Тэгэхээр энэ хулгайтай ер нь яаж тэмцсэн юм гэсэн ийм асуултуудыг асуумаар байна.

Өнөөдөр энэ эдийн засгийн ийм эгзэгтэй яг ийм хүнд, энэ төсвөө баталж чадахгүй ийм үед та бүхэн маань энэ эдийн засаг, энэ төсөв мөнгө энэ 15-нд хугацаа дуусах гэж байна шүү дээ. Энэ энэ зүйл дээр ямар төлөвлөгөө, гарц гаргалгаа байгаа юм бэ? Үнэхээр чадахгүй бол энэ Ардчилсан нам сүүдрийн Засгийн газар байгуулаад явах юм уу Учрал сайд аа тээ? Ийм юмыг та хэд юу гэж бодож байна? Ардчилсан намаасаа дэмжлэг авах юм уу эс үгүй бол? Эх баригч нам маань үнэхээр төр засгаа удирдаж чадахгүй ийм суудлын хэрүүлтэй болчихсон байгаа бол Ардчилсан намаас та бүхэнд дэмжлэг үзүүлэх бас өмнө нь сайн ажиллаж байсан сайд нар байгаа шүү. Энэ тал дээр ямар бодолтой байна Учрал сайд аа? Ингээд саяын манай энэ Пүрэвдорж гишүүн бас ингээд маргаан үүсгээд байна. Энэ огцрох асуудал яригдаагүй шүү. Огцрох асуудал дээр Ардчилсан намын гишүүд гарын үсэг зурсан. Энэ бол өөрөө өргөдөлгүй өгсөн асуудал яригдаж байгаа шүү.

Тийм учраас Пүрэвдорж гишүүн дээр ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй. Яагаад энийг ингээд 2 талаар тайлбарлаад байгаа юм, өөртөө ашигтай байдлаар яагаад тайлбарлаад байгаа юм? Энэ дээр хариулт өгөөч. Хэн өгөх юм? Булгантуяа бол өгч чадахгүй өөрөө энэ чинь ашиг сонирхлын зөрчилтэй. Тийм учраас Учрал сайд энд хариулт өгөөч. Тэгээд хэн хариулт өгөх юм бэ? Энэ дээр ингэе Пүрэвдорж гишүүн хариулт өгөөч, манай Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж оо, Пүрэвдорж оо чи хариулт өгөөдхөөч энэ чинь эрх баригч нар хариулт өгөхгүй гээд байна шүү дээ. Б.Энхбаяр гишүүнээс хариулт авъя, Учрал сайдаас хариулт авъя. Өөр хариулчих хүн байна уу? Ардын намд хариулах хүн байхгүй бол манай энэ Пүрэвдорж гишүүн хариулт өгье.

Х.Булгантуяа: Жаргалсайхан гишүүнээ Дэгийн тухай хуулиараа ийм юм байна Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эс үгүй бол өргөдөл гаргасан, хэлэлцсэн Байнгын хорооны дарга, эс үгүй бол өргөдөл гаргасан хүн л үүнд хариулт өгөх ёстой. Тэрнээс өөр хүмүүс бол хариулт өгөх эрх байхгүй юм байна. Амарбаясгалан дарга. Амарбаясгалан даргын микрофоныг өгье.

Д.Амарбаясгалан: Яах вэ Пүүжээ дарга удирдаад явахад болохгүй зүйл байхгүй шүү дээ. Энэ дээр тэгээд айхтар улс төр болгох гээд байх юу байх вэ. Гол нь яах вэ хэдүүлээ хэлэлцэж байгаа асуудал дээрээ төвлөрөх нь зөв байх гэж бодож байна. Сая Булгаа дарга бас хэлж байна нэгдүгээрт би өргөдөл гаргасан хүний хувьд бол өргөдөл гаргагчийн хувьд хариултуудаа өгөөд явах нь зарчмын хувьд миний үүрэг болох байх. Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцсэн. Яах вэ би бас хүсэлт гаргаад асуулт, саналаа чуулган дээр шууд хэлэлцээд явъя аа гээд шууд наашаа ороод ирчихсэн учраас бас Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга айхтар хариулах боломж байхгүй болов уу гэж бодож байна. Тэгэхээр миний хувьд асуултуудад хариулаад явна аа гэдгийг бас хэлье.

Тэгээд Пүүжээ дарга удирдаад явахад болохгүй зүйл байхгүй байх. Улсын Их Хурлын даргын хувьд бол хурал даргалах хүний асуудлыг дарга өөрөө үүрэг, чиглэл өгөөд шийдээд явдаг. Ардчилсан намаас тавьсан шаардлагатай холбогдуулаад би бол Улсын Их Хурлын даргын захирамж гараад 16, 17 оны чуулганы хуралдааныг Булгантуяа дарга удирдана аа гээд гаргачихсан, шийдчихсэн байгаа юм. Гэхдээ одоо зайлшгүй шаардлагатай гэж бодож байгаа

бол Пүрэвдорж гишүүн удирдаад явахад болохгүй зүйл байхгүй байх аа гэж бодож байна.

Х.Булгантуяа: Пүрэвдорж гишүүндээ микрофоныг шилжүүлье. Би бол заавал энэ хэцүү хуралдааныг даргалах гээд байгаа юм байхгүй шүү дээ Пүрэвдорж гишүүн ээ.

Б.Пүрэвдорж: Монголын ард түмнийхээ энэ өдрийн мэндийг айлтгая. Тэгэхээр өнөөдөр Монгол Ардын нам 2024 оны сонгуулиар олонхын саналыг авч төрийн эрхийг хэрэгжүүлж байгаа. Тийм учраас энэ бол энэ даргын суудал бол Монгол Ардын хэн нэгэн албан тушаалтан заавал суух ёстой ийм суудал. Түр зуур энэ хурлыг хэтэрхий хоёр талдаа гарчихсан байгаа Монгол Ардын намынхныг эвлэрдүүлэх тэр хооронд энэ хурлыг удирдах ийм зорилгоор энд сууж байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр та бүхэн эвтэй болонгуутаа энэ суудлаас нь буугаад та бүхэн энэ хурлаа удирдаж болно.

Ер нь бол Монгол төр бол, энэ бол парламентын засаглалтай орны хамгийн том албан тушаалын суудал. Тийм учраас энэ суудал дээрээс аливаа нэг талд гарсан тийм шийдвэрийг ярих, аль эсвэл хэн нэгний кнопыг таслах, аль эсвэл хэн нэгний үг хэлэх тэр эрх чөлөөнд нь халдах ийм зүйл ерөөсөө байж болохгүй юм. Хэрвээ янз бүрийн асуудалтай зүйл ярихаар бол би тэр доор өөрийнхөө суудал дээрээсээ ярина. Эндээс бол ямарваа нэгэн тийм төрийн нэр хүнд халдсан аливаа нэгэн зүйлийг хийх ёсгүй гэж би үздэг. Тийм учраас энэ хурлыг зөв удирдаад энэ Монгол төрийн нэр хүндийг буцааж авчрахын тулд энэ суудал дээр сууж байгаа гэдгийг хэлье. Тэгээд та бүхэн маш хурдан эв нэгдлээ олоод энэ хурал дээрээ удирдахыг бас хүсье.

Ингээд дараагийн хүн. Хэнээс авах вэ? Энэ Дэгийн тухай хуулиар бол би дэг сахиулна. Тийм учраас ер нь бол яг энэ өргөдөл гаргасан хүн л хариулах үүрэгтэй. Байнгын хорооны дарга бас хариулж болно. Хэн нэгэн хүнээс асуух боломж байхгүй. Бас та нарыг намайг энд гаргалаа гээд бас хууль зөрчинө гэсэн бас үг биш шүү дээ.

Д.Ганбат гишүүн. Тодруулъя, Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Тэгвэл Амарбаясгалан даргаас асууя. Ингээд та асуудалд холбогдсон. Тийм учраас өөрөө өргөдлөө өгч байгаа. Мөн 67 гишүүн таныг огцруулах гарын үсэг зурсан. Тийм учраас энэ асуудлаа ямар хүрээнд яаж шалгуулах вэ? Өнөөдөр огцорлоо буюу эс үгүй бол өргөдлөө өглөө гээд энэ асуудлыг зогсоох ёстой юу? Ямар хэмжээнд шалгуулж энэ нэр төрөө сэргээлгэх ёстой юм бэ? Энэ асуудал.

Дараагийн асуудал нь юу вэ гэхээр танайх ингээд 32 юм уу, 35 ч юм уу ингээд 2 бүлэгтэй болчихсон байна. Ардчилсан нам ингээд 42 хүнтэй гээд олонх нь буюу ингээд бүлэг байгаа юм. Тэгтэл ингээд засаг төрийн ажил, энэ ард түмний ажил бол үнэхээр хүлээгдэхгүй. Ард иргэд маань тэр тусмаа багш, эмч нар, ингээд тэтгэврийн настай хөгшид маань авч байгаа цалин, тэтгэвэр нь амьдралд нь хүрэхгүй өлмөн зөлмөн амьдарч байна, зарим нь хоосон хонож байна аа гээд зовлон яриад байж байна. Энэ асуудал олон хонолоо. Энэ дээр шийдэл, гарц алга аа. Монгол Улсын.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Би ямар нэгэн асуудлаар холбогдож хуулийн байгууллагаар шалгагдаагүй. Аливаа шатын шүүхийн байгууллагаар гэм буруутай гэж тогтоогдоогүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэсэг бүлэг хүмүүсийн хэлж, ярьж байгаагаар намайг асуудалд холбож ярьж байгаа гэдгийг эрхэм Улсын Их Хурлын гишүүд эрхээ биш ойлгож байгаа байх гэж бодож байна.

Ер нь Монгол Улсын энэ парламентын засаглал, парламентын тогтолцоо энэ мэт нэр төрд бүдүүлгээр халдаж, эргүүлээд гэмт хэрэгтэн мэтээр яллаж, араас нь шүүхийн тогтоол унших гэж явдаг энэ байдлаас бид салах цаг ирсэн гэдгийг хэн хүнгүй ойлгох ёстой. Алтанхуяг гишүүн саяхан бас Байнгын хорооны хурал дээр хэлж байсан. Маш олон жил энэ хонгилоор чирүүлж байгаад би гарч ирлээ гэж. Үнэн. Өнөөдөр хүртэл амьд оршин тогтнож байгаа энэ хонгилыг устгахын төлөө бид ажиллаж байх ёстой. Би Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болж очсоноосоо хойш өөрөө ч мэдэлгүй байж байгаад өч төчнөөн өмч хөрөнгө, өч төчнөөн орд газартай нэр холбогдож эхэлсэн. Би өөрөө мэддэггүй. Намайг хүмүүс холбодог.

Б.Пүрэвдорж: Д.Ганбат гишүүн асууя.

Д.Ганбат: Энэ чинь нөгөө юу билээ хэдэн адасганаас болж хүний аминд хүрэх нь шив дээ гэдэг билүү нэг тиймэрхүү л юм болоод байгаа юм биш үү? Бид нар чинь нүүрсчидтэйгээ хариуцлага ярих энэ тэр юм байхгүй болоод тэрнийхээ оронд энэ гэрээ нураах нь л дээ. Бясаа, жоомоо алах гэж байж. Төрийн байгуулалтын байнгын хорооноос асууя. Танайх чинь юу билээ хуралдаад Ерөнхий сайдыг огцруулахыг дэмжихгүй гэсэн хүмүүс чинь сая дэмжиж байх шив дээ. Энэ чинь юу юм бэ залилан юм уу? Тэрийгээ нэг тодорхой тайлбарлачхаарай.

Би өчигдөр харлаа. Өнөөдөр бол ажлын цагт, 10 цагт нь хүрч ирээд л хуралд нь суулаа. Тэгээд бүлгийнхээ шийдвэрийг дагаад л кнопоо дарлаа. Тэгээд бүтэн нэг өдөр бол тамлалаа шүү дээ та нар бол Монголын ард түмнийг. Шөнө, өдөргүй унтуулахгүй. Ингэж болохгүй шүү дээ ийм бүдүүлэг байж. Би нэр усыг нь хэлээд яах вэ ойлгоорой тэрийгээ. Ахиад ийм юм явмааргүй байна. Тэгэхээр асуудлыг хурдасгахын тулд энэний дараа би бол ардчилалд итгэдэг. Энэ 2 том гүрний дунд Монгол Улс ардчилсан засаглалтай байх ёстой. Энийг би үгүй болгочихгүйн тулд энэний төлөө л явж байна. Энэ парламентын засаглал, хувийн өмч, шударга шүүх, компани, чөлөөт зах зээл энэ юмыг алга болгочихгүйн тулд л бид нар хичээж байна.

Тэгээд Их Хурлын даргаас асууя. Би бол таныг огцруулах 63-д нь ч байна уу тэнд нь зурсан. Нөгөө хэн нь ч билээ даанч та удав аа гэдэг шиг яасан их удаж байна аа. Би таныг өөрөө эртхэн гарч ирээд бас энэ юм хумаа яачих юм болов уу гэсэн чинь тэгээд заавал тэрэндээ хүрч байж ингэх шаардлага байсан юм уу? Тэрийг та хэлээд тайлбарлаад өгөхийг бодоорой. Яагаад ийм болчхов гэдгийг чинь бас сонирхож байна. Би таныг бол эхлээд л дөнгөж хэл аманд оронгуут л гарч ирээд л би энийг түдгэлзээд өгчихье. Ардчилсан намын шаардлага бол эхлээд тэр Энхтүвшин гишүүнийхтэй нэгдэхдээ бол Их Хурлын даргыг огцруулъя гээгүй шүү дээ. Түдгэлзье гэсэн. Тэгээд хүлээгээд л байсан, хүлээгээд л байсан. Байхгүй.

Өчигдөр ч гэсэн энэ 2 шийдвэрээ ахиж баталгаажуулахдаа би тэр 34 гишүүний арай шийдвэр чинь зөв өө гэхдээ цаг нь болоогүй байна аа гэсэн. Тэгж санал гаргасан нэг гишүүний нэг нь би. Тэгээд хараад байхад бол ерөөсөө энэ улс орныг дуусгах нь л дээ. 35 жилийн өмнө бид нарын сонгосон одоо хүртэл явж байгаа энэ зам бол хэдхэн өдрийн дотор байхгүй болох гэж байна шүү дээ. Ингэж бид нар болохгүй л дээ. Бид нар энэ танхим дотор асуудлаа шийдээд, дараагийн тэр Үндсэн хуулийн субъектүүд нь ажиллах хэрэгтэй байна. Монгол Улсын Ерөнхийлөгч бол 6 жилд 1 удаа сонгогдож байгаа дээд танхимын.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут өгье.

Д.Ганбат: Тэр хүн мэдээж хэрэг тэр хоригоо тавих байх. Эсвэл тавихгүй юм уу тэр өөрийнхөө үзэмжээр шийдэх асуудал байх. Дараа нь Цэц байгаа. Тэнд бас хэдэн хүн байгаа шүү дээ. Тэр хүмүүс сая Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсгэлээ гээд л ярьж байна. Энэ асуудлуудыг ингээд хурдан түргэн шийдээд явчихмаар байна. Тийм учраас орж ирж байгаа шүү. Та нарыг их харлаа, хүлээлээ. Тэгэхгүй бол гадаа асуудлууд их сунжирсан байна, их хуримтлагдсан байна, та нарын сандал суудлын, ширээний хэрүүл чинь хэтэрсэн байна. Би нэг Ардын намынхан та нарыг тавлаад байх сонирхол алга. Ийм болчхож, тийм болчхож гэж. Танай намын дотоод асуудалд оролцох хүсэл алга. Гэвч танай намын санхүүжилтийг Монголын ард түмэн тэр чигээр нь хийж байгаа шүү дээ. Тэрний нэг нь би. Учир начраа хурдхан шиг ол л доо. Та нар ч гэсэн аятайхан байвал зүгээр байна шүү дээ. Бид нар ч гэсэн аятайхан байя. Тэгээд энэ Монгол улсаа аятайхан шиг хамтдаа аваад явчихмаар байна шүү дээ. Тэгэхгүй бол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Дахиад авах юм уу? Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Ганбат гишүүнд баярлалаа. Би яах вэ гишүүдээсээ нэг зүйлийг бас асуухыг хүсэж байгаа юм. Энэ дотор бас янз янзын асуудалтай нэр холбогдоод л хэвлэлээр гүтгүүлээд л янз янзаар бичүүлдэг гишүүд бас зөндөө л олон байгаа. Тэгээд хэвлэлээр бичүүлсэн гишүүн болгон түдгэлзээд шалгуулах ёстой гэдэг ийм зарчим өнөөдрөөс эхэлж надаар эхэлж байгаа юм болов уу гэж би харж байгаа. Би түрүүнд хэллээ ямар ч хуулийн байгууллагаар шалгуулаагүй, аливаа шатын шүүхийн байгууллагаар гэм буруутай гэдэг нь тогтоогдоогүй. Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрхээ эдэлж байгаа намайг шалгагдаагүй хэрэгтээ буруугүй гэдгээ нотолж ир гэдэг шаардлага тавина гэдэг энэ Ардчилсан Монгол Улсад, XXI зуунд байх ёстой хандлага юм уу гэдгээс би асуултаа эхэлмээр байгаа юм.

Хоёрт нь парламентын засаглалтай улсын энэ парламентын дархлаа гэж нэг чухал зүйл байдаг. Парламентын дархлаа 1 гишүүний бүрэн эрхээс бүрддэг. Гишүүн бүрийн. Гэтэл энэ гишүүдийн бүрэн эрхээр дамжуулж парламентын дархлаанд халдах оролдлогууд магадгүй олон талын оролцоотойгоор хийгдэж байгаа энэ үйлдлүүдийн нэг томоохон жишээ энэ удаагийн хохирогч нь миний бие гэж би өөрөө үзэж байгаа юм. Хэрвээ би ямар нэгэн байдлаар хуулийн байгууллагад шалгагдаад шүүхийн байгууллагаар гэм буруутай нь тогтоогдсон бол би энд өргөдлөө өгөөд, тайлбар хийгээд сууж байх эрх, ёс суртахуун надаа байхгүй. Харамсалтай нь ийм зүйл болсон.

Тэгэхээр одоо яах юм миний дараачаас эхлээд тэр гишүүн тэрэнтэй холбогдсон байна, чи явж түдгэлзэж шалгуул гэдэг ийм зарчим руу парламентыг шилжүүлэх юм уу? Цаашлаад энэ парламент өөрөө дархлаагаа алдаж Монгол Улсын парламентын тогтолцоо, парламентын ардчилал үгүй хийх тэр зам руу бид явах юм уу гэдэг асуултыг би эрхэм гишүүдээсээ би асуухыг хүсэж байгаа юм. Миний хувьд парламентын спикерээр сонгогдсон цагаасаа эхлээд олон намын оролцоотой парламентын төгөлдөршилийг бий болгох, шинээр төлөвших, энэ шинэ тутамд бий болсон тогтолцоо бодитой амь орох, Монголын ард түмний тавьж байгаа тэр олон шаардлагуудыг хангаж чаддаг байх, олон намын оролцоотой болсноороо олон талын хүсэл, сонирхлыг илэрхийлж чаддаг байх гэдэг энэ зарчмууд дээр л төвлөрч ажиллаж байгаа.

Гэхдээ миний хувьд олон гишүүд маань буруу ойлголт авч, гэмт хэрэгт холбогдсон мэтээр ойлгож, түдгэлзэн шалгуул гэдэг шаардлагыг тавьсан учраас миний хувьд ёс суртахууны хувьд санаачилга гаргаж, өргөдлөө өгье. Надаар дамжуулж парламентын засаглалд аюул учрах нөхцөлийг бүрдүүлэхгүй байя гэдэг ийм санаачилгын үндсэн дээр би өнөөдөр өргөдлөө өгөөд Улсын Их Хурлын даргын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан байгаа.

Б.Пүрэвдорж: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Ер нь өндөр албан тушаалтан ямар нэгэн хэл аманд орвол тэгээд шалгуулдаг байх л ёстой л доо. Хууль хяналтын байгууллагадаа бид нар итгэж байгаа байх. Шударга шүүхдээ итгэж байгаа байх. Энэ бүх хуулийг тогтоох энэ зүйлийг бид нар л хийж байгаа шүү дээ. Тэгээд иргэдээ болохоор очиж шалгуул гэдэг өөрсдөө болохоор тэгдэггүй. Ийм байж болохгүй ээ. Ардчилсан улс оронд байдаг энэ юм руугаа л бид нар явна. Өөрсдөө эхлээд шалгуулчихдаг байх хэрэгтэй. Тэрний ёс суртахууны хэмжээгээр тодорхойлогдоно. Бас ахиад тодруулъя. Та би ингээд огцорно, би эсвэл ингээд шалгуулна гээд ингэж хэллээ. Тэрнийхээ дагуу бас Засгийн газар унах ёстой гэж хэллээ. Занданшатар огцрох ёстой гэж, Ерөнхий сайд. Яагаад тэгж эхлэх болов? Ямар учир шалтгаан байна? Барьцаж байгаа юм уу. Эсвэл энэ Засгийн газар буруу ажил хийсэн юм уу. Энийг та нэг тайлбарлаад өгөөч надад.

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Хүлцэл өчье. Одоо чуулганы танхимд бас намын асуудал яриад байх төдийлөн зохимжтой биш байдаг. Бидний маргаан өнөөдрийг хүртэл намын даргын сонгуульд нэр дэвшсэнээс үүдэлтэйгээр энэ хүртэл явж ирсэн. Тийм учраас миний хувьд өчигдөр улс төрийнхөө байр суурийг илэрхийлж, мэдэгдэл хийхдээ энэ маргааны нэг хэсэг болсон хоёр хүн хоёулаа огцроод, өнөөдөр энэ төрийн ажлыг тогтвортой хэвийн явах нөхцөлийг нь хангаж өгье. Төр биднээр дутахгүй ээ. Бид харин өөрсдөө асуудлаа нам дотроо шийдэх ёстой юм гэсэн ийм байр суурины үүднээс мэдэгдэл хийсэн юм.

Б.Пүрэвдорж: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандаг-Очир хариулъя.

Ц.Сандаг-Очир: Манай Байнгын хороо энд сууж байгаа 126 хүн Улсын Их Хурал дээр хэлэлцэж байгаа, Байнгын хороо дээр хэлэлцэж байгаа аливаа

асуудалд өөрийнхөө итгэл үнэмшлээр, өөрийнхөө байр суурь, үгээ хэлж, санал хураалтад өөрийнхөө итгэл үнэмшлээр саналаа өгөх эрх нь халдашгүй байдлаар хамгаалагдсан байгаа. Байнгын хороо дээр саналаа яаж өгснөөс нь хамаараад чи яагаад тэгж өгөхгүй байсан юм гэж ингэж хэн ч хэнээс ч асуух эрх байхгүй. Энэ бол гагцхүү парламентын гишүүний өөрийнхөө, ард түмнээсээ авсан мандатынхаа хүрээнд асуудалд итгэл үнэмшлээрээ саналаа өгч байгаа асуудал. Одоо таны байдлаар бол асууж байгаа асуулт нь заавал дарах ёстой байсан юм уу, үгүй юу гэж. Тийм учраас энэ гишүүдээс яагаад чи тэгж саналаа өгөөгүй юм гэдэг энэ асуудал өөрөө байж болохгүй асуудал гэж нэгт. Тийм учраас энэ бол Байнгын хороо гишүүд асуудалд өөрсдийнхөө итгэл үнэмшлээр л асуудалд хандсан шүү.

Б.Пүрэвдорж: Чинбатын Ундррам гишүүн асуулт асууя.

Ч.Ундрам: Өнгөрсөн хэд хоног Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль ноцтой зөрчигдсөн ийм үйл явдлууд гарсан гэж би үзэж байна. Тэгээд энэ хуулиудыг өөрт ашигтайгаар тайлбарлаад, яг 2 хүний асуудал дээр өөр өөрөөр хандаж байгаа ийм дабл стандартын байдалтай. Дабл стандарт үйлчилж байгаа байхгүй юу. Одоо нэг жишээ гэхэд ажлын цаг, нэг хүн дээр нь болохоор ажлын цаг боллоо гээд яг тухайн үедээ хэрэгтэй. Нөгөө өдөр нь болохоор ажлын цаггүй болчихдог. Асуулт, хариулт нь ч гэсэн нэг хүн дээр нь болохоор бөөнөөрөө дайрч асуулт асуучхаад, нөгөөдөх дээр нь болохоор асуулт асуухгүй, үгийг нь хүртэл тасалдаг. Энэ Улсын Их Хурлын даргын, спикерийн суудал бол дэгийг бариулах, аль аль намын гишүүдэд адил, тэгш хандах ийм суудал болохоос биш хуулийг өөрт ашигтайгаар ашиглаад, нэгтэй нь болохоор арай өөр харьцаад, нөгөөдөхөд нь бол арай зөөлөн харьцдаг ийм дабл стандарт бий болгодог суудал биш ээ. Тэгээд хурал ирц хүрээгүй байхад хурал эхлээгүй байдаг. Эхлээгүй хурлыг даргалаад өдөржин Улсын Их Хурлын гишүүдийн нэр төрд халдаад, доромжлоод, шантаачлаад бараг ингээд суудаг ийм суудал биш ээ. Тэгээд энэ бүгдийг бас гаргасанд маш их харамсалтай байна.

Амарбаясгалан даргын хувьд асуулт байна. Энэ хэвлэлд, гадаадын хэвлэлд гарсан мэдээтэй холбоотой тагнуулын шинжээчийн дүгнэлт гарсан гээд та тайлбар хэлж байсан. Энэ тагнуулын дүгнэлт нь яг ямар дүгнэлт юм бэ? Энийг ерөөсөө хараагүй болохоор яг энэ асуудлыг бас бид нар нэлээн сайн ойлгож ухах ёстой. Тэгж байж итгэл үнэмшлээрээ санал өгнө. Тэгэхээр энийг хаалттай хэлбэрээр ч юм уу та гишүүдэд танилцуулах ийм боломж байгаа юу? Эсвэл нээлттэй микрофон дээр хэлчих ийм боломж байгаа юу? Ер нь энэ тантай холбоотой нүүрсний сонсгол Бор тээг гээд энэ бол гишүүдийн дунд маш их эргэлзээ төрүүлж байгаа. Энэ бол үнэн шүү дээ. Тэгэхээр яг ийм баримттай, нотолгоотой тэр тагнуулын дүгнэлт бол маш чухал гэж би бодсон. Таны өгсөн мэдээллүүдээс. Тэрийгээ бид нарт харуулаад, тайлбарлаад өгчихвөл санал өгөхөд бид нар бас итгэл үнэмшилтэйгээр өгөх боломж бүрдэнэ гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: 2 зүйл дээр тодорхой хариулт өгье.

Нэгдүгээрт Тагнуулын ерөнхий газрын 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн шинжээчийн дүгнэлт энд байна. Би энийг Улсын Их Хурлын гишүүдэд нэг бүрчлэн гүтгэлэгтэй холбоотой баримт материалуудыг хэвлэмэл байдлаар өрөөнд

нь хүргүүлж өгсөн байгаа. Энэ дүгнэлтийн хамгийн сүүлд шинжилгээгээр илэрсэн дээрх сайтууд төлбөр төлсөн тохиолдолд ямар ч хүн мэдээлэл нийтлүүлж болдог ба мэдээллийн үнэн зөвийг шалгахгүйгээр мэдээ нийтэлдэг сайтууд байна. Дээрх сайтуудын нууцлалын бодлогод мэдээллийн үнэн, зөвийг тухайн веб сайт хариуцахгүй гэх агуулгатай зүйлс бичигдсэн байгаа нь хэн дуртай нь бусдыг гүтгэсэн худал мэдээлэл нийтлүүлэх боломжтой юм.

Мөн дийлэнх сайтууд нь интернэт орчинд бэлэн байдаг веб сайтын загвар ашиглан хийсэн хуурамч байх магадлалтай веб сайтууд байх тул хэн, хэзээ, хаанаас, ямар IP хаягаас, ямар төхөөрөмж ашиглан нийтэлсэн талаарх мэдээллийг тогтооход хүндрэлтэй гэсэн ийм дүгнэлт гарч ирж байгаа юм. Тагнуулын ерөнхий газраас гарч ирсэн мэдээлэл. Энэ бол би өмнө нь бас Төрийн байгуулалтын байнгын хороо дээр хэлж байсан. Ньюс дайрект /news direct/ гэдэг мэдээллийн гүүр дамжуулалт хийдэг тийм байгууллага руу үндсэндээ төлбөр төлөөд, төлсөн төлбөрийнх нь хэмжээгээр хэчнээн ийм төрлийн сайтад түгээх вэ гэдэг асуудлыг шийдвэрлээд түгээчихдэг. Төлбөртэй мэдээлэл. Монголоос 50 гаруй мянган долларыг төлж, энэ мэдээллийг бол түгээлгэсэн нь үндсэндээ тогтоогдчихсон. Үүний араас маш олон хэлбэрээр манай хуулийн зөвлөхүүд албан мэйл бичиж, харилцаж, мэдээлэл үнэн, зөвийг нягтлах тал дээр бол асуудлуудыг ярьж байсан. Нэгнээс нь ч үнэн, зөвийг нь нягтлах, батлах хариу ирээгүй. Бид хуурамч мэдээлэл нийтэлсэндээ хүлцэл өчье гэдэг байдлаар мэдээллүүдээ устгасан гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Хоёрт нь саяхан бас хэрүүл бужигнааны дундуур Sonin.mn сайт дээр 1 гадаадын сэтгүүлч гэсэн нэртэй нийтлэл гарсан. Тухайн нийтлэлтэй холбоотойгоор та бүхэн Chat GPT-ээр ороод үзэхэд тухайн нийтлэл дээр дурдагдаж байгаа сэтгүүлчийн нэр, хаягийг оруулахад шал өөр зурагтай хүн гарч ирж байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бол бас энэ Sonin.mn дээр гарсан нийтлэлийн мэдээнд ашигласан хүний зураг, нэр бүх зүйл ашиглагдаагүй. Ахиад мэдээний агуулга дотор зөрүүтэй мэдээллүүдийг бичсэн. Миний хувьд тэр зөрүүтэй мэдээллийг хэн, яаж санаачилж, зохиож бичсэн бэ гэдгийг үндсэндээ бас гадарлаж байгаа гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Хоёрт нь Ундрам гишүүн маань Улсын Их Хурлын даргын асуудлыг гэхээс илүү Улсын Их Хурлын даргын суудлын асуудлыг ярих шиг боллоо сая. Улсын Их Хурлын дарга парламентад суудалтай намууд, парламентын гишүүдэд ижил, тэгш хандаж байх ёстой гэдэгтэй зарчмын хувьд байр суурь нэг. Миний хувьд ч гэсэн Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхдаа энэ зарчмыг байнга баримталж ажиллаж ирсэн гэдгийг би бас түрүүн үгэндээ хэлсэн байгаа.

Гуравт нь би энэ амьдралдаа 1 хүрз нүүрс зарж борлуулж, тээвэрлэж явсангүй ээ гэдгийг бас Ундрам гишүүндээ хариуцлагатайгаар хэлье.

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Би нэг үг хэлье. Хүний эрхийг дээдэлсэн 126 гишүүнтэй ардчилсан парламентын хамгийн анхны даргаар ажиллах боломж бол танд өөрт чинь сая оногдсон байна. Өнгөрсөн хугацаанд болсон үйл явдлыг харахаар 126

гишүүнтэй адилхан 1 гишүүн мөртөө хурал зохион байгуулах, ялангуяа Улсын Их Хурлын гишүүдэд бол Улсын Их Хурлын Тамгын газар адилхан эрх тэгш үйлчлэх ёстой. Байнгын хороод мөн адилхан. Бүлгийн ажлын алба. Гэтэл Улсын Их Хурлын бүтцийн байгууллагууд болох эдгээр байгууллагууд Тамгын газар, Байнгын хороод, бүлгийн ажлын алба Улсын Их Хурлын гишүүдэд хурал зохион байгуулах боломжийг бий болгож өгөхгүй гээд маш олон ийм бойкотууд хийлээ. Өөрөөр хэлбэл зөвхөн Улсын Их Хурлын даргад хувь хүнд нь үйлчилдэг ийм бүтцийн байгууллага байж болохгүй гэж үзсэн учраас өөрийг чинь огцруулах албан бичигт би гарын үсэг зурсан. Тэгэхээр өнөөдөр бас өөрөө саналаараа Улсын Их Хурлын даргаас чөлөөлөгдөж байгаа нь бол зөв байна гэж харж байгаа. Цаашдаа бол энэ асуудал дээр бас анхаарах ёстой байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Би үг хэлье. Ардчилал өндөр хөгжсөн орнуудад бас яг энэ төрийн өндөр албан хаагчдын хувьд бол ёс зүйн өндөрлөг бас нэлээн чухал шаардлага болдог. Тэгэхээр Амарбаясгалан даргын хувьд бол бас энэ үүсээд байгаа асуудалтай холбогдуулаад миний нэр дээр гишүүд бас ёс зүйн шаардлага хүргүүлсэн байгаа. Тэгээд энэ дээр бол үндэсний эв нэгдлийг хангах, төрийн үйл ажиллагааны тасралтгүй үйл ажиллагаа явуулах, төрөө дээдлэх, ард түмний итгэлийг бэхжүүлэх, хамгаалах гэдэг үүднээс ёс зүйн шаардлагыг хүргүүлсэн.

Тэгэхээр Амарбаясгалан даргын хувьд бол бас яг энэ жишгийг тогтоож, өөрөө бас өөрийнхөө хүслээр Улсын Их Хурлын даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргаж байгаа нь бас олон төрийн өндөр албан тушаалтнуудад жишиг болж байгаа гэж бодож байна. Тэгээд энэ жишгийг бусад төрийн өндөр албан хаагч нар бас ер нь ёс зүйн өндөрлөг дээрээ байх ёстой шүү. Ер нь бол ийм шаардлагыг зөвхөн Улсын Их Хурлын гишүүд, намууд биш ард түмний хувьд ч гэсэн бас яг ийм шаардлагууд тавигдаж байгаа. Тэгэхээр энийг цаашид бас төрийн өндөр албан хаагчид бас анхаарна биз гэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Иргэдийн бухимдаж байгаа шалтгаан бол парламентын 126 гишүүнээс маш өндөр ёс зүй шаарддаг. Ёс суртахуун шаарддаг. Яагаад гэвэл ёс зүйтэй байж байж хууль батлах, тэр баталсан хууль нь нийгмийн амьдралд хэм хэмжээ тогтоох, шударга ёсыг сахиулах, иргэдийн амар амгалан, тайван байдал, улс орны хөгжил цэцэглэлтэй шууд холбоотой байдаг. 2 талтай. Харамсалтай нь сүүлийн бараг сарын хугацаанд энэ парламентын гишүүдийн амнаас байж болшгүй үг, гарч болшгүй авир гарч байгаа. Энэ нь харамсалтай юм шиг авч нөгөө талд нь иргэдийн мэдэх эрх нээгдэж, асар олон хулгай, луйвар, мөнгөний мөртэй асуудлууд яригдлаа. Асуудлууд яригдлаа. Барин тавин мэдээ сэлтүүд гарч байна. Хууль, шүүхийн өмнө ганцхан үнэн байх ёстой. 2 буюу түүнээс дээш үнэн байх боломжгүй.

Тэгэхээр өнөөдрийн Ерөнхий сайд огцрох, Их Хурлын дарга огцрох энэ 2 асуудлын дараагаар эдгээр зүйлүүд намжиж болохгүй. Яг хуулийн өмнө эцэслэгдээд шийдэгдэх ёстой. Нэг нь буруутай байгаа, эсвэл нөгөөдөх нь гүтгэсэн л байгаа. Энэ хоёрын л аль нэг шүү дээ. Тэр улс төрийн эрх ашиг хангагдахаар энэ дагаад нам жим болчихдог, эргээд иргэдийг хөөрхий талцуулаад үлддэг, улс

орныхоо төрд итгэх итгэлийг алдуулаад явдаг байж болохгүй ээ. Амарбаясгалан Их Хурлын даргаас хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, Та өөрийгөө ер нь хэр зэрэг ёс зүйтэй хүн гэж боддог юм бэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Та эрх баригч намын Ерөнхий нарийн бичгийн дарга хийж байхдаа өрсөлдөгч намуудаа ялахын тулд ямар нэгэн хууль бус ажиллагаа хар пи ар хийж байсан уу?

Гуравдугаар асуулт. Хөрөнгө орлогын мэдүүлгийг харж байна. Өнөөдөр Монгол Улсын нийт иргэдийн ихэнх нь хадгаламжгүй байгаа. Хадгаламжтай иргэдийн 90 орчим хувь нь 1 саяас доош хадгаламжтай байгаа. Тэгэхээр таны хөрөнгө орлого ямар замаар бүрэлдэн тогтсон бэ гэдэг талаар та тайлбарлаж өгөхгүй юу.

Дараагийн асуулт. Тэр Тагнуулын ерөнхий газраас гаргасан дүгнэлт гэж байгаа. Энэ дээрээ яг та хэрвээ нууц биш бол тодорхой баримттай, эшлэлтэй зүйлийг хэлж өгөхгүй юу. Энэ тэр гадаадын хэвлэлтэй холбоогүй юм биш үү? Холбоотой юм уу? Ер нь зүгээр эндээс бол бид нэг л зүйлийг ойлгох ёстой. Энэ олон жил яригдаад байгаа энэ барин тавин зүйлс чинь үнэн худлаа эсэх дээр ард түмэн үнэлэлтээ өгөх ёстой. Тэгэхээр ямар нэгэн байдлаар ... 1 минут авчихъя.

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут өгье.

С.Эрдэнэболд: Ямар нэгэн байдлаар шүүхээс гэм буруутай нь эцэслэн тогтоогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай гэж хэлж болохгүй. Энэ зарчмыг бол би дэмждэг. Мань мэт ч гэсэн тэр хонгилоор нь явж байсан хэлмэгдэгч, хохирогчдын нэг. Гэхдээ энэ улс төрийн нөхцөл байдлаас үүдээд хуулийг, шударга ёсыг үзэмжээр, субъектив байдлаар тайлбарлах боломжгүй. Гэхдээ ямар ч байсан энэ танхим дотор нэг нь худлаа ярьж байгаа, нэг нь хэлмэгдэж байгаа гэсэн ийм л хоёр логикийн аль нэг нь байх ёстой. Энэ дээр та яг барин тавин биш яг баталгаатай, нотолгоотой, өөрийнхөө байр суурийг илэрхийлэхгүй юу гэж асуумаар байна.

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Мэдээж хүн болгон өөрийгөө ёс зүйтэй, зарчимтай гэж үздэг. Би ч гэсэн өөрийгөө өндөр ёс зүйтэй, өндөр зарчим барьж ажиллаж, амьдрах тийм байдалтай хүн гэдгийг дүгнэж хэлнэ. Ямар нэгэн байдлаар улс төржилтийг өмнөө тавьдаггүй, аливаа асуудал дээр урдуур нь орж гүйдэггүй, аль болох зарчмыг барьж, ёс зүйг эрхэмлэж ажиллаж, амьдрах ийм л зорилгыг агуулж явдаг ийм хүн.

Мэдээж миний хувьд өнөөдөр Ардчилсан намын гишүүдийн дунд бас их олон янзын буруу, зөрүү ойлголтууд байдаг юм шиг байгаа юм. Олон сонгуулийн ард гарсан. Олон сонгууль удирдсан. Сүүлийн үед олон сонгууль удирдаж Ардчилсан намыг ялсан учраас Амарбаясгаланг огцруулах нь зөв юм гэж гарын үсэг зурсан гэдэг асуудал хүртэл ордон дотор их яригдаж байгаа. Би энийг сонссон. Гэхдээ энэ бол миний хийж байсан ажил. Би аливаа түвшинд хаана ч ажиллаж байсан хийж

байгаа ажилдаа илүү үнэнч ажилладаг. Ажлынхаа араас өдөр, шөнөгүй зүтгэх тийм зүтгэлийг гаргаж ажилладаг. Ажиллаж байгаа орчин нөхцөл дээрээ илүү дэвшилтэт үзэл, хандлага, арга барилыг нэвтрүүлэхийг зорьж ажилладаг. Энэ хүрээнд мэдээж сонгуулийн амжилт, ололт гэдэг зүйл дандаа дагаад гараад явж байдаг гэж би дотроо боддог. Нэг барьдаг зарчим бол өрсөлдөгч сул бол би ялна гэдэг зарчмаар ерөөсөө ажиллаж үзээгүй. Харин өрсөлдөгч хүчтэй бол бид илүү хүчтэй байх ёстой гэдэг зарчмаар асуудалд хандаж ирсэн.

Тэр ч утгаараа би Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн даргаар 8 жилийн хугацаанд ажиллахдаа улс төрийн нам бол албан тушаалд хүрэхийн төлөө ашигладаг гүүр, дамжлага биш байх ёстой. Энэ бол мэргэжлийн улс төрийн институт байх ёстой юм гэдэг ийм зарчмаар ажиллаж, Монгол Ардын намын шинэчлэл, өөрчлөлтийг хийхийг зорьж ажиллаж ирсэн. Өнөөдөр харамсалтай нь зарим журмын нөхөд маань намайг огцруулах бичиг дээр гарын үсэг зураад, 3 удаа дараалан ялалтад хүргэсний төлөө зурж байгаа гэж Ардын намынхныг ойлгосон. Ардчилсан намын гишүүдийн заримыг нь 3 удаа ялагдалд хүргэсэн учраас зурж байгаа гэж ингэж ойлгосон байгаа гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Сонгууль бол мэдээж өрсөлдөөн дунд явагдаж байдаг. Гэхдээ саяын Занданшатар даргатай бид хоёрын өрсөлдөж байгаа түвшний ийм Орос технологийн хар пи ар-ын түвшинд бол хүрдэггүй байсан. Энэ чинь ерөөсөө хүн алсан, хулгай хийсэн, ер нь энэ Монгол Улсад бүр цаашлаад ярих юм бол бараг дэлхий дээр алхаж явах эрхгүй мэт болтол нь хүнийг харлуулж, гүтгэж байгаа ийм хар технологийг миний хувьд сонгуульд огт ашиглаж үзээгүй гэдгийг хэлье. Би сонгуулийн тойрог дээр пи ар хийж ажиллаж үзээгүй. Би сонгуулийн төв штабыг удирдлага, менежментээр нь хангаж ажиллаж ирсэн ийм хүн байгаа гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Манай гэр бүлийн бизнес 1999 оноос эхлээд хэвлэлийн компани, барилгын материалын худалдаа, хөдөө аж ахуйн чиглэлээр төдийлөн том биш ч гэсэн өөрсдийгөө болгох хэмжээнд бол ажиллаад ирсэн. Өдгөө 26 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагааг явуулж байна. 300 орчим хүнийг ажлын байраар хангаж, татвар төлж байдаг. Тэгэхээр миний хувьд төрд үндсэндээ 2022 оны 9 дүгээр сарын 02-ны өдрөөс эхэлж Хэрэг эрхлэх газрын даргаар ажилласан. Тэрнээс өмнө зөвхөн улс төрийн намд улс төрийн ажил хийхээс гадна хувийн хэвшлээс, хувийн бизнесээс өөрийнхөө орлого, өөрийнхөө хөрөнгийг бий болгож явсан гэдгийг бас хариуцлагатай хэлье. Эрдэнэболд гишүүн ч гэсэн бас өөрөө санаж байгаа байх. 2006, 2007 оны үед лектор төвийнхөн ном хэвлүүлэхээс өгсүүлээд олон асуудлууд гарч байхад тэр үед би бас хэвлэлийн компанийн захирал гэдэг статустай ажиллаад явж байсан гэдгийг та өөрөө санаж байгаа байх гэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Тодруулгыг би Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаас асууя. Сандаг-Очир дарга аа, нэг ийм юм байгаа юм. Түрүүн уг нь Ганбат гишүүн асуусан юм. Тэгээд тодорхой хариулт хүсээд байгаа юм. Мэдээж иргэд маань бол төрөө хүндэтгэдэг. Тэгэхдээ хэр хэмжээнээс хэтэрсэн хэрүүл уруултай, хэлцэл талцалтай байгаа учраас иргэд бухимдалтай байгааг ойлгож байгаа. Хөхөө өвлийн хүйтэн наашилж байгаа учраас. Гэтэл өчигдрийн тэр Төрийн байгуулалтын

байнгын хорооны тэр цаад өдрийн хурал дээр ч гэдэг юм уу Ерөнхий сайдыг огцруулах санал гаргачхангуутаа Байнгын хороо дээр болохлоор огцруулахын эсрэг дардаг. Тэгээд дэмжихийг дэмжихгүй ч гэдэг юм уу, эсвэл дэмжихгүйг дэмжинэ ч гэдэг юм уу ингээд толгой эргүүлсэн юмнууд яваад байгаа юм. Энэ дээр түрүүн хэллээ шүү дээ Ганбат гишүүн. Залилан хийчхэв үү, юу хийчхэв гээд. Энэ дээр яг тодорхой та байр сууриа хэлээч. Хуульчид бол янз бүрээр л тайлбарлаад байгаа. Наадах чинь орооцолдсон юм болоод байна шүү дээ. Эцсийн эцэст бид нар төр тунгалаг, шийдвэр нь тодорхой байх, логиктой байх ёстой. Тэгээд энэ дээр та тодруулж өгөөч.

Б.Пүрэвдорж: Сандаг-Очир дарга хариулъя.

Ц.Сандаг-Очир: Бид нар анх удаа Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулж байгаа асуудал биш. Өмнө нь олон олон Ерөнхий сайд нарыг огцруулж байсан. 2017 оны 9 сарын 7-нд Ж.Эрдэнэбатын Засгийн газрыг огцруулах асуудал яригдаж байхад Их Хурлын дарга М.Энхболд дарга байсан байна лээ. Энэ хурлын материал, тэмдэглэлийг parliament.mn дээрээс нь аваад үзэж болно. Тийм учраас одоогоос яг 8 жилийн өмнө яг ийм процедураар Эрдэнэбатын Засгийн газар унаж байсан ийм бас кэйс байгаа юм билээ. Байнгын хороо нь огцруулъя гээд гарын үсэг зурж явж байсан. Байнгын хороон дээрээ огцруулъя гэснийг огцруулахгүй гэж шийдвэр гарч байсан. Их Хурал дээрээ Байнгын хорооны саналыг огцруулахгүй гэснийг дэмжье гэснээр санал хурааж, ингээд кноп нь хүрээгүйгээр Эрдэнэбатын Засгийн газар унаж байсан юм байна лээ гэдгийг нэгд хэлье.

Хоёрт хэлэхэд эрхэм гишүүд маань энэ өөрөө өргөдлөө өгөөд ёс зүйгээрээ явъя гэж байгаа хүнийг бушуухан .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Минутдаа хариулж сур. Гомбын Ганбаатар.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Бид нар анх удаа Монгол төрийн түүхэнд төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын дарга болоод Ерөнхий сайдыг огцруулж байгаа нь бараг анхны түүх байх. Энэ юунаас эхтэйг ч та нар өөрсдөө мэдэж байгаа. Миний асуулт энэ парламентын засаглалыг ер нь аюулд учруулах шахлаа бид бүхэн. Парламентын засаглалыг аюулд учруулж Үндсэн хуулийн хямрал руу түлхэж байгаа нь үндэсний эв нэгдэлд ноцтой хохирол учруулж байгаа хэлбэр мөн үү гэж асуух асуулт байна. Энэ асуултыг бол би Амарбаясгалан даргаас асууж байна. Эхлээд би энэ асуултаа асуучихъя. Өнгөрсөн сар гаруй хугацаанд та бүхний намын даргын өрсөлдөөн чинь энэ улс орныг Үндсэн хуулийн хямрал руу, дээрээс нь парламентын засаг таны ярианд ч бас парламентын засаг аюулд учрах гэж ярьж байгаа харагдсан. Энэ хямрал руу түлхэж байгаа хэлбэр мөн үү? Би энэ асуултаа асуусныхаа дараа би бас өөрийнхөө асуултыг асууя гэж бодож байна. Үндсэн асуултаа.

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Тийм өнгөрсөн 2 өдрийн л жишээ л дээ. Үндсэндээ парламент нь хурлаа хийж чадахгүй, ирц бүрдэхгүй нөхцөл байдал үүсэж байгаа нь парламентаар дамжуулж улмаар Үндсэн хуулийн хямралд орох нөхцөл, суурь тавигдах эрсдэл бүрдэх вий гэдгээс л болгоомжилж, би түрүүн хэллээ. Надаар дамжуулж парламентын хямралыг бий болгох аюул ирэх вий дээ гэдгээс би

болгоомжилж энэ өргөдлийг бол өгсөн байгаа. Ажил, албан тушаал нэг хэрэг. Хамгийн чухал бидний хайрлаж, хамгаалж байх зүйл бол өөрөө энэ ардчилсан парламентын тогтолцоо гэдэг дээрээ би өөрөө хатуу итгэл үнэмшилтэй байдаг хүний хувьд энэ тогтолцоогоо хамгаалах үүднээс өргөдлөө өгсөн.

Надад өргөдөл өгөхөд ерөөсөө эргэлзээ байгаагүй. Яагаад гэвэл миний эрхэмлэж байгаа үнэт зүйл рүү халдах гэж байгаа учраас би энийг хамгаалахын төлөө зоригтой шийдвэр гаргах нь миний зарчим юм гэж бодож энэ шийдвэрийг гаргасан байгаа. Монгол Улсын хувьд мэдээж үе үеийн энэ парламентын засаглалд аюул учрах нөхцөл тохиолдлууд бас гардгийг та бүхэн бүгдээрээ мэднэ. Тэгээд 10, 10 жилийн давтамжтай ийм нөхцөл байдлууд бүрдээд ирдгийг та бид мэднэ. Гэхдээ үүнээс бид ямархуу хэмжээнд дуу хоолойгоо өргөж, ямар хэмжээнд ардчиллынхаа бат цайз нь болж хамгаалж гарах вэ гэдэг нь улс төрийн намууд, улс төрчдийн эр зориг, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар л хэмжигдэж байдаг гэж миний хувьд ойлгодог.

Тэгээд би ч гэсэн цаашдаа өнөөдөр Улсын Их Хурлын даргын ажлыг өгөх хүсэлтээ өгөөд парламентаар хэлэлцүүлээд шийдүүлж байгаа ч гэсэн миний хийж байсан, зорьж байсан, тэмцэж байгаа үйл хэрэг зогсохгүй. Улам бүр цаашдаа энэ итгэл үнэмшлээ баталгаажуулахын төлөө энэ парламентад орж ирсэн олон намын төлөөлөл болсон олон шинэ залуу гишүүдтэй энэ XXI зууны чиг хандлагыг, XXI зууны парламентын зарчмыг Монголд бүрэн нутагшуулахын төлөө бүх талаар хамтарч ажиллана гэдгийг бас бодож, зорьж хэлэхийг хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Гомбын Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

Г.Ганбаатар: Тэгэхээр сая таны асуултад бол үндсэндээ үндэсний эв нэгдэлд ноцтой хохирол учруулж байгаа талаар, парламентын засаглалд аюул учруулж байгаа талаар, мөн Үндсэн хуулийн хямрал руу түлхсэн талаар маш тодорхой хариуллаа. Би хувь хүн гэхээсээ илүү тэртээ тэргүй сая Улсын Их Хурлын дарга таныг ажиллаж байх үед бас Монгол Улсын гүйцэтгэх засаглалын тэргүүн та бүхэнтэй хамтарч байсан Хууль зүй, дотоод хэргийн сайд маш олон баримт ярьсан. Маш их хулгай луйврын тухай ярьсан. Би та нарыг хувь хүнтэй чинь ярих гэсэн юм алга л даа. Тэр нь тэгээд цаг хугацаа хууль, шүүхийн байгууллагаар тодорхой болох биз. Түүнийгээ бас шалгуулаарай гэж хүсэх байна.

Хоёрдугаарт нь ингээд зүгээр өргөдлөө өгөөд огцрох, ер нь өргөдлөө өгөх, огцрох гэдэг чинь бараг шагнал болох нь байна шүү. Үнэхээрийн ийм их хулгай зэлгий хийсэн бол. Миний үндсэн танаас асуусан асуултын хариулт нь гэхээр Улс төрийн намын тухай хуулийн 10.1.1-д аливаа улс төрийн нам нь улс, үндэсний эв нэгдэлд ноцтой хохирол, аюул учруулсан бол үйл ажиллагааг нь хориглоно гэж заасан байгаа юм. Тэгэхлээр энэ заалт .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмээд тодруулчихъя Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Тэгэхээр Улс төрийн намын тухай хуулийн 10.1.1 буюу үндсэндээ энэ удаагийн өнөөдрийн манай байгаа парламент Улсын Их Хурлын дарга аа, дээрээс нь Ерөнхий сайд аа нэг өдөр огцруулж байгаа чинь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 гишүүнээ нэг өдөр огцруулж байгаа чинь улс, үндэсний эв нэгдэлд бараг ноцтой хохирол учруулж байна. Тийм учраас хувь хүн

гэхээсээ илүү Монгол Ардын нам энэ хулгай, луйврын үүр болсон Монгол Ардын нам Улс төрийн намын тухай хуулийн дагуу татан буугдах болж байгаа юм биш үү. Та энэ дээр юу гэж хариулах вэ?

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Улмаар улс үндэстний аюулгүй байдалд аюул учруулж болохуйц нөхцөл үүсгэхээс урьдчилан сэргийлсэн арга хэмжээг өнөөдөр миний бие авч байгаа гэж би өөрөө ойлгож байгаа. Энийг цааш нь даамжруулахгүйгээр энэ хүргээд зогсох цэг нь болсон гэдгийг би өчигдөр бас олон нийтэд хандаж хийсэн мэдэгдэлдээ хэлсэн гэдгийг бас хэлмээр байна. Нэг зүйлийг Ганбаатар гишүүн бас танаас ойлгохыг хүсэж байна. Одоо хэвлэлээр баахан холбоос гаргаж ирж байгаад Амарбаясгалан үүнтэй холбоотой байж болзошгүй л гээд л гаргаад ирчхэж байгаа юм. Надтай хамт 10 жилийн сургуульд сурч байсан нөхрийг, надтай хамт их сургуульд сурч байсан нөхрийг, надтай хамт Говь-Алтай аймгийн “Төрөлх Алтай” Төрийн бус байгууллага байгуулаад, 1998 оны төгсөгчдийн бүрэлдэхүүнд орж ирээд, тэрний удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 15 хүний 1 болсон хүнийг надтай хамаарал бүхий этгээд болгож, түүгээр дамжуулж намайг нүүрсчин болгох оролдлого бол өргөн хүрээгээр хийгдсэн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмээд хариулъя.

Д.Амарбаясгалан: Би энэ чуулганы хариуцлагатай микрофон дээрээс хэлэхэд ямар нэгэн байдлаар миний бие, миний ураг төрөл, ах дүү, хамаатан садан Бор тээг гэдэг уул уурхайн ордтой ямар ч холбоо байхгүй. “Админерал” гэдэг тэр компанитай ямар ч холбоо байхгүй гэдгийг маш хариуцлагатайгаар хэлье. Би харин жинхэнэ нүүрсчдийн өмнүүр орж Алтанхуяг даргын хэлдгээр хонгилдуулж гүтгэгдсэн XXI зуунд гарч байгаа томоохон гүтгэлгийн эзэн болсон байгаа шүү гэдгийг бас хэлье.

Б.Пүрэвдорж: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууя.

Ч.Лодойсамбуу: Их Хурлын даргаас тодорхой асуултууд. Мэдээжийн хэрэг Үндсэн хуулиар бид нар хэн нэгнийг шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй байхад гэм буруутан гэж үзэх боломжгүй. Гэхдээ эргэлзээг тайлах, заавал тайлах ёстой субъект бол та өөрөө Их Хурлын дарга. Эрдэнэжаргал, Чулуунзагд гэдэг хүмүүс та сая хэлж байна 10 жил, их сургууль хамт төгссөн найз нөхөд. Найз нөхөд юм байна. Таныг Ерөнхий нарийн бичгийн дарга байх үед нарийн бичгийн дарга чинь байсан уу? Ер нь хамтарч ажиллаж байсан уу? Хамт ямар нэгэн ажил хийж байсан уу? Нэг.

Хоёрдугаарт, Та энэ асуудалтай холбоотой намайг ерөөсөө шалгаагүй гээд байгаа юм. Намайг ерөөсөө шалгаагүй гээд байгаа юм. Нөгөө талдаа гарч ирэхээр намайг ерөөсөө манай гэр бүлээс авхуулаад бүгдийг нь шалгаж байна гээд байгаа юм. Шалгаж байгаа юм уу, шалгахгүй байгаа юм уу таныг?

Гуравдугаарт, Тагнуулын ерөнхий газрын гаргасан бичгийг та үзүүлээдэх. Сая та хэний асуултад хариулчхав. Гишүүдэд тараалаа гэх шиг болох юм. Хэн гэдэг гишүүнд тараасан юм? Надад лав ирээгүй. Манай Ардчилсан намын гишүүдээс сая асуулаа. Ирээгүй байна. Тэрийгээ тараачихаа. Үзье.

Нэг дүгнэлт хэлэхэд сая хар пи ар парламентын засаглалд аюул учирсан бид нар ийм харанхуй цаг үеийг туулаагүй ээ гэж. Худлаа л даа. Одоо тантай яг мөр зэрэгцээд сууж байгаа хүнийг Ерөнхий сайдаар ажиллаж байсан энэ 5 жилийн хугацаа, сүүлийн 6, 7 сарыг нь бол би яг өөрөө биеэрээ үзэж туулсан хүн л дээ. Хамгийн харанхуй засаглал бол энэ үед явж байсан юм шүү. Саяынх бол үндсэндээ танай дотооддоо л та бүхэнд л жинтэй санагдаад байгаа болохоос биш та бүхэн тэр үед мэдрээгүй байх. Бид нар бол мэдэрч байсан. Баярмаа гишүүн байна. Энд мэдэрч байсан хүмүүсийн төлөөлөл.

Тэгэхээр энэ нэг талдаа бид нар парламентын ардчиллаа хамгаалдаг итгэл үнэмшилтэй гэж итгэл төгс хэлдэг. Нөгөө талдаа бид нар парламентаа дандаа эрх мэдлийн тулаанд ашиглаж, нөгөө парламентын ардчиллаа сөхрүүлэх ийм л алхмуудыг хийдэг. Тэгэхээр энийг бас тодорхой хэлж өгөхгүй бол бас зарим юм буруу дүгнэгдээд байх шиг байна.

Дөрөвдүгээрт, Одоо манай парламент ер нь балрах гээд байна гээд байгаа юм. Энэ өнгөрсөн хугацаанд өчигдөр, өнөөдрийн чуулганы хуралдаан болж байгаа процессыг харахаар парламент бас жинхэнэ утгаараа ажиллаж байна шүү гэж Монголчуудад бас хэлмээр байна. Энэ 126 гишүүнтэй парламент ажиллаж байгаа учраас өнөөдөр 2 дугаар хүн, 3 дугаар хүн огцрох асуудал дээрээ тулж байгаа .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулья.

Д.Амарбаясгалан: Лодойсамбуу гишүүнтэй санал нэг байгаа зүйл нь энэ олон үл ойлгогдох гүтгэлгүүдийг эргэлзээг тайлах ёстой гэдэгтэй 100 хувь санал нэг байна. Би өчигдөр бас олон нийтэд хандаж мэдэгдэл хийхдээ энэ эргэлзээг бүрэн тайлна гэдгийгээ бас хэлсэн. Намайг гүтгэсэнтэй холбоотой асуудлуудаар би холбогдсон этгээдүүдийг шүүх, хууль хяналтын байгууллагуудад бүрэн хандсан. Харамсалтай нь шүүгчийн зарлан дуудахаа авдаггүй, бултдаг, асуудлыг шийдвэрлэхэд саад учруулдаг гээд их олон хүндрэлүүд энд гардаг юм байна лээ. Та бүхэн ч гэсэн магадгүй зарим тохиолдолд энийг өөрсдөө мэдэрсэн хүмүүс энэ танхимд байгаа болов уу гэж бодож байна. Шүүхээс дууддаг очдоггүй. Шүүхийн зарлан дуудах бичгээ авдаггүй гээд янз янзын асуудлууд бол энд байгаа. Тэгээд би хариуцлагатай хэлэхэд бүх асуудлыг хууль хяналтын байгууллагуудаар бүрэн шалгуулж, нэр төрөө бүрэн сэргээлгэнэ гэдгийг би хэлэхийг хүсэж байна.

Саяхан бас л гүтгэж байгаа юм. Эрдэнэжаргал гэдэг залууг миний нарийн бичгийн дарга, туслах, зөвлөх байсан гэж. Хэзээ ч тийм туслахтай байгаагүй. Хэзээ ч би тийм зөвлөхтэй байгаагүй. 2011-2013 онд хамтарч tor.mn гэдэг онлайн худалдааны сайт байгуулж, ажиллуулах гэж үзээд тэр үед онлайн худалдаа дэлгэрээгүй байсан учраас амжилтгүй болоод дампуурсан тийм л хамтын ажиллагаа байсан. Гэтэл тэр хүний 2020 онд хийсэн бизнесийг надтай холбож, энэ нөхөр ингэж хөрөнгөжсөн байна гэдэг асуудлыг гаргаж тавьж байгаа юм. Энэ зовлон бас та нар дээр ирнэ шүү. Та бүхэн маань их болгоомжтой байгаарай. Яг ийм байдлаар хүнийг хамааралгүй хүмүүстэй холбож, авлигажсан, тендержсэн, хулгай хийсэн, хөрөнгөжсөн гэдэг энэ мэдээллийг олон нийтийн мэдээллийн дутуу байдлыг ашиглаж түгээдэг энэ технологи Монголд хөгжиж байна. Хөгжиж байна.

Энэ цаашдаа та нар дээр тохиолдох аюул шүү. Энийг бас гишүүд маань дотроо их сайн бодож, тунгааж аваарай гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Чулуунзагд гэж залуугийн хувьд Монгол Ардын намын Хэвлэл мэдээллийн хэлтсийн даргаар ажиллаж байсан. Нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Гэхдээ миний томилгоогоор биш. Намын Бага хурал, Удирдах зөвлөлийн томилгоогоор томилогдож, хамтарч ажиллаж байсан. Говь-Алтай аймагт 10 жил төгссөн нь үнэн. Манай нөгөө параллель анги байсан нь үнэн. Гэхдээ намд бол намын Бага хурал болон Удирдах зөвлөлийн шийдвэрүүдээр ажиллаж байсан гэдгийг бас хэлье.

Тэр Тагнуулын байгууллагын шинжээчийн дүгнэлтийг би одоо хувилуулаад та бүх бүхэнд гар дээр чинь тараая. Өмнө нь бас гишүүдийн өрөөнд ийм тайлбар баримттай материалыг бас тараасан байгаа. Нэмж энэ тагнуулын шинжээчийн дүгнэлттэй холбоотой материалыг өгье.

Б.Пүрэвдорж: Лодойсамбуу гишүүн тодруулъя.

Ч.Лодойсамбуу: Аль болох баримтад бид нар итгэх гээд байгаа юм л даа. Тал талын байр сууриудыг сонсоод, итгэх гээд байгаа юм. Сая та тараасан гэж хэлээд, тараагаагүй л юм байна шүү дээ. Ингээд л 1, 2 үг худлаа хэлэхээр л наадах чинь бол ярилцлага байна. Нөгөө тагнуулын бичгийг та тараасан гэж түрүүн яг бүр хэлсэн юм шүү дээ. Энийг залгаад л тавих хүмүүс. Тэгэхээр ингээд худлаа яриад байхаар бусад бүх юманд чинь итгэх эргэлзээ төрөөд байгаа учраас дахин дахин асуугаад байна.

Та түрүүн хэлж байна. Та бүхэн дээр ч гэсэн гишүүдээ ингээд янз янзын юм наагаад л гүтгэдэг юмнууд явна шүү гэж. Явдаг байсан юм шүү дээ. Явж байгаа шүү дээ. Байнга явж байгаа шүү дээ. Зүгээр зүсийг нь хараагүй хүмүүстэй холбоод л тавьдаг. Энийг бол мэднэ. Энийг харин зүгээр эцэслэж, хууль хяналтын байгууллагынхан хурдтай ажиллаж тогтоох л ёстой. Энэ хохирогч нь өөрөө яриад байна шүү дээ. Гүтгүүлдэг.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Эрхэм гишүүд ээ, би өчигдөр өглөөнөөс хойш 8 цагаас хойш 31 цаг тасралтгүй байж байгаа учраас хоолой маань жоохон сааралтаад байгаа шүү. Болгооно уу.

Гишүүдийн ёс зүйн дүрэм байгаа. “3.2.Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн хүндэтгэлтэй хандах, бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх, доромжлохыг цээрлэнэ.” гэж. Хэдүүлээ бүгдээрээ нэг прокурор болчихсон юм шиг л ийм байдалтай сууж байна л даа. Олон нийтийг төөрөгдүүлэх, үндэслэлгүй мэдээлэл хийхийг бас хориглож байгаа. Энэ ёс зүйн дүрмээр. Амарбаясгалан дарга та шалгагдаж байгаа юу? Гүтгэлгийн талаар та шүүхэд гомдол гаргаж байсан уу гэдгийг бас асууж байсан. Үүнийг бас та тодруулж өгнө үү.

Би Ардчилсан намдаа юунд талархал дэвшүүлмээр байна вэ гэхээр та бүхэн маань өчигдөр өглөө 9 цагаас хуралдах, 10 цагаас хуралдах Пүрэв гарагийн

чуулганы ирцдээ 9 цагаас хойш бүртгүүлж, хэсэг бүлэг нөхөд маань орж, 61 хүний ирцтэйгээр бид өчигдөр өглөө 9 цагаас хойш өнөөдрийг хүртэл 25 цаг хүлээж байж өнөөдрийн чуулган эхэлсэн. Тэгэхээр өчигдөр орой гэнэт шийдвэр гараад ирцээ нээсэн асуудал огт биш. Өчигдөр өглөө 9 цагаас чуулганы ирцэд бүртгэх бүртгэлийн систем бол нээгдсэн. Өнөөдрийн энэ байгаа нөхцөл байдал бол та бүхэнд ч гэсэн хэдэн жилийн өмнө бас тохиолдож байсан институт хоорондын ийм бас зовлон байгаа гэдгийг ний нуугүй та бүхэндээ бас хэлмээр байна. Тэмүүжин гишүүндээ ч гэсэн баярлалаа. Өнгөрсөн хавар Оюун-Эрдэнийн Засгийн газар огцрох тэр үед Тэмүүжин гишүүн гэнэт л бас нэг гарын үсэг зураад, цуглуулаад нэг бичиг гаргаад ирсэн. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд ч гэсэн бас огцрохдоо, итгэл үзүүлэх тэр бичгээ гаргахдаа бас нэг тийм институт хоорондын зөрчил байна гэдгийг илэрхийлсэн.

Яах вэ, би энийг дэлгэрүүлж ярихаас илүүтэй ер нь бол манай нам доторх асуудал цагаан байрнаасаа халиад өнөөдөр төрийн зовлон болсон нь бол үнэн. Тэгээд бидэнд бас боломж олгож, та бүхэн маань өчигдөр бүлгээрээ гаргасан шийдвэр 3 одтой шийдвэр буюу Засгийн газар болон Улсын Их Хурлын дарга Амарбаясгаланд хоёуланд нь хариуцлага тооцъё гэдэг энэ 3 одтой шийдвэр дээрээ бас баттай зогсож, өнөөдөр өөрийнхөө хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ илэрхийлж байгаа Амарбаясгалангийн шийдвэрийг нь бас хүндэтгэж, огцруулж өгөхийг бас хүсэж байна. Манай журмын нөхдөөсөө ч гэсэн би бас улс төржүүлэхгүй албан тушаалаас нь огцруулаад, Засгийн газраа ч гэсэн огцруулсан дээрээ баттай байгаад ямар нэгэн хөшигний ар дахь энэ нөлөөллүүд нь ил гарахгүйгээр хэдүүлээ цагаан байран дээрээ ярилцъя гэдгийг хичээнгүйлэн хүсье. Хангалттай хэдүүлээ улс төржлөө. Одоо болно. Амарбаясгалан дарга саяын .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Би шалгагдаагүй ээ.

Б.Пүрэвдорж: Товчхон тодруулчихсан. Сайнзориг гишүүн асууя. Сайнзориг гишүүн алга байна. Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Ариунзаяа гишүүний хэлдэг үнэн. Монгол Ардын намын зовлон Монгол төрийн зовлон болоод, та хэдийн хоорондоо хагарсан байлдаанаас болоод энэ ард түмэн бүр паникт орлоо. Дээрээс нь парламентын ардчилал алдагдахад хүрлээ. Ардчилсан нам байгаагүй бол энэ төр будаа. Энэ Монгол улс будаа. Бидэнд баярлаж явах хэрэгтэй танай нам. Ардчилсан нам байгаа тулдаа ардчиллыг барьж тогтоолоо шүү дээ.

Тэгээд сая ингэж ярьж байгаа байхгүй юу Ариунзаяа гишүүн та огцруулаад өгөөч ээ Амарбаясгалан даргыг. Бид нар цагаан байран дээрээ очоод ярья гэж. Үгүй. Танай цагаан байрнаас хальсан наад асуудал чинь. Төрийн асуудал болсон. Тийм учраас төрийн асуудлыг нэг мөсөн цэгцэлж дуусах ёстой. Амарбаясгалан дарга та өөрийгөө Авлигатай тэмцэх газарт шалгуулах ёстой. Энэ Улсын Их Хурлын даргаас буух чинь юу юм бэ. Юу ч биш шүү дээ. Та хүн амины гэмт хэрэгт холбогдсон. Та нүүрсний хулгай, Бор тээг гэдэг газрыг завшсан хэрэгт холбогдсон. Авлигатай тэмцэх газарт шалгуулж, эцсийн дүгнэлт, тэр шийдвэрийг хүн алсан бол

алсан. Хулгай хийсэн бол хулгай хийсэн. Тэрийгээ авчирч энэ парламентад танилцуулах ёстой.

Дээрээс нь хэн таныг ямар учраас гүтгээд байгаа юм гэдгийг одоо хэлээд өг. Хэн, хэн юм, хэн парламентын ардчиллыг алдагдуулах гээд байгаа юм? Хэн юм? Тэгээд бүдэг бадаг юм ярьчихаад, бид мэдэж байгаа, тэгж байгаа гэххээд цагаан байр руугаа гүйж орж, эвлэрч гарч ирчхээд 11 сарын 15-аас хойшоо энд хөөрхөн суухгүй ээ найзууд аа. Наадах чинь одоо төрийн хэрэг болсон. Бид оролцсон. Тэгэхээр бид одоо энийг бүр эцсийг нь хүртэл явах ёстой байхгүй юу. Хэн юм. Хэн айлгаж, ичээгээд, хэн энэ төр засгийг хөмөрч бүр ганц хүний дарангуйлалд орох гээд байгаа юм? Нэрийг нь хэлээч. Одоо танай асуудал биш. Энэ төрийн асуудал болсон. Тэгэхээр Ардчилсан нам өнөөдөр энд бүлэггүй байгаагүй бол Монгол Улс дуусах нь байна шүү дээ. 8 жил төр барьсан том хүчин 100 гаруй жилийн түүхтэй Ардын нам яасан ичдэггүй юм. Тэр цагаан байр руугаа буцаж гүйж орохгүй. Одоо эндээ хагалуул юм аа. Тэр хууль хяналтын байгууллагаараа шийдүүл. Би танаас 2 юм асуусан тээ. Хэн.

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүндээ хандаад хэлэхэд та их буруу зүйл ярих шиг боллоо. Би хүн амины хэрэгт холбогдоогүй шүү. Хүн амины хэрэгтэй холбоотой гэж гүтгүүлсэн. Та бол сая холбогдсон гэж хэлж байна. Энэ хүний эрхэм нэр хүндэд ингэж халдаж болохгүй гэдгийг бас хариуцлагатай хэлье.

Бие муутай байсан хүн унтаад босож ирээгүй. Нөгөөдөх нь цагдаа, шүүхийн шинжилгээний хүрээлэн, эмнэлгүүдээр бүх шинжилгээнүүд нь хийгдсэн. Ямар нэгэн асуудал байгаагүй гэдгийг цагдаагийн байгууллагын дүгнэсэн бичгээ надад ирүүлсэн талаар би бас хэвлэл мэдээллээр олон нийтэд хэлсэн. Ер нь ийм л болсон байна. Баримтгүйгээр хүнийг гүтгэдэг, гүтгэж байгаа үгийг та бүхэн анзаараарай. Болзошгүй, магадгүй, би тэгж бодож байна гэдэг үгнүүдээр хэлдэг. Би таныг тэгсэн байж болзошгүй гэж бодож байна гэдэг үгээр хүний нэр төрд дамжуулан халддаг энэ байдал бол хэрээс хэтэрсэн.

Ер нь яах вэ, мэдээж яагаад над руу энэ нүүрсчин болгох, энэ бохир, нэр хүндийг унагаах ийм технологи, үйл ажиллагаануудыг зохион байгуулж хийж байна вэ гээд та асууж байх шиг байна. Би ч бас өнөөдрийг хүртэл гайхаад явдаг юм. Хэний ямар том эрх ашгуудыг хөндсөнөөс болж өнөөдөр энэ түвшинд хүрч ирээд байна вэ гэж. Өчигдрийн л жишээ шүү дээ. Парламент хуралдаж чадахгүй болж байгаа жишээ. Парламентын чуулгандаа ирж чадахгүй байсан гишүүдээс харин энийг юунаас айгаад ирэхгүй байсан юм бэ гэдгийг асуух ёстой. Өнөөдөр би ганц дуугарч байгаа нь байж үлдэхгүй. Үлдмээргүй байна. Өнөөдөр дуугарч байгаа энэ сөрөг хүчин Ардчилсан нам энэ ардчиллынхаа бат цайз нь бол зогсох ёстой тэр үүргээ гүйцэтгэх ёстой гэдэг дээр би хэлэхийг хүсэж байгаа юм.

Монгол Улсад хууль, шүүхийн байгууллага нь шударга ажилладаг. Улс төр нь хууль хяналттайгаа хутгалддаггүй. Элдэв янзын хонгил угсарч, түүгээрээ чирдэггүй байх тэр цаг нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө бид харин анхаарч ажиллах ёстой. Ийм зүйлүүдээр айлгаж, ийм зүйлүүдээр дарамталж, Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы хуралдаанд оролцох, хэнээс ч хамааралгүй, нөлөөгүйгээр шийдвэр гаргах тэр нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэл дээр бид харин анхаарч ажиллах

ёстой. Хэн бэ гэдгийг бид өөрсдөө хайх ёстой. Энгийг олох ёстой. Энгийг бид засах ёстой. Залруулах ёстой. Энгийн иргэдэд ирдэг тэр дарамт шахалтууд өнөөдөр энэ парламентын түвшинд ямар их өргөн хүрээгээр мэдрэгдэж байна вэ гэдгийг ч бид ойлгож, засахын төлөө хичээж ажиллах ёстой юм гэж ингэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Энэ асуудал дээр үг, асуулт хоёулаа хамт явж байгаа. Одоо 3 хүний дараа санал хураалт явагдана. Тийм учраас гишүүдийг чуулгандаа орохыг хүсэж байна. Одоо Буланы Бейсен гишүүн асуулт асууна. Уучлаарай. Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Амарбаясгалан дарга аа, би таныг ингэж гүтгээд байгаа биш. Их Хурлын гишүүн хүн хариуцлагатайгаар хэлсэн шүү дээ. Хүн амины хэрэгт холбоотой, бараг л алчихсан юм шиг. Энхбаяр гишүүн байна уу? Одоо шууд ингээд л нүүр нүүрэн дээрээ ярьчихмаар байх юм. Тэгээд нууцлаг юм яриад л явмааргүй байгаа байхгүй юу даа. Тэгээд одоо би гүтгэсэн болж таарах гээд байна шүү дээ. Тийм биз дээ.

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн асуулт асууя. Хариулах юм уу. Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Энэ ноцтой асуудал яригдаж байгаа учраас би бас заавал тайлбар хийх ёстой гэж бодож байгаа юм. 2025 оны 10 сарын 2-ны өдрийн Цагдаагийн ерөнхий газраас миний нэр дээр ирүүлсэн бичиг байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Админерал” компанийн ажилчдын байранд 2025 оны 2 сарын 12-ны өдөр ХБНГУ-ын иргэн Н.Хасбаатар нас барсан гэх мэдээлэлд тус аймгийн Цагдаагийн газрын Цогтцэций сумын сум дундын цагдаагийн хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж, мөн оны 3 дугаар сарын 2-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорын байгууллагад хүргүүлсэн болохыг мэдэгдье гэж байгаа юм. Прокурорын байгууллагад хүргүүлээд 7 хоногийн дотор хариу ирээгүй бол энэ хэрэг хаагдсанд тооцогддог хуулийн заалттай юм байна лээ. Тэгээд ямар ч холбогдолгүй зүйлээр хүнийг гүтгэсэн. Улсын Их Хурлын гишүүн үнэн ярьдаг гэж ойлгож болохгүй. Худлаа ярьдаг Улсын Их Хурлын гишүүн байна. Хүн гүтгэдэг Улсын Их Хурлын гишүүн бас байна.

Б.Пүрэвдорж: Яг ингээд энэ асуудал дээр тодорхой Их Хурлын гишүүний нэр хэлээд Мөнхбаясгалан гишүүн асуулт асуугаад байна. Яг энэ дээр хариулж болох уу гэдгийг Ариунхур дарга хэлээдэх дээ. Уг нь болохгүй л байх ёстой. Би тэгэхдээ тодорхой болгож өгмөөр байна. 1 номер.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын даргын чөлөөлөгдөх хүсэлтийг яг одоо энэ цаг мөчид хэлэлцэж байна. Тэгэхээр гишүүд бол асуулт асууж, үг хэлэх эрхтэй. Энэ асуултын хариултад Байнгын хорооны дарга санал, дүгнэлтээ гаргасан Байнгын хорооны дарга болон мөн хүсэлтээ гаргасан Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан дарга л хариулах үүрэгтэй.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар Монгол төр хямраад, нэлээн хүнд байдалд байна. Энийг дагаад төрийн түшээдийн нэр хүнд бас унаж байна. Өглөө би бас эмнэлгээр явлаа. Бараг хулгайч очирлож байна энэ тэр гээд наад зах нь тэгж байна шүү дээ. Бид нарын чинь нэр хүнд унаж байна. Харамсалтай л байна. Ардын намын даргын сонгуультай холбоотой ингээд тэр маргааныг авчраад Төрийн ордонд ингээд хагарал үүсгээд, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд хоёрыг огцруулж байна л даа.

Гэтэл сая бид Монгол Улсын Ерөнхийлөгчтэй хамт Энэтхэг Улс руу яваад ирсэн. Урдаас төлөвлөсөн ажил байсан. 6 гишүүн явсан. Бүх намын төлөөлөл. Миний хувьд эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн талын асуудлаар явсан. Хоршооны. Энд бас Ерөнхийлөгчийг бас буруутгаж байна. 6 гишүүнийг авч явсан юм байна гээд Ерөнхийлөгчийн нэр хүндэд халдаад. Гэтэл тэнд Ерөнхийлөгч бол ерөөсөө энийг хамгаал, энийг огцруул гээд тийм юм яриагүй бид нарт. Амарсайхан сайд бас давхар явсан. Энийг бас бид нар хариуцлагатайгаа хэлчихье гэж бодож байна. Энийг бас зөвөөр ойлгоно биз дээ.

Амарбаясгалан даргаас асууя гэж бодож байна. Энэ өвлийн хахир хүйтэн ирлээ. Нөгөө талаар ингээд эмч, багш нар, ахмадууд цалингаа нэмүүлнэ гээд өлсгөлөн зарлаж байна. Урьд нь ер цалин нэмэх, тэтгэвэр, тэтгэмжийн боломжгүй гэсэн мөртөө сая хэд хоногийн дотор 15-20 хувь нэмж болж байна гэж ярьж байна. Ер нь урьд нь танд бид нар бас 5 жил ярьж байсан. Ер нь нэмэх боломж төрд байгаа юм уу. Та анзаарч бас Их Хурлын даргын хувьд бас Засгийн газарт хэлж байсан уу энэ Сангийн сайдад. Энэ талаар асууя.

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Сүүлийн өдрүүдэд бас энэ төсөв хэлэлцэж байгаатай холбоотой Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлтэй холбогдуулан багш, эмч, үйлчилгээний салбарын ажилчдын хувьд цалингийн нэмэгдлийн асуудлыг их хэмжээгээр хөндөж байгаа. Бас дундаж цалинтай холбоотой асуудал тэнд нэлээдгүй хөндөгдөж, яригдаж байна. Тэгээд зайлшгүй цалин нэмэгдлийн шаардлага бол бодитой байгаа. Засгийн газрын зүгээс өргөн барьсан төсөл дээр төдийлөн хангалттай биш гэж салбарынхан үзэж байгаа. Зүгээр энд би бас Ардчилсан намын болон бусад намын гишүүддээ хандаж хэлэхэд энэ улсын төсвийг хоёрдугаар хэлэлцүүлэг бол энэ асуудлын дараа хэлэлцэгдэнэ. Улсын Их Хурал санаачилгаараа энэ хоёрдугаар хэлэлцүүлэг дээр нь дэмжиж, төсвийг хүлээж аваад, эргээд Улсын Их Хурлын түвшинд ажлын хэсгээ албан ёсоор байгуулаад, Улсын Их Хурлынхаа ажлын хэсгийн хүрээнд цалингийн нэмэгдлийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх боломжтой гэж харж байгаа юм. Зарим төрлийн зардлыг бууруулах замаар багш, эмч, үйлчилгээний ажилчдын цалинг өнөөдөр шаардаж байгаа түвшинд нь хүрдэггүй юм гэхэд Засгийн газраас зорьж байгаа түвшнээс ахиулж нэмэх зайлшгүй шаардлага байна гэж бол харж байгаа. Мэдээж нарийвчилсан тоо, нэгтгэлийг бол ажлын хэсгийн түвшинд хийгээд явах нь зүйтэй гэж ингэж хэлэхийг хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Би асуулт асуухгүй. Үг хэлнэ ээ. Өнгөрсөн энэ 10 хоногийн хугацаанд бид ч ёстой булаагаа чирч л байна л даа яг үнэнийг хэлэхэд. Засгийн газрыг огцруулах санал гаргасан тэр цаг хугацаанаас хойш маш олон процедур Үндсэн хуулийн эсрэг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудыг зөрчсөн ийм олон процесс явж өнгөрлөө. Би одоо хамгийн эхний асуудлыг л ярьж хэлэх гээд байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрыг огцруулах, Улсын Их Хурлын даргыг огцруулах саналаа гаргах эрх нь нээлттэй. Хэн ч хорихгүй. Яагаад энэ процессыг процедурынх нь дагуу явуулахгүй байгаа юм.

Баасандорж дарга Ерөнхий нарийн бичгийн дарга Дэгийн хуулийн 6.5-ыг энэ чуулганы танхимд яг 2 өөрөөр тайлбарлахыг 2 удаа сонслоо. Өмнө нь Пүрэвдорж даргын асуултад нэг өөрөөр тайлбарлаж байсан. Өнөөдөр дахиад өөрөөр тайлбарлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Үндсэн хуулийн 43.1-ийг өнөөдөр нэгээр, маргааш нэг өөрөөр тайлбарлахыг харлаа. Улсын Их Хурлын дэд дарга хууль биш хүн засаглавал ямар аюултайг, тэр тусмаа тамгатай, алхтай, микрофон нээж, хаадаг эрхтэй хүн ёс зүйгүй байвал ямар аюултайг өнгөрсөн шөнө харууллаа.

Би яагаад ёс зүйгүй гэж хэлж байгаа юм гэхээр энэ Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн “3.8.Улсын Их Хурлын гишүүн үзэл бодол, байр сууриа илэрхийлэхдээ албан ёсны эх сурвалжийг баримтална. Олон нийтийг төөрөгдүүлэх үндэслэлгүй мэдээлэл хийхийг хориглоно.” гэж байгаа юм. Өнөөдөр Засгийн газрыг огцруулахгүй гээд зогсож байгаа гишүүд Ерөнхий сайдын дарамтад орчихсон гэж хэлж байна шүү дээ. Тэгвэл Улсын Их Хурлын даргыг огцруулахгүй гээд зогсож байгаа гишүүд Улсын Их Хурлын даргын дарамтад орчихсон болох юм у? Гишүүдийг ингэж хэлж болохгүй л дээ. Өөр өөрийн үзэл бодол, өөр өөрийн үнэт зүйл, өөр өөрийн эрхэмлэх чанар, өргөсөн тангаргийнхаа хүрээнд энэ хүмүүс чинь итгэл үнэмшлээрээ зогсож байгаа юм. Яагаад энийг ийм байдлаар гуйвуулж, мушгиж гишүүдийн нэр хүндэд халдаж, Үндсэн хуулийн эсрэг зогсохгүй ээ. Үндсэн хууль зөрчиж байгаа санал хураалтад оролцохгүй ээ гээд зогсож байгаа гишүүдийг хууль зөрчиж байгаа юм шиг, хулгай хийгээд нийлээд явчхаж байгаа юм шиг, хэн нэгний дарамтад орчхож байгаа юм шиг, ажил, албан тушаалын шантааж, наймаанд орчхож байгаа юм шиг ийм байдалд оруулж, өнөөдөр парламентын ардчилал засаглалыг ёстой жинхэнэ шороотой нь хутгаж байгаа юм бэ. Юуны төлөө. Эндээс би юу гэж ойлгож байна гэхээр цаашдаа бид Улсын Их Хурлын гишүүд энэ Улсын Их Хурлын даргын албан тушаал бол намын даргыг хийж болдог, хавсарч болдог албан тушаал биш юм байна гэдгийг хуулиар баталгаажуулах ёстой юм байна. Ийм тогтолцооныхоо өөрчлөлтийг хийж чадахгүй бол бид нар энэ асуудал .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. 1 минут нэмж авъя.

Д.Үүрийнтуяа: Ийм тогтолцооны өөрчлөлтийг хийж чадахгүй бол энэ асуудлыг бид олон дахин үзэх нь ээ. Өнөөдөр Засгийн газрыг огцруулахаараа нүүрсний хулгай гээд огцруулдаг. Энэ нүүрсний хулгай гэж нэг хадны мангаатай боллоо. Нэг бол Засгийн газрыг огцруулах үндэслэл болдог. Нэг бол улстөрчийг харлуулах үндэслэл болдог. Аль нь юм бэ. Энийгээ эцэслэмээр байна. Үүний тулд магадгүй бид нар Эрдэнэс Тавантолгойтой холбоотой асуудлыг олон улсын

менежмент, олон улсын зарчмаар нь Хөрөнгийн бирж дээр гаргаж ажиллуулж байж л үүний ард гарах байх.

Эцсийн дүндээ энэ хууль хяналтын байгууллагаар тогтоогдох ёстой олон асуудлууд бидний ард үлдэж байна. Энийг бид эцэслэж байж парламентын засаглалыг ардчиллынх нь түвшинд авч үлдэх энэ үнэт зүйлийг нь хамгаалж үлдэнэ. Улсын Их Хурлын гишүүд ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнч өнөөдөр энд зогсож байгаа шүү. Хэн нэгний төлөө, хэн нэгнийг дарга болгохын төлөө энд зогсоогүй, суугаагүй гэдгийг би бас хэлэхийг хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Баярмаа: Та бүгд энэ өдрийн амрыг эрье. Тэгээд шөнөжингөө бас элдвээрээ цоллуулсан л даа. Тэгээд бас их тийм тавтай тухтай унтсан ч үгүй. Уг нь бол бас Үндсэн хуулиа бариад, томьёоллоо зөв оруулаад ирвэл бас орж ирээд саналаа өгчихмөөр байсан юм.

Тэгэхээр намын даргын сонгуулиас болоод энэ асуудал үүслээ гэж яриад байх шиг байх юм. Үгүй л дээ. Ардын намын хулгай, булхай, луйвар, авлига зүгээр илэрсэн юм. Ардын намын даргын сонгуулиар илэрсэн юм азаар. Түүнээс биш тэр хулгай, дээрэм, булхай, авлига өмнө нь байсан шүү дээ. Тэгээд ялангуяа Улсын Их Хурлын даргатай холбоотой асуудал бол миний санаж байгаагаар тэр сонсголын үеэс л дурдагдаад байсан. Тэгэхээр бид нар хүссэн, хүсээгүй бараг хэрэг ярих болоод байна л даа. Тэгэхээр хэд хэдэн асуулт байна л даа.

Тэгэхээр энэ хулгайтай холбоотой асуудал ингээд намын даргаар сонгогдсон гэж байгаа Улсын Их Хурлын даргатай холбогдож яригдаад байгаа учраас өнөөдөр яригдаж байна гэж ойлгож байна. Занданшатар дарга бол бас яасан юм бол. Хулгайтай бас холбогдоод сонсголоор дуудагдсан юм уу? Тийм учир бас яригдаад хоёулаа зэрэг огцорч байгаа юм уу?

Хоёрт, тэр 50000 доллар төлөөд ингээд гүтгэсэн нь тогтоогдсон гэж байгаа юм. Хэн гүтгэсэн юм бол? Хэн яг таныг ингээд гүтгэсэн гээд байгаа юм бол. Бас аягүй муухай байна шүү дээ. Би ч бишгүй гүтгэлгийн хонгилоор чирүүлсэн учраас гүтгүүлсэн хүмүүсийг харахаар бас зовлон нэгтэй юм шиг санагдаад байдаг юм.

Дахиад одоо та Улсын Их Хурлын дарга. Одоохондоо огцроогүй байна. Тэгэхээр өнөөдрийн, өчигдрийн процессыг та юу гэж харж байгаа вэ. Үндсэн хуулийн зөрчил мөн үү, биш үү? Үндсэн хуулийн 43.1-ээр бол Ерөнхий сайдыг огцруулах саналыг олонх нь дэмжсэнээр уг саналыг огцорсонд тооцно гэсэн ийм агуулга байгаа. 43.1. Өөрөөр хэлбэл Сайнзориг гишүүний бланк дээр бичигдсэн тэр зүйлээр санал хураах ёстой байсан гэж бид ойлгоод байгаа юм. Бас Дэгийн тухай хуулиар 101.3-д бүр цагаан дээр хараар биччихсэн. “Нэгдсэн хуралдаан нь Байнгын хорооны санал, дүгнэлтийг уншиж танилцуулна. Тэгээд нөгөө суурь буюу үндсэн асуудлаар санал хураана.” гэж байгаа юм. Ерөнхий сайдыг огцруулах. 101.3 ингээд би буруу уншаад байгаа юм уу эсвэл яагаад байгаа юм. Та энэ дээр яг Улсын Их Хурлын дарга гэдэг агуулгаараа хариу өгөөч ээ. Үндсэн хууль зөрчигдөж байгаа эсэх дээр.

Дахиад та бол яг өөрөө холбогдоогүй гээд тэгдэг л дээ. Би ч бас итгэж байна. Тэгэхээр бид нар чинь нэг хууль баталчихсан л даа Нийтийн ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль гээд нэг их урт нэртэй. Тэгээд тэр дээр чинь маш тодорхой биччихсэн байгаад байгаа байхгүй юу. Ах, эгч, дүү, төрсөн, анги хамт олны гишүүн ч билүү бараг. Тэр бүү хэл би сая шалгасан чинь .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Минутаа нэмж өгье.

Ж.Баярмаа: Холбоо, сан хамтын шийдвэр гаргадаг байгууллага, түүний гишүүд гээд бас заачихсан юм байна л даа. Тэгэхээр таны яриад байгаагаар тэр Чулуунзагд гээд хүн, тэр Эрдэнэжаргал гээд 2 хүн яг хэрэгт холбогдсон юм уу, холбогдоогүй юм уу? Холбогдсон та тодорхой хэмжээгээр энэ нийтийн ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар хамаарал бүхий этгээд бөгөөд ашиг сонирхол бүхий этгээд мөн юм уу, биш юм уу гээд.

Тэгээд нэг зүйл хэлмээр санагдаад байна. Энэ Платоны хэлсэн үг юм байна лээ л дээ. Хуулийн талаар. Ёс суртахуунтай, ёс зүйтэй хүмүүст бол хууль хэрэггүй гэж байгаа юм. Яагаад гэвэл тэртээ тэргүй тэд нар буруу зүйл хийхгүй. Ёс суртахуунгүй муу хүмүүст бол дахиад хууль хэрэггүй гэж байгаа юм. Яагаад гэвэл тэд нар тэртээ тэргүй зөрчинө. Тэгэхээр энэ үгийн дагуу бол энэ хууль ч юу ч болчихоод байгаа юм. Тэгээд Үндсэн хуулиа хүртэл зөрчөөд ингээд бид нар шийдвэр гаргачхаад явж байгаа юм биш биз дээ? Тэгээд Ардын нам бол Ардын нам биш авлигачдын нам болсон нь бол .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Амарбаясгалан дарга хариулъя.

Д.Амарбаясгалан: Тэр Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, чуулган удирдсан Булгантуяа дарга нар Үндсэн хуулийн зөрчилтэй эсэхтэй холбоотой асуудлаар мэдээж өөрсдийн тайлбаруудаа хийсэн байх. Би бол Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй гэдэг тайлбар, дүгнэлт гаргадаг субъект огт биш учраас би энэ дээр зөв, буруу гэж ярих нь илүүц гэж бодож байна.

Өмнөх өмнөх Засгийн газар, Ерөнхий сайд нар огцорсон тэр протокол, тэр тогтоол, бүх зүйл яг ижил ном журмаараа л өнөөдөр адилхан тогтоол гараад, хэлэлцэгдээд, батлагдаад л явж байна. Сүүлийн 3 Засгийн газар огцорсонтой холбоотой асуудал дээр 2 Засгийн газрынх нь Ерөнхий сайдынх нь асуудлыг Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэдгээр асуудал нь шийдэгдээд явсан. Нэг Засгийн газрынх нь огцорсон асуудал нь Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье буюу өнөөдрийн Засгийн газрыг огцруулж байгаатай холбоотой саналын томьёоллоор асуудал шийдэгдээд явсан.

Тэгэхээр энэ дээр бол их тийм хуулийн зөрчил гарчихсан гэж ойлгохгүй байна. Өглөө бас Ерөнхий нарийн бичгийн дарга албан ёсоор зөвлөмж өгч байх шиг байсан. 2 залууг л надтай холбоод байгаа юм. Ер нь холбоотой болгоод ер нь энэ нөхрөөр л дамжуулаад бариад авах юм сан л гэж их л үздэг юм шиг байна лээ. Тэгээд барьж аваачиж хорьж байгаад, сэгсрээд л олон талаас нь шалгаад л үзээд байх шиг байгаа юм. Харамсалтай нь ямар нэгэн санхүүгийн харилцаа байхгүй. Би түрүүнд хэлсэн. Урьд өмнө нь буюу одоогоос 14, 15 жилийн өмнө хамтраад 2 жил компани байгуулаад нэг бизнес хийх гэж үзээд дампуурчихсан, татан буугдчихсан компаниар хамаарал бүхий гэж орж ирж байгаа юм. Нөгөөдөх нь хамтдаа төрийн

бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн гээд явж байгааг нь хамаарал бүхий этгээд гээд оруулчхаж байгаа юм. Ийм 2 зүйлээр холбогдчихоод би өнөөдөр тэдгээр хүмүүсийн цаад талд байгаа хамаарал холбооснууд руу нь намайг чирч аваачиж л оруулаад байгаа шүү дээ. Түүнээс тэр бизнестэй нь холбогдоод, тэнчээнээс нь би санхүүжээд, тэндээс нь би цалин, орлого аваад явчихсан зүйл өнөөдрийг хүртэл нэгээхэн ч байхгүй ээ. Тийм учраас би өөртөө итгэлтэй би асуудалд холбогдож шалгагдаагүй гэдгээ тод илэрхийлж хэлж байгаа. Тэдгээр хүмүүсийг шалгаж байгаа асуудал нь намайг шалгаж байгаа гэсэн үг биш шүү дээ. Хувь хүмүүсийн асуудал гэж би ойлгож ингэж явж байна.

Гүтгэлэгтэй холбоотой асуудал байна. Би харин Тагнуулын байгууллагад өргөдөл, гомдол гаргачхаад жил гаруй болж байгаа юм. Хэн гүтгэж вэ гэдгийг тогтоож өгөөч гэдэг. Тэрнээсээ өмнө түрүүний шинжээчийн дүгнэлтийг надад гаргаж өгсөн байгаад байгаа юм. Энэ нь өөрөө ийм ийм, ийм ийм сайтуудад ингэж, ингэж мэдээлэл түгээдэг юм байна гээд. Тэгээд сайт руу нь орохоор та ч өөрөө ороод харахад хэдэн төгрөгөөр, хэдэн доллароор ямар хэмжээний мэдээллийг хэдэн сайтад түгээх вэ гэдэг нь өөрөө зүгээр ханштайгаа байж байдаг тийм л мэдээлэл түгээдэг сайт. Гол нь тэр сайтын үнэн, зөвийг батлахгүй гэдэг тийм үгтэй байж байдаг. Тэгэхээр энэ өөрөө хүний нэр төрд халддаг тийм том шугам line юм байна гэдгийг олж авсан. Харин хэн хийлгэсэн бэ гэдгийг манай Тагнуулын байгууллага бол одоо хүртэл надад тогтоож өгч чадаагүй байгаа. Би одоо харин тэр шинжээчийн дүгнэлтийг та бүхэнд хувилаад тараачихъя.

Тэгээд төгсгөлд нь би тайлбар хийгээд байгаа нь Их Хурлын даргаар үлдэх гээд тайлбар хийгээд байгаа зүйл биш шүү. Гишүүд маань бас асуулт асууж байгаа учраас, эргэлзээ байгаа учраас миний хувьд тайлбар хийж байна. Би өөрөө хүсэлтээ гаргасан. Улсын Их Хурлын гишүүдийг бас дэмжиж, энэ хүсэлтийг маань дэмжиж, шийдвэрлэж өгөхийг бас албан ёсоор хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Баярмаа гишүүнд нэмж тодруулъя.

Ж.Баярмаа: Та Улсын Их Хурлын даргаасаа огцрох нэг хэрэг, та гишүүнээсээ түдгэлзэж байгаад шалгуулах уу нэг.

Хоёрт, Ардын нам ч сууж байгаад л бид ч мөн булайгаа дэлгэж байна даа гээд л байна л даа. Тэгээд юу гэх вэ, ингэж булайгаа дэлгэлцэж сууж байхаар тарвал яасан юм. Тараад нэг их сайхан restart хийгээд ингээд явбал яасан юм гэж бүр санагдлаа сүүлдээ.

Дахиад нэг асуулт. Та 5 жил Ерөнхий сайдаар ажиллаад бүх Монгол Улсын индексүүдийг хойшоо ухраагаад, ардчилсан Монгол Улсыг авторитар дэглэмтэй болгосон Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрыг яагаад дэмжсэн юм. 5 жил болсон шүү. 125 их наяд төгрөг үрээд, 1 ч цахилгаан станц бариагүй. Өнөөдөр 3 сар болж байгаа Ерөнхий сайд Занданшатарыгаа та яагаад огцруулах гээд байгаа юм? Хувийн өш хонзон байгаа юм уу эсвэл? Зүгээр наад захын харьцуулахад 5 жил, 3 сар. Тэгээд 3 сар болсон хүнээс түрүүн Батболд гишүүн маш сайн асуусан л даа. Юу нэхээд байгаа юм бэ гээд .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя. Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүний ярьж байгаа зүйл дээр би хариулт тайлбар хийх боломжгүй зүйл байна. Ялангуяа 1 минутад багтаж яагаад вэ гэдгийг тайлбарлах тийм боломжгүй. Засгийн газар болгон өөрийн гэсэн онцлогтой, өөрийн гэсэн үлдээж байгаа өв, легаситай гэдгийг та бид мэднэ. Тэр болгон дээр өөр өөрийн итгэл үнэмшил, бодлого зорилгоор дэмжих, дэмжихгүй асуудлууд шийдэгдэж явж байдаг гэдгийг бас товчхон хэлчихье. Би гэмт хэрэг хийгээгүй учраас түдгэлзэж шалгуулах шаардлага байхгүй.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх хамтдаа байсан шүү. Санал хураалтад бэлтгэе. Орж ирээгүй гишүүд.

Нийт 114 гишүүнээс одоогийн байдлаар 104 гишүүн ирцэд орсон байна. Одоо бэлэн бус байгаа Баттулга гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Ж.Золжаргал гишүүн, С.Лүндэг гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, Б.Найдалаа гишүүн, М.Нарантуяа гишүүн, Н.Номтойбаяр гишүүн, Д.Пүрэвдаваа гишүүн, Ж.Чинбүрэн гишүүн.

Санал хураалтын томьёолол. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалангийн чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авах нь зүйтэй гэснийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Нийт 114 гишүүн оролцож, 102 гишүүн зөвшөөрч, 89.5 хувиар Д.Амарбаясгаланг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Дугаар Улаанбаатар хот.

Д.Амарбаясгаланг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, 12.3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.4.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Дашзэвгийн Амарбаясгаланг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Улсын Их Хурлын даргын албан үүргийг хэрэгжүүлж байхыг Улсын Их Хурлын дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяад даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан. Тогтоолыг баталсанд тооцлоо.

Тогтоолын найруулгатай холбоотой ямарваа нэгэн санал байхгүй байх. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Одоо та бүхний өмнө Монгол Улсын Их Хурлын 13 дахь дарга өөрөөр хэлбэл өнөөдөр Засгийн газрын тэргүүн 34 дэх нь явж байгаа. Манай парламент бол их тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, илүү дархлаатай газар. Тийм учраас энэ өнөөдрийн 13 дахь Их Хурлын даргаар ажилласан Дашзэвгийн Амарбаясгалан таныг индэрт үг хэлэхийг урьж байна.

Д.Амарбаясгалан: Ардчилсан Монгол Улсын ард иргэд ээ, Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн эрх мэдлийн эх ундарга бол Монголын ард түмэн байсаар ирсэн. Тиймээс ч Үндсэн хуульд Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэж заасан байдаг.

Улсын Их Хурлын гишүүн бид ард түмний элч болж, тэдний нэрийн өмнөөс засаглах эрхийн төлөөллийг хэрэгжүүлдэг. Бидэнд эрхэмлэвэл зохих ганц л ашиг сонирхол байдаг. Тэр нь Үндсэн хуульд зааснаар нийт иргэн, улсын ашиг сонирхол юм. Гэвч сүүлийн өдрүүдэд үүнийгээ умартаж, хэсэг бүлэглэлийн амин хувиа хичээсэн санаа, гүйцэтгэх эрх мэдлийн сонирхолд дулдуйдсан үзэгдэл парламентын танхимд газар авч, хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдлийн хяналт тэнцэл алдагдаж байна. Энэ байдлаа парламентыг удирдаж байгаа даргаас болж буй мэт харагдуулах зорилгоор намайг хүн амины ноцтой гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх, хань ижил, гэр бүлийн хүмүүсийг маань маш их хэмжээний мөнгө гадаадаас авсан мэтээр хуурамч мэдээлэл тараах зэргээр хүний ёсноос гажууд хуулиас давсан авир, үйлдэл гаргаж, дарамт шахалт үзүүлсэнд туйлын ихээр харамсаж байна. Намайг Улсын Их Хурлын даргын албан тушаалд байгаа учраас шалгуулахгүй байгаа мэтээр олон нийтийг төөрөгдүүлсээр ирсэн. Өнөөдрийг хүртэл надад хийсэн хэрэг, гэм зэм байхгүй гэдгийг хариуцлагатайгаар хэлэхийг хүсэж байна.

Парламентад ардчилсан зарчим, хамтын шийдвэр чухал. Тиймээс би олонхын санаа бодолд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ парламентын институтын тогтвортой байдлыг хангах шаардлагатай гэж үзэн өөрөө чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан юм. Цаашид над руу чиглэсэн гүтгэлэг, хуурамч мэдээлэл, эргэлзээ бүрийг бүрэн эцэслэж, нэр төрөө хуулийн дагуу сэргээх болно гэдгээ мэдэгдье.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын даргын ажлыг хийхдээ би үзэл бодлоо ил тод, тов тодорхой илэрхийлж, 3 төгөлдөршилийн үзэл санааг дэвшүүлж, хэрэгжүүлж ирлээ. Олонхын бүлгээс санал болгож, Улсын Их Хурлын даргаар сонгогдож ажилласан хэдий ч Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бусад нам, эвслийн оролцоог бүрэн дүүрэн, ижил, тэгш хангаж ажиллаж ирснийг цохон тэмдэглэж хэлье. Учир нь Үндсэн

хуульд 2023 онд оруулсан өөрчлөлтийн дагуу Монгол Улсын 126 гишүүнтэй анхны парламентад зөв соёл, ажиллах орчин бий болгох нь парламентын цаашдын хөгжилд чухал гэж үзсэнтэй холбоотой юм.

Улсын Их Хурлын даргын хувьд парламентыг олон ургалч үзэлд тулгуурлах, ил тод, нээлттэй байх, хүн төвтэй ойлголцол, зөвшилцлийг баримтлахад нэн тэргүүнд анхаарч ажиллаж ирлээ. Цаашид парламентын засаглалыг бодит утгаар нь баталгаажуулахад байнга анхааран та бүхэнтэйгээ хамтарч ажиллах болно.

Бид жил гаруй бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, төсөв хэлэлцэх дэгд өөрчлөлт орж Улсын Их Хурал илүү цомхон бүтэцтэй болж чадсан.

Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд Улсын Их Хурал нэгэн бүрийн эрхийн хугацаандаа баримтлах хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санаа бүхий алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлээ нэгтгэн тодорхойлж чадсан юм. Цаашид энэ стратеги төлөвлөгөөнд заасан ил тод, нээлттэй үйл ажиллагаа явуулан иргэдийн санал бодлыг сонсож, эрх, хууль ёсны, ашиг сонирхол нь хөндөгдсөн талуудын тэгш оролцоог хангах зорилт хэрэгжих ёстой гэж үзэж байна.

Шинээр бүрдсэн парламентын ажлыг оновчтой зохион байгуулах зорилгоор Улсын Их Хурлын даргын хувьд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд гишүүдийн санал бодлыг харгалзан, мөн зарим гишүүдэд тухайлан итгэл хүлээлгэн ачаа үүрүүлж, 60 гаруй ажлын хэсгүүдэд хуваарилан ажиллуулсан нь үүний үр дүн гарч, ойрын ирээдүйд хууль тогтоомжуудын чанар эрс сайжирна гэдэгт итгэлтэй байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр төр төвтэй хуулиас хүн төвтэй хууль руу шилжих, хуулиас давсан журмыг цэгцлэх, хууль ба журмын зохист харьцааг хангах эрх зүйн үндсийг Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар бий болгож чадсан. Журам батлах нэрийдлээр хуулиар тогтоосон иргэний эрх зүйн байдлыг дордуулдаг явдал цаашид үгүй болох ёстой. Мөн хүний эрхийн зөрчилтэй олон мянган журам цэгцрэх ёстой. Энэ хуультай хамт баталсан “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа бүх хуулийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэхийг даалгаж, холбогдох хуулийн төслийг 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан. Энэ ажил нь энэ удаагийн парламентын хийх эрхэм чухал үүрэг юм гэдгийг цохон тэмдэглэж хэлье. Эдгээр бодлого, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр хууль тогтоомж, эрх мэдлийг гагцхүү Их Хурал хадгалагдана гэсэн Үндсэн хуулийн заалт бүрэн утгаар биеллээ олно гэдгийг хэлье. Энэ чуулганаас эхлэн Улсын Их Хурал цомхон, шинэ бүтэцтэй ажиллахаар болсон. Байнгын хороодын тоог цөөлж, дэд хороодын тоог нэмэгдүүлснээр илүү мэргэжлийн түвшинд ажиллах нөхцөл парламентад бүрдсэн.

Шинэтгэл хийсэн бас нэг асуудал төсвийн хэлэлцүүлэг болж чадсан. Төсвийн хэлэлцүүлгийг 5 үе шаттай хэлэлцдэг болсноор Улсын Их Хурлын гишүүд

төсөвтэйгөө өргөн хүрээнд танилцаж, иргэд, сонгогчдын дунд хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах боломж нээлттэй болсон. Цаашлаад улсын төсөв батлагдахдаа илүү бодитой, илүү амьдралд нийцсэн төсөв болох нөхцөл нь бүрэн хангагдаж дээ.

Парламентыг илүү нээлттэй, иргэддээ ойр байлгах зорилгоор Нээлттэй парламент хөтөлбөрийг бид хэрэгжүүлж эхэлсэн. Цаашдаа парламентын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгаж, иргэдийн оролцоог бүрэн хангаж чадсанаар парламентын үйл ажиллагаа олон нийтийн дунд бодитой үнэлэгдэх тэр нөхцөл суурь нь тавигдана гэж үздэг юм. Өнөөдрийг хүртэл парламентын үйл ажиллагааг олон нийтийн зүгээс шууд утгаар нь бүрэн дүгнэж чаддаггүй, парламентын үйл ажиллагаа олон нийтийн дунд өндөр хэмжээнд үнэлэгдэж чаддаггүй явж ирсэн энэ нөхцөл байдал үүгээр засагдана гэж миний зүгээс үзэж ажилласан гэдгийг та бүхэндээ хэлье.

Улсын Их Хурлын даргын албан тушаалыг өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ өчигдөр би Улсын Их Хуралд гаргасан. Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хороо, өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар орж, асуудал одоо эцэслэн шийдэгдлээ. Миний хүсэлтийг хүлээн авч дэмжсэн Улсын Их Хурлын гишүүддээ чин сэтгэлийн талархлыг дэвшүүлье. Миний хувьд улс төрчийн хувьд энэ шийдвэр улс төрийн төгсгөл биш, шинэ эхлэл байна гэдгийг би албан ёсоор хэлэхийг хүсэж байна.

Миний хувьд парламентын засаглалын дархлааг бэхжүүлэх баталгааг улам бүр баталгаажуулж, Монголын ардчиллын хатуу хана хэрэм байх тэр нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө цаашдаа тууштай тэмцэнэ гэдгийг та бүхэндээ хэлэхийг хүсэж байна. Монгол Улсын парламентын засаглал өнө мөнхөд оршиж, Монгол Улсын ардчилал бүрэн баталгаатай байх тэр цаг үе, ирээдүйн төлөө тууштай зүтгэнэ гэдгийг та бүхэндээ илэрхийлэхийг хүсэж байна. Баярлалаа та бүхэнд.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Өнөөдрийн Засгийн газар болон Их Хурлын дарга огцорсонтой холбоотойгоор би нэг үг хэлчихье. Тэгэхээр өнгөрсөн 9 жилийн туршид энэ сөрөг хүчнийхээ үүргийг хангалттай бүрэн биелүүллээ. 5 удаагийн Засгийн газар огцруулах асуудал орж ирж, түүний 1 дээр нь огцруулах санал өгсөн боловч Хүрэлсүхийн Засгийн газар үлдсэн байгаа. Эрдэнэбатын Засгийн газар, Хүрэлсүхийн Засгийн газар, Оюун-Эрдэнийн Засгийн газар, Занданшатарын Засгийн газар 4 Засгийн газрыг огцруулж, Миеэгомбын Энхболд, Дашзэгвийн Амарбаясгалан гэдэг 2 Их Хурлын даргыг огцруулсан ийм өвөрмөц амжилтыг энэ сөрөг хүчнийхээ хувьд гаргалаа. Ингээд ер нь ажлаа сайн хийх юм бол бидний хувьд энэ 28 онд амжилт байгаа гэдгийг гишүүддээ хэлье.

Та бүхэнд бас нэг зүйлийг анхааруулж байна. Ардын намын бүлэг 31, 37-гоор хуваагдчихсан, 2 Бүлгийн даргатай болчихсон байгаа. Та нар маш хурдан Бүлгийнхээ даргын асуудлыг шийдвэрлэж орж ирэх хэрэгтэй. Өнөөдөр энэ асуудлыг сүүлд нь ярилцана.

Дараагийнхаа асуудалд оръё. Булгантуяа нааш ир. Энэ суудал дээр нэг их суугаад байх юм байхгүй, энэ чинь ингээд л сайхан эвтэйхэн удирдаад явчхаж болно Булгантуяа минь.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилэв/

Х.Булгантуяа: Дараагийн асуудалдаа оръё. Гурав дахь асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Байнгын хороодоос саналаар санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 1 саналын санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх гэж байна. Зарчмын зөрүүтэй 1 саналын томъёолол, Мөнхтуяа гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй 1 саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энэ бол цаг хугацаатай асуудал. Ерөнхий сайд Занданшатар үргэлжлүүлэн үүрэг гүйцэтгэгчээр ажиллахаар түрүүн бид тогтоолын төслийг баталсныг уншиж та бүхэнд танилцуулсан.

Тийм учраас бид цагтаа Улсын Их Хурал төсвөө батлуулах үүрэгтэй байгаа. Тийм учраас бид төсвийн хүрээний, одоо бол төсвийн хүрээний мэдэгдэл шүү дээ. Тийм, төсвийн хүрээний мэдэгдэл. Зарчмын зөрүүтэй 1 саналын томъёолол байгаа. Улсын Их Хурлын гишүүд, гишүүд хуруугаа уншуулъя. Гишүүд хуруугаа уншуулж, санал хураалтын бэлэн байдалдаа ормоор байна. Гаргасан саналын томъёоллыг та бүгдэд танилцуулъя. Төсвийн болон Эдийн засгийн хамтарсан байнгын хороон дээр дэмжээгүй санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31,6 их наяд төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32 их наяд 980 тэрбум төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьд өөрчлөлт оруулах гэдэг саналыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр гаргасан нь дэмжигдээгүй санал байна. Тэгэхээр нэгдсэн, дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Энэ санал ингэсэн юм байна шүү Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн болон Эдийн засгийн хамтарсан байнгын хорооны хуралдаанаар бас дэмжээгүй. Ийм саналыг, дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүдийн 56.1 хувь нь энэ саналыг дэмжээгүй байгаа.

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганхуяг даргын саналыг дэмжсэнээр тооцъё.

Өмнөх нэгдсэн чуулган дээр уг нь үүн дээр тайлбар хэлсэн юм Улсын Их Хурлын Тамгын газраас. Тамгын газраас та бүхэн маань дахиад хэлээдхээч, горимоороо Байнгын хорооны дарга энэ дээр нэмэлт тайлбар өгөх боломжгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр, 2 номерын микрофон дээрээс хэлэх үү? 2 номерын микрофон.

Ч.Дондогмаа: Улсын Их Хурлын Тамгын газар. Үндсэн хуулийн заалтыг уншиж танилцуулъя. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д Улсын Их Хурал улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гэж заасан. Тэгэхээр энэ саналаар зарлагын хэмжээ нэмэгдэхээр байгаа.

Х.Булгантуяа: Ганхуяг гишүүнийх, Ганхүлэг гишүүн. Ганхүлэг гишүүний микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Санал хураалтыг дахин явуулж өгөхийг хүсье. Тодорхой дутуу мэдээлэл авсантай холбогдолтой гишүүд буруу, зөрүү ойлголтууд авсан байх магадлалтай байна. Миний хувьд ч гэсэндээ санал хураалтыг дахин явуулж өгөх ийм саналтай байна. Санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: Мөнхтуяа гишүүнээ дэгээрээ ийм юм байна. Саяын санал хураалтаас өмнө үг хэлж болохоор байсан байна санал гаргасан гишүүн. Одоо сая санал хураалт явагдчихсан. Тэгэхээр санал хураалт дээр Ганхүлэг гишүүн дахин санал хураалт явуулж өгөх горимын санал гаргасан байна. Тиймээс саяын санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулна уу гэдэг санал хураалт. Саяын санал хураалтыг эхлээд хүчингүйд тооцох санал хураалт. Санал хураалт.

Ганхүлэг гишүүний горимын санал дэмжигдсэнгүй. Тиймээс Мөнхтуяа гишүүний гаргасан санал тэгэхээр дэмжигдсэн байна гэсэн үг.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

16.08 цаг

Дөрөв. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2025.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилэв/

Дөрөвдүгээр асуудалдаа оръё. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүд Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Эдийн засгийн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд дахин санал хураалтад бэлдэнэ үү. Энэ материал нь тараагдаад, хэлэлцүүлэг нь явагдаад, гишүүд асуулт асуугаад, үг хэлээд дууссан. Санал хураалт л үлдсэн байсан. Тийм, санал хураалт л одоо, бүр төслийг нь батална шүү дээ. Тогтоолын төслийг нь батална. Саналын томьёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдээ энэ эцэслэн батлах учраас ирц өндөр байх ёстой, санал өндөр байх ёстой тогтоол учраас.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

72 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархаж байна.

16.11 цаг

Тав.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилэв/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэгдүгээр хэлэлцүүлгийг 9 сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд 4, 5 хоногийн хугацаанд бараг явуулсан байна. Ингээд салбар салбарын хэлэлцүүлгүүдийг Төсвийн байнгын хорооноос явуулсан.

Одоо төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны

төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 15, 18, 19, 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд Улсын Их Хурал төсвийн төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн үед олон нийтийн хэлэлцүүлэг хийж болно гэж заасны дагуу Төсвийн байнгын хорооноос Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж, эрсдэл, Боловсролын салбарын 2026 оны төсөв, Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүд, Төсвийн орлого бүрдүүлэлт, Эрүүл мэнд, нийгэм хамгааллын 2026 оны төсөв, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын 2026 оны төсөв гэсэн 6 сэдвийн хүрээнд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Дээрх хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газар, Сангийн яам, төсвийн ерөнхийлөн захирагчид, төрийн бус байгууллагаас давхардсан тоогоор 394, цахимаар 17 төлөөлөл оролцсон бөгөөд хэлэлцүүлгийн зарыг Улсын Их Хурлын албан ёсны веб хуудас parliament.mn дээр, цахим хуудас parliament.mn хаягуудад байршуулж, олон нийтийн оролцоог ханган ажилласан.

Хэлэлцүүлэгт оролцогчдоос эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлэх, багш, эмчийн цалин, ахмад настны тэтгэврийн хэмжээг нь инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг урт хугацааны хөгжлийн бодлогын зорилттой уялдуулах, гадаадын зээл, тусламжийн ашиглалт, түүний үр дүнг үнэлж, өрийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх, татварын шинэчлэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдийн татварын дэмжлэгийг оновчтой болгож, өрхийн орлогыг дэмжихэд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналууд гаргасан.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгын талаар:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Анар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан Батлан хамгаалахын сайдын 2026 оны хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох зохицуулалттай нийцэхгүй байгааг анхаарах, нууцад хамаарах төсөл, хөтөлбөрөөс бусад нийгмийн шинж чанартай арга хэмжээний задаргааг төсөлд тусгах шаардлагатай талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Мөнхбат нар орон нутаг дахь зэвсэгт хүчний анги, салбаруудад тусгай сургалт, бэлтгэлийн төвийн барилгын засвар болон албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах хөрөнгийг төсвийн төсөлд тусгасан эсэх, улсын төсвөөс санхүүжилт авдаггүй аймаг, сумд хөрөнгө мөнгөний хүрэлцээгүй байдал үүсэж байгаа талаар зохицуулах, дээрх хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд дэлхий нийтийн тогтворгүй нөхцөл байдлаас үүдэн батлан хамгаалах салбар, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, гал, ус, зуд зэрэг байгалийн гамшгийн үед батлан хамгаалах, онцгой байдлын салбарт бэлэн байх.

Мөн иргэдийн чадавхжуулан сурахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Болормаа гадаад харилцааны салбар болон батлан хамгаалах салбарын ажиллагсдын цалин хангамж, ажиллаж, амьдрах нөхцөлийг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртгүүд нэмэгдэж байгаад анхаарч, шалтгааныг тодруулах нь зүйтэй бөгөөд 2026 онд төсвийг үр дүнтэй захиран зарцуулах талаар санал хэлсэн байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгын талаар:

Улсын Их Хурлын гишүүн Батчимэг, Идэрбат нар хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд олгож байгаа зээлийн ашиглалтыг сайжруулах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах болон цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээний зардлыг улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд ашиглаж байгаа тоног, төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодруулж, хувийн хэвшлээр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг улсын төсөвт тусган санхүүжүүлэх шаардлагагүй гэсэн саналуудыг хэлсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгын талаар:

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл Шинэ хоршоо хөтөлбөрийн үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Номин, Бадамсүрэн нар төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь улсын хөгжлийн төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа 2026 онд төсвийн төсөлд төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог 36 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн тэтгэмжийг он дамжуулан олгохоор туссан нь холбогдох хуульд нийцэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Саранчулуун, Бадамсүрэн, Болормаа нар төсвийн бодлогыг эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлуудад чиглүүлэх, тухайн жилийн төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах процессыг шинэчлэх, төрийн албаны шалгалтын агуулгад хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудлыг тусгах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар саналуудыг хэлсэн байна.

Хууль зүйн байнгын хорооны танилцуулгын талаар:

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Алтангэрэл, Сандаг-Очир, Мөнхбаатар, Дамдины Цогтбаатар нар иргэдийн амар тайван, аюулгүй байдлын төлөө үйл ажиллагаа явуулдаг хууль зүйн салбарын байгууллагуудын төсвийг бусад салбартай адилтган нийтлэг байдлаар бууруулах нь тохиромжгүй бөгөөд тухайн салбарын байгууллагуудын орон тоо дутуу байгааг анхаарч, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай талаар, мөн донтолттой тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх төсвийг анхаарах.

Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгын талаар:

Тус хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн Засгийн газрын төсөв эдийн засгийн бодлогыг боловсруулахад шаардлагатай санал, тулгамдаж байгаа асуудлыг тухай бүр холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлдэг байх, Улсын Их Хурлын гишүүн Шижир төсвийн урсгал зардал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн боловч багш, эмч нарын цалин, ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахгүй байгаа талаар, Их Хурлын гишүүн Очирбат мега төслүүдийг эрчимжүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг инфляцтай уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж 2026 оны төсөвт говийн бүсийн усжуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах хөрөнгийг нь тусгах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан байна.

Өргөдлийн байнгын хорооны танилцуулгын талаар:

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат төсвийн урсгал зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байх хязгаарыг өөрчлөн боловсрол, эрүүл мэндийн салбарын санхүүжилт, ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц Улсын хөгжлийн төлөвлөгөө болон төсвийн төслийн шалгуур үзүүлэлтүүд хоорондоо уялдахгүй байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа Засгийн газраас 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласан боловч Боловсролын сайдын төсвийг 1 их наяд төгрөгөөр бууруулахаар төсвийн төсөлд тусгасан нь 300 мянган хүүхдийн эрх ашиг зөрчигдөж, 16 мянган багш, ажилчдын цалин хөлс буурч байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл 2026 онд хэрэгжиж дуусах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, улсын төсвийн урсгал зардлыг 24-өөр хязгаарласныг нэмэгдүүлэх боломжийг судлах, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн суурь салбаруудыг санхүүжүүлэхэд Сангийн яам анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгын талаар:

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат ирэх оны төсөв эрүүл мэндийн салбарын техник тоног, төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгө оруулалт туссан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгосонтой холбогдуулан хөдөө орон нутагт шаардлагатай сургууль, цэцэрлэгийн барилгын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, орон нутагт мэргэжлийн багш дутагдалтай эсэх талаар асуулт асууж, холбогдох хариултыг авсан байна. Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлж буй соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын төсвийг хассан талаар, тус салбарын төсвийн бууруулсныг нэмэгдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг 2026 онд ахмадуудын эрүүл мэнд, соёл, спорт, насан туршийн боловсролд зориулсан арга хэмжээний зардал болон Боловсролыг дэмжих

жилийн хүрээнд хийгдэх ажил, хүрэх үр дүн, Боловсролын зээлийн сангийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтийн талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Улсын Их Хурлын гишүүн Батжаргал төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлаж, цалин хөлс, тэтгэвэр, урсгал зардлын зарцуулалт болон 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй барилга байгууламжуудыг дуусгах боломжийг судлах, хөрөнгө оруулалтын бодит хэрэгцээ, үлдсэн ажлуудын санхүүжилтийг оновчтой хуваарилах, хувийн хэвшлийн төлбөрийн чадамжийг хамгаалах чиглэлээр зохицуулалт хийх, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат төрийн албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлийг урт болон дунд хугацааны бодлогоор шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 2024 оны Засгийн газрын санхүүгийн тайланд аудитын байгууллагаас илрүүлсэн зөрчил, алдаа дутагдлын хариуцлагын асуудлыг тодруулж, холбогдох албан тушаалтнуудад ямар арга хэмжээ авсан, мөн аудитын дүгнэлтийн хэрэгжилт, зөвлөмжийн биелэлтийг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл төсвийн шинэчлэлийг хийх шаардлагатайг онцлон, ирэх онд төрийн албан хаагч, ялангуяа багш нарын цалинг нэмэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт нэмж тусгах боломжийн талаар асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хороонд танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхэнд хүсэж байна.

Х.Булгантуяа: Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Улсын Их Хурлын гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт. 1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, гишүүд санал хураалтад бэлтгэсэн байдлыг одоохон хараадахъя. 73. Санал хураалт бэлтгэе.

Санал 1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 63.2 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлж байна.

16.25 цаг

Зургаа.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Зургаадугаар асуудалд оръё. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 2 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Хуулийн төсөл болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүдэд дараах агуулгатай нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгалаа. Үүнд:

1.Айл өрх, иргэдийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах, орлогын тэгш бус байдлыг бууруулах, бизнесийн идэвхжилийг дэмжих, татварын хамрагдалтыг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл батлагдсанаар нийт иргэдийн 75 хүртэлх хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвараас 50-100 хувь хөнгөлөгдөх юм

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн процесс ажиллагааг багасгах, түншлэлийн хүрээг тэлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтод нийцүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд түншлэлийн төслийг бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

3.Өрийн удирдлагын стратегийн хэрэгжүүлэх зорилгоор 2026 оны төсвийн жилд арилжаалах гадаад болон дотоод үнэт цаасны дээд хэмжээ, зориулалтыг

тусгасан Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулан, орд ашиглалтыг сайжруулах зорилгоор “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсрууллаа.

Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулж, өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярт танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Батбаяр: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Төсөл санаачлагч иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, бодит орлогыг хамгаалах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг оновчтой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, татварын хамрагдалтыг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн процесс ажиллагааг хялбарчлах, түншлэлийн хүрээг тэлж, нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээнээс гадна, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтод нийцсэн төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд түншлэлийн төслийг бие даан хэрэгжүүлэх боломжоор тэгш хангах, түншлэлийн төсөлд тавигдах шаардлагыг багасгаж, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 2026 оны төсвийн жилд арилжаалах гадаад болон дотоод үнэт цаасны дээд хэмжээ, зориулалтыг тусгасан “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиглалтыг сайжруулах зорилгоор “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар ирэх оны төсвийн орлого бүрдүүлэлтэд тусгагдсан алт, зэс, нүүрсний биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрэх боломжтой эсэх болон үнийн тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжлийн бодлого, зорилтод тусгагдсан томоохон

ямар төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан, төр, хувийн хэвшлийн түншлэлд олгох зөвшөөрлийн асуудал нь ирэх жилүүдийн хөгжлийн бодлого, төсвийн орлого, зардалд үзүүлэх нөлөөллийн талаар болон Тавантолгойн ашиглагдаагүй ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад хувийн хэвшлийг оролцуулах зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн төсвийн төсөлд төсвийн бодлогоо хэрхэн төлөвлөсөн талаар тодруулж, цаашид инфляцыг бодит нөхцөлд нийцүүлэн тооцох, мөн татварын суурь шинэчлэлийг хийж, хувийн хэвшлийг дэмжсэн, эдийн засгийн идэвхилийг сайжруулах бодлогын өөрчлөлтүүдийг төсвийн төсөлд тусгах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдаваа 2026 онд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэр, байршил болон сонгон шалгаруулалтын талаар тодруулж, цаашид ашиггүй ажиллаж байгаа төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тоог бууруулж, үйл ажиллагааг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, танилцуулга хоёрын агуулга нь зөрүүтэйгээс гадна, төсөвт шууд үзүүлэх нөлөөлөл багатай тул хэлэлцэхгүй байх, мөн Татварын хуулийн өөрчлөлтөд татвар ногдуулалт, хураалт, буцаалт, олголттой холбоотой асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн процесс ажиллагааг хөнгөвчилсөн хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд Засгийн газрын 2025 оны 54 дүгээр, 55 дугаар тогтоолын дагуу энэ оны 8, 9 дүгээр сард борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого болон хөнгөлөлтийн талаар тодруулж, харин “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1, 2 дахь заалтад тусгагдсан зохицуулалтуудыг дахин нягталж, сайжруулах нь зүйтэй талаар, “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолоор өрийн удирдлагыг зохицуулах, дахин санхүүжүүлэх зорилготой 1 тэрбум ам.долларын дотоод үнэт цаасыг арилжаалахтай холбоотой асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Батбаяр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэхээр тусгасантай холбогдуудан худалдан авалтуудыг бүртгэх судалгаа бүрэн хийгдсэн эсэх, мөн энэ хууль хэрэгжсэнээр иргэдэд очих урамшуулал, нэмэгдэл болон аж ахуйн нэгжүүдэд үүсэх дарамтын талаарх судалгаа байгаа эсэх, мөн нэмэгдсэн өртгийн албан татвараас орох орлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг өртгийн албан, төр, хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулалтын ажил нэмэгдсэнээр улсын болон орон нутгийн төсвийн урсгал зардалд тодорхой хязгаарлалт тавиагүй нөхцөлд төсөвт нэмэгдэх ачааллыг хэрхэн тооцсон талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн судалгаа хангалтгүй, мөн үр ашгийн тооцоо бүрэн хийгдээгүй байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Түвшин нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олголтоор хөнгөлөлт үзүүлэхээс илүүтэйгээр нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хувийг бууруулах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төмрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Батболдын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Монхоогийн Амгаланбаатар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал, Баатарсүрэнгийн Батсайхан Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нийтдээ 17 гишүүний нэр ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн, одоо энэ ирцээрээ орчихсон байгаа юу? Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Өчигдөр ч баахан биднийг ажлаа хийдэггүй гээд л тойргоос сонгогдсон гишүүд дээр нэлээн л хүнд тусаж, баахан л баалууллаа. Тэгээд энэ хурал удирдаж байгаа Булгантуяа дарга одоо нэгэнт асуудал шийдэгдээд, тэртээ тэргүй хоёулаа огцроод явчихлаа. Тэгээд санаа амарсан бол энэ байгаа гишүүдээсээ нэг уучлалт гуйчихвал яадаг юм бэ. Өчигдөр олон давтаж, нэлээн л баалж янз бүр боллоо.

Би Эдийн засаг, хөгжлийн сайдаас л асуух гээд байгаа юм. Нөгөө Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль маань яг энэ дагаж орж ирээд, дагаж батлагдаад, шийдэгдээд ирэх жил одоо яг тэр 26 оны хөгжлийн төлөвлөгөөнд, улсын төсөвт, хөгжлийн төлөвлөгөөнд орчихсон хэр нь улсын төсөвт орж амжаагүй ажлууд яг хийгдэхэд цаг хугацааны хувьд амжих уу? Энэ хууль батлагдан гараад яг хэзээнээс хэрэгжиж эхэлнэ гэж тооцож байгаа юм бэ? Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ хуулийг яг бодит амьдрал дээр хэрэгжүүлээд явахад хувийн хэвшилд уг нь нөөц байгаа гэж харж байгаа. Тэгэхдээ ирэх жилийн эдийн засгийн нөхцөл байдал ямар байгаа юм бэ? Хувийн хэвшил маань ийм Засаг төр тогтворгүй, олон улсын байдал ийм хүнд хэцүү, Монголыг ганц тэжээж байгаа энэ нүүрсний экспорт нь эрсдэлд орчихсон ийм нөхцөлд хувийн хэвшил төртэй хамтарч, төртэй түншилж ажил хийх үү? Тэгэхээр ер нь энэ хуулийнхаа өөрчлөлтийг хэр сайн бодож тооцоолж орж ирсэн юм бэ? Энэ дээр нэг Учрал сайд сайн хэлж өгөөч.

Би энэ улс хийж чадахгүй байгаа ажлаа энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгээд явмаар байна гэдэг ийм саналтай байгаа. Энэ саналыг л гишүүд маань маш сайн дэмжиж, хувийн хэвшилд байгаа боломжоо ашиглаж, энэ улс орныхоо бүтээн байгуулалтыг хиймээр байна. Хөдөө орон нутагт маш их хийх ажил байна. Бид одоо энд ингээд сандал суудал ярьж, хэрүүл уруул хийж суусаар байтал хөдөө орон нутгийн хөгжил олигтой хийсэн бүтээсэн юм алга, ард иргэдийн ажил, амьдрал улам дордож байна. Өвөл хүнд болж эхэлж байна, бензин тосны хангамж тасалдаж эхэлж байна гэж байна. Тэгээд энэ бүхнийг ер нь тооцож байгаа юу? Тэгээд ирэх жил хувийн хэвшилдээ яг үнэхээр боломж олгоод ингээд явах уу? Яагаад гэхээр зэрэг хувийн хэвшил чинь одоо энэ бидний батлах гэж байгаа төсвийг, мөн дагаж орж ирж байгаа энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг хараад, ирэх жилийнхээ бизнес төлөвлөгөөг гаргах гээд, ажил, амьдралаа зохицуулах гээд сууж байна. Гэтэл бид одоо энд ингээд шал өөр юм яриад суугаад байдаг. Тийм учраас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр гишүүд маань ч гэсэндээ онцгой анхаарч ажиллаарай гэж ингэж хүсэх гэсэн юм. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн сайдаас энэ хуулийн талаар нэлээн тийм сайн хариулт авах хүсэлтэй байна.

Х.Булгантуяа: Хосбаяр гишүүний асуултад Учрал сайд хариулъя. Учрал сайд хариулахын өмнө би бас манай Улсын Их Хурлын эрхэм гишүүд бид сая цаг хугацаатай, Үндсэн хуулийн цаг хугацаатай асуудлыг хэлэлцэх гээд зарим гишүүд маань өглөөний 8 хагасаас авхуулаад Төрийн байгуулалтын байнгын хороо дээрээ ирцдээ ороод ингээд явж байсан. Шөнөжин, өдөржин хуралдаад, бас нэлээдгүй амаргүй цаг үе байлаа. Тэгээд та бүгдийг чуулгандаа орооч гээд нэрийг нь дуудаад, улс орон даяар ингээд дуудах хүртэл, би Улсын Их Хурлын дэг дээр чинь дэгийг сахиулах, чуулганы энэ ирцийг бүрдүүл гэж шахах, дэгийг сахиулах ийм үүрэгтэй юм байна. Энэ хэцүү юм байна, ийм амаргүй чуулган хуралдуулна, даргална гэдэг их амаргүй юм байна. Би сая ямар сайндаа Монгол Улсын Ерөнхий сайдаар ингээд ажилласан Занданшатар дарга бол өнгөрсөн парламентад Улсын Их Хурлын даргаар ажиллаж байсан. Өнөөдрийн Үндсэн хуулийн 2 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг өлгийдөж авч, 126 гишүүнтэй парламент болоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Тэгээд би бол хувь хүнийхээ хувьд ийм хэцүү хурал даргалсанд, ийм санал эндээс гарсанд хүлцэл өчиж байна гэдгийг хүртэл хүмүүс янз янзаар л хүлээж авч байх шиг байна.

Тэгэхдээ бас одоо та бүгдээс чуулганыхаа дэгийг сахиулах гэж та бүгдээс ингээд дуудаж, ирцдээ орно уу гэж шахаж, эвгүй байдалд оруулсан бол та бүгдээс хүлцэл өчье. Энэ дэг сахиулна гэдэг бол хэцүү юм байна. Тэгээд бид 126 гишүүнтэй болсон чинь бүр их хатуу дэгтэй болчихож. Хуучин горимын саналыг хэзээ ч гаргадаг, өглөө орж ирээд л гишүүд олон асуудлуудаар саналаа хэлдэг, 76 гишүүнтэй байхад арай энгийн, амар дэгтэй байсан. Манай Пүрэвдорж дарга сайн мэдэж байгаа тэр үеийн дэгийг. Саяын Хосбаяр гишүүний асуултад хариулна уу гэж Учрал сайд.

Н.Учрал: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Мэдээж сайн мэдээ олон улсын Moody's агентлаг зээлжих зэрэглэлийг B2-оос B1 болгон ахиулж, урт хугацааны төлөвийг тогтвортой хэвээр хадгаллаа гэдгээ өнгөрсөн өдрүүдэд зарлалаа. Зээлжих зэрэглэл сэргэсэн, валютын нөөц 5.8 тэрбум долларт хүрсэн сайн мэдээнүүд байгаа. Экспорт ч гэсэн 1.7 дахин нэмэгдсэн. Хил, гааль дээр үүсээд байгаа асуудлуудыг Засгийн газар шийдвэрлэхээр богинохон хугацаанд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Та бидний баталсан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт 126 төсөл байсан. Энэ 126 төслийн 60 хувь буюу 76 төсөл нь улсын төсвийн төсөлд суусан байгаа. Үлдсэн 50 төслийг төсвөөс санхүүжүүлэх бололцоо байгаагүй. Тийм учраас бид улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан энэ 50 төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулъя гэж төлөвлөсөн. Тийм учраас жилийн төлөвлөгөөнд энэ удаагийн төсөв нийцэж байгаа. Энэ 50 төслийг явуулъя гэхээр өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн шалгуурууд, шаардлагууд их хэт их өндөр. Тийм учраас энэ түншлэлийнхээ хуулийн үе шатуудыг нь бууруулах, шат дамжлагуудыг нь бууруулах, цаг хугацааг нь бууруулах өөрчлөлтүүдийг хийж байна. Энэ Түншлэлийн хууль 1 сарын 01-нээс хэрэгжинэ.

Энэ Түншлэлийн хууль батлагдсанаар аймаг, орон нутаг түншлэлийн төслөө хэрэгжүүлэх бололцоо бүрдэж байгаа. Одоогийн хуулиар төсвөөс татаас авдаггүй аймгууд, нийслэл хялбаршуулсан журмаар эрчим хүч, дулаан хангамж, хог хаягдал, гадаргын ус, саарал усны барилга байгууламж, цэвэр, бохир усны шугам

сүлжээ, цэвэрлэх байгууламж, хурдны зам, нийтийн тээвэр, тээвэр логиستيкийн салбар, хүнс хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, барилга байгууламж гэсэн 6 чиглэл, дээрээс нь 100 тэрбум төгрөгөөс доош төслүүдийг аймаг, нийслэлд хялбаршуулсан журмаар шийдэх бололцоо байсан. Үүнийг нь бид төсвөөс татаас авдгаас үл хамаараад аймаг, орон нутаг бие дааж хэрэгжүүлж болохыг энэ хуулиар хийж өгсөн учраас нутгийн өөрөө удирдах байгууллагууд түншлэлийн төслөө явуулах бололцоо бүрдэж байна.

Төсөлд тавигдаж байгаа шаардлагуудыгаа хялбаршуулсан. Төрийн үйлчилгээний төсөлд төслийн онцлогоос хамаараад ТЭЗҮ шаардахгүй болгож байна. Мөн төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийг эргэлтэд оруулах буюу төрийн өмчид хамаарч байгаа энэ шинжлэх ухааны хүрээлэнгүүд оюуны өмчөө эргэлтэд оруулсан тохиолдолд, гаднын хөрөнгө оруулалт оруулаад, түншлэлийн төсөл хэрэгжүүлбэл ирэх жил RND буюу судалгаа хөгжүүлэлтдээ зарцуулах бололцоо бүрдэж байна. Одоогийн хууль 8-аас үе шат, 8 үе шатыг дамждаг. Энэ хууль батлагдсанаараа 4 үе шаттай болж байна. 12, 13 сар болдог байсан бол энэ хууль батлагдсанаар 4, 5 сарын дотор түншлэлийн төсөл хэрэгжинэ.

Х.Булгантуяа: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Одоо улсын төсөв хэлэлцээд нэлээн чухал асуудал хэлэлцэж байгаа. Тэгээд дахиад нөгөө гишүүд маань байхгүй байх шиг байх юм. Булгантуяа дарга тэгээд өчигдрийнх шигээ энэ нэр усаар нь дахиад захаас нь авхуулаад дуудаад явбал зүгээргүй юу?

Би дахиад л Учрал сайдаас асууя. Нөгөө нэг мөнгө босгож оруулж ирэх төлөвлөгөө төсвийн ар талын хавсралт дээр дагалдах тогтоолын төсөл орж ирж байгаа. Тэр ер нь хэр бодитой вэ? Нөгөө нүүрсний үнэ маань нэлээн доошилчихсон байгаа. Тэгээд энэ урд хил дээр чинь нүүрс тээвэртэй холбоотой асуудал байна. Монголын 300 гаруй компани жийгдээд нүүрс тээвэрт явж чадахаа байчихсан, дандаа цаад талын Хятадуудын оролцоотой, Хятадын хөрөнгө оруулалттай, Хятадууд нүүрсийг нь авсан ийм тээвэр сүлжээ л нүүрс нь гарч байна гээд байна. Тэгэхээр энэ дотоодынхоо тээврийн компаниудын нүүрс гаргалт дээр яаж анхаарах юм бэ? Энэ талаар нэг хариулт өгөөч?

Х.Булгантуяа: Сангийн яамнаас 4 номерын микрофоноос нэмж хариулъя. Уул уурхайн яамнаас уу? Уул уурхайн яам яав? 3 номерын микрофон.

Г.Намчинсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдал 2, өнөөгийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалж байгаа бүтээгдэхүүний үнийг танд танилцуулъя. Коксжих нүүрс 96.4, сул коксжих нүүрс 73 доллар, эрчим хүчний нүүрс 37 доллароор борлуулагдаж байгаа. Бид Засгийн газрын зүгээс цаашид биржийн арилжааг идэвхжүүлэх замаар бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллана. Өнгөрсөн хугацаанд биржийн арилжаа идэвхэжсэнээр нүүрсний үнэ унаад байсан 6, оны эхнээс унаж байсан нүүрсний үнэ 6 сараас хойш биржийн арилжаа идэвхэжсэнээр нэмэгдэх, үнэ нь өсөх хандлага харагдаж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Хишигдэмбэрэлийн Тэмүүжин дарга. Тэмүүжин даргын микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Төсөвтэй холбоотой асуудлуудыг бид шийдүүлэхээр Байнгын хороод руу шилжүүллээ. Дагаж өргөн барьсан хуультай холбоотой асуудлыг хэлэлцэх гэж байна. Сая бүтэн 2 өдөр үргэлжилсэн чуулганы үйл явцаас болоод гишүүд яг энэ асуудал дээр төвлөрөх, хариулт өгөх ёстой сайдууд бага байгаатай холбоотойгоор, мөн ирэх нэг дэх өдрөөс ер нь төсөв болон энэ асуудлуудаар аль, аль намын бүлэг хариуцлагатай, шийдэмгий, хурдтай ажиллах шаардлага, хэрэгцээ байгаа учраас энэ хэлэлцэж байгаа асуудлаас түр завсарлага авч байна. 2 хоног.

Х.Булгантуяа: Тэмүүжин даргын микрофоныг нэмж өгье.

Х.Тэмүүжин: Завсарлагаа 3 хоногоор авъя.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.2-ийн дагуу 3 хоногийн завсарлагыг Ардчилсан намын бүлгийн дэд дарга Тэмүүжиний саналаар 3 хоногийн завсарлага өгч байна.

16.49 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар нийтдээ 6 асуудал хэлэлцэхээр байсан. Зургаадугаар асуудал дээр ийнхүү завсарлага авсан тул өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна. Та бүхэнд 20, бараг 30 цаг хуралдсан чуулганахаа хуралдаанд идэвхтэй оролцсон та бүхэндээ маш их баярлалаа.

16.50 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

